УДБҮ-ийн төслийн төмөр бетон угсралтын ажлыг туслан гүйцэтгэгч компаниудыг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлж байгаа ба бетон зуурмаг нийлүүлэх ажлыг “Айзава Монгол” ХХК болон “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж буй тул УДБҮ-ийн төслийн талбайд бетоны узель байгуулах, төслийн талбайд бетоны нэмэлт химийн бодис хадгалах зэрэг нөхцөл үүсээгүй болно.

Бетон цутгалтын ажлын туршид гүйцэтгэгч нь хөрсөнд үүсэж болзошгүй аливаа төрлийн асгаралтаас урьдчилан сэргийлж, гүйцэтгэгчийн “Хөрс хамгаалах төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажилласан.

№	Бетон зуурмаг нийлүүлсэн огноо	Бетон зуурмаг нийлүүлсэн компани	Бетон зуурмаг цутгасан байршил	Зориулалт	Бетон зуурмагийн тоо хэмжээ, м <sup>3</sup>
1	2023.07.06	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №1	Ул бетон (1-р үе)	30.0
2	2023.07.09	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №1	Ул бетон (2-р үе)	24.0
3	2023.07.20	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №1	Ул бетон (Pit)	4.0
4	2023.07.26	Премиум Бьюлдинг Материалс	Хөдөлгөөнт био-реактор	Ул бетон	17.0
5	2023.07.31	Айзава Монгол	Хөдөлгөөнт био-реактор	Ул бетон	240.0
6	2023.08.01	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №1	Суурийн бетон	258.0
7	2023.08.15	Айзава Монгол	Хөдөлгөөнт био-реактор	Суурийн бетон	24.0
8	2023.08.29	Айзава Монгол	Ламела тунгаагуур	Ул бетон	190.0
9	2023.09.01	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №2	Ул бетон (1-р үе)	29.0
10	2023.09.05	Айзава Монгол	Хөдөлгөөнт био-реактор	Суурийн бетон	642.5
11	2023.09.08	Айзава Монгол	Насос станц №2	Ул бетон (2-р үе)	30.0
12	2023.09.20	Премиум Бьюлдинг Материалс	Тогтворжуулах сан	Ул бетон (1-р үе)	28.0
13	2023.09.26	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №2	Суурийн бетон	420.0
14	2023.09.27	Айзава Монгол	Тогтворжуулах сан	Ул бетон (2-р үе)	30.0
15	2023.09.29	Премиум Бьюлдинг Материалс	Ламела тунгаагуур	Pit	20.0
16	2023.09.30	Премиум Бьюлдинг Материалс	Насос станц №1	Ханын бетон	130.0
17	2023.10.10	Айзава Монгол	Тогтворжуулах сан	Суурийн бетон	100.0
18	2023.10.18	Айзава Монгол	Тогтворжуулах сан	Суурийн бетон	403.0
19	2023.10.20	Айзава Монгол	Ламела тунгаагуур	Суурийн бетон	1124.0
				<b>Нийт</b>	<b>3,743.5 м<sup>3</sup></b>



**ХЭВ ХАШМАЛ УГСРАХ АЖИЛ**



**Насос Станц №1**



**Насос Станц №2**

**БЕТОН ЦУТГАЛТЫН АЖИЛ**




**Насос Станц №1**







**Хөдөлгөөнт био-реактор**



**Ламела тунгаагуур**






 <p>9/27/23 21:56 Ulaanbaatar, Songinokhairhan Wastewater tank facility Blinding Concrete second layer Slump-230mm</p>	
<b>Тогтворжуулах сан</b>	<b>Насос Станц №2</b>
<b>АРМАТУРЫН АЖИЛ</b>	
 <p>31 Aug 2023 at 19:10:43 Mongolia Ulan Bator</p>	 <p>25 Aug 2023 at 08:32:14</p>
<b>Насос Станц №1</b>	<b>Хөдөлгөөнт био-реактор</b>
 <p>Sep 28, 2023 10:11:48 AHS Kherid-20 Songinokhairhan Ulaanbaatar</p>	 <p>19 Sep 2023 10:05:00</p>
<b>Ламела тунгаагуур</b>	<b>Насос Станц №2</b>

## 2.2 2023 оны УДБҮ-ийн төслийн ажилласан хүн хүчний мэдээлэл

2023 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд ажилласан хүн хүчний төлөвлөлтийг доорх графикаар харуулав. 2023 оны 7 дугаар сараас эхлэн хүн хүч нэмэгдсээр тус оны 10 дугаар сард хамгийн их буюу 196 ажилтан төслийн талбайд ажилласан.





### 2.3 2023 онд УДБҮ-ийн төслийн барилгажилтын үе шатанд ашигласан техникүүд

2023 онд УДБҮ-ийн төслийн барилга угсралтын үе шатанд доорх хүснэгтэд харуулсан тоног төхөөрөмж, хүнд машин механизмуудыг ашигласан бөгөөд эдгээр тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг УДБҮ-ийн төслийн барилга угсралтын ажилбарууд дээр туслан гүйцэтгэгчээр сонгогдсон компаниуд хариуцан ажиллаж байна. Гүйцэтгэгч нь тухайн туслан гүйцэтгэгч бүрийн тоног төхөөрөмжийн техникийн бүрэн бүтэн байдалд төслийн талбайд нэвтрэхээс өмнө хяналт тавьж, хяналтын хуудсаар шалгаж баталгаажуулсны дараа төслийн талбайд нэвтрүүлдэг.

Хүснэгт 2-14: 2023 онд УДБҮ-ийн төслийн талбайд ашигласан тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Машин механизм	Марк, загвар	Ашигласан тоо хэмжээ
1	Авто кран	Zoom Lion	1
2	Ачааны машин	North Benz	1
3	Ачааны машин	Daewoo	1
4	Өрөмийн машин	Power-9000	1
5	Компрессор	Sullair 750	1
6	Экскаватор	Caterpillar 420D	1
7	Гагнуурын машин	Rivcen ZX7400	1
8	Авто кран	Daewoo	1
9	Экскаватор	Doosan DX380	1
10	Ковш	SD300N	1
11	Экскаватор	Doosan DX210W	1
12	Ачааны машин	HOWO336	6
13	Авто кран	Sany Truck Crane (25tn)	1
14	Индүү	Roller-YZ10J	1
15	Нягтруулагч машин	Masalta-MS90	1
16	Авто помп	DAEWODCP43-11	1
17	Бетон зуурмагийн тээвэрлэгч машин	HOWO-ZZ1257	18
<b>Хэсгийн дүн</b>			<b>39</b>

### 3. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

УДБУ-ийн төслийн 2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ажлын зардалд нийт 35,885,256₮ төсөвлөсөн бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 38,166,475₮-ийг зарцуулаад байна.

Гүйцэтгэгч нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.9-р заалтын дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50%-тай тэнцэх барьцаа мөнгийг 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн байгаль орчин нөхөн сэргээх баталгааны төрийн сангийн тусгай дансанд байршуулсан (ХАВСРАЛТ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ БАТАЛГААНЫ ТӨЛБӨРИЙН ШИЛЖҮҮЛГИЙН БАРИМТ).

*Хүснэгт 3-1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн зардлын задаргаа, 2023.10.23-ны байдлаар*

№	Зардлын төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсөв	15,423,696	4,572,880
2	Орчны тохижуулалт, цэцэрлэгжүүлэлтийн төсөв	-	-
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв	-	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	400,000	400,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төсөв	3,226,560	6,799,720
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв	16,435,000	25,993,875
7	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	-	-
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төсөв	400,000	400,000
	<b>Нийт</b>	<b>35,885,256</b>	<b>38,166,475</b>

*Хүснэгт 3-2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа, 2023.10.23-ны байдлаар*

№	Үйл ажиллагааны төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Газар	3,000,000	2,970,000
2	Уур амьсгал	-	0
3	Агаарын чанар	368,696	0
4	Гадаргын ус	-	0
5	Газрын доорх ус	1,260,000	750,880
6	Хөрсөн бүрхэвч	10,100,000	0
7	Дуу шуугиан	370,000	132,000

8	Үнэр	325,000	720,000
	<b>Нийт</b>	<b>15,423,696</b>	<b>4,572,880</b>

*Хүснэгт 3-3 Хяналт шинжилгээний үйл ажиллагааны төсвийн задаргаа, 2023.10.23-ны байдлаар*

№	Үйл ажиллагааны төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Агаарын чанар	14,400,000	22,925,775
2	Дуу шуугиан	-	-
3	Усны чанар	1,000,000	1,245,000
4	Хөрсний чанар	1,035,000	836,100
5	Бохир усны чанар	-	987,000
	<b>Нийт</b>	<b>16,435,000</b>	<b>25,993,875</b>

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### 4.1 Байгаль орчны мэдлэг олгох үйл ажиллагаа

М-Си-Эс Проперти ХХК нь байгаль орчны бодлогын хүрээнд нийт ажилчдын байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг хангах үүднээс мэдлэг олгох үйл ажиллагааг төслийн талбайд 4.1.1-р хэсгээс 4.1.4-ээр хэсэгт дурьдсан арга хэмжээнүүдээр дамжуулан нийт ажилчдад тогтмол зохион байгуулж байна.

##### 4.1.1 Төслийн урьдчилсан зааварчилгаа

УДБҮ-ийн төслийн талбайд нэвтэрч ажил гүйцэтгэх ажилтан бүр төслийн талбайд аливаа ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө гүйцэтгэгч талаас олгох төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад зайлшгүй хамрагдсан байх шаардлагатай байдаг. Энэхүү сургалтад төслийн талбай дах гүний худгийн эрүүл ахуйн бүс, төслийн талбайд нийт ажилчдын дагаж мөрдөж, хэвшүүлэх шаардлагатай “Ногоон дүрэм”, хог хаягдлаа ангилан хаях заавар, асгаралтаас сэргийлэх арга хэмжээ, асгаралт шингээгч иж бүрдэл ашиглах заавар болон соёлын өвийн олдвор илрүүлсэн тохиолдолд авах арга хэмжээ зэргийн талаар тусгасан байдаг.

Тайлант хугацаанд нийтдээ 618 шинэ ажилтан 112 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан байгаль орчны мэдлэг олгох сургалтад хамрагдсан байна. Доорх хүснэгтэд төслийн талбайд зохион байгуулагдсан урьдчилсан зааварчилгааны тоон мэдээллийг үзүүлсэн ба Зураг 4-1 болон Зураг 4-2-д урьдчилсан зааварчилгааны сургалтын материалын байгаль орчны хэсэг болон сургалт зохион байгуулж байх үеийн баримтжуулсан мэдээллийг тус тус харуулав.

*Хүснэгт 4-1: УДБҮ-ийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтын мэдээлэл, 2023 оны 10-р сарын 23-ны өдрийн байдлаар*

	2023 оны үзүүлэлт	Төслийн нийт үзүүлэлт
Урьдчилсан зааварчилгаа олгосон давтамж	112	166
Урьдчилсан зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	618	792

Зураг 4-1: УДБУ-ийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтын агуулгын жишээ

WRP PROJECT MCSproperty

Байгаль Орчин

43

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Бид байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар бууруулна

- Нийцлийг хангах
- Мэдэг, ойлголт олгох
- Ажлын байрны уулз, шалгалт хийх
- Орчны хяналт, шалгалтууд
- Хог хаягдлын менежмент
- Химийн бодисын менежмент
- Усны менежмент
- Агаарын чанар, дуу чимээний менежмент

43

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Төслийн талбайд байрлах гүний худаг 80 метрийн радиуст гүний худгийн эрүүл ахуйн бүс байрлана.

ЭРҮҮЛ АХУЙН БҮСЭД ХОМГОЛОХ ЗҮЙЛС:

- Хог хаягдал болон бохирдуулах бодис хаях
- Машин техник угаах
- Газрын тосны буцалдууруу, хөмийн бодис хадгалах, ашиглах

43

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Бид байгаль орчны нөдөлгийг нэмэгдүүлэх зорилгоор "Ногоон дүрэм"-ийг хэрэглэж байна.

- Эрүүл ахуйн хамгаалт
- Шалгалт хийх
- Усны хэмжээг бууруулах
- Хог хаягдлыг бууруулах

43

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Бид аливаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хажуу, дахин ашиглах болон дахин боловсруулдаг.

Хөгжлийн хөгжлийн байршил

- Барилгын хөгжил - Үндсэн барилгын хэргийн хувиар
- Хөгжлийн хөгжил - Гидрологийн тус орчинд оруулах

Барилгын хөгжлийн ангилал

- Мяг
- Төмөр
- Аюултай хаягдал
- Бусад дахин боловсруулах боломжтой хаягдал
- Барилгын хаягдал

Аюулгүй хөгжлийн ангилал

- Хүлээвэр, хийн
- Шавь
- Хөвдөл хуруу зай
- Бусад дахин боловсруулах боломжтой хаягдал
- Боловсруулах боломжгүй ахуйн хаягдал

Сэргийлэх/Бууруулах

Дахин боловсруулах

Устгах

Least Preferred

47

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Бид оффисын орчинд хог хаягдлыг 3 төрөлд ангилан хаядаг.

- LANDFILL
- RECYCLE
- RECYCLE

48

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Химийн бодис, бараа материал болон бүх төрлийн хог хаягдлыг тохиромжит агуулах савд хадгална.

Асгаралтаас урьдчилан сэргийлэх

- Хаягдал тос хэсгийг ил задгай агуулахгүй байх
- Химийн бодис, бараа материалын татгийг онгорхой оруулахгүй байх
- Техникийн задрал бүхий тонийг төвөррөхийн төслийн талбайд агуулахгүй байх

Асгаралтын ик бүрдлийн байршил

- Химийн бодисын агуулах
- Аюултай хог хаягдлын цэг
- Барилга урсгалын талбай
- Шаврагалагтай өндөр эрсдэл бүхий байршил

49

WRP төслийн байгаль орчны зааварчилгаа

Асгаралт шингээгч ик бүрдэл ашиглах заавар

- ХАНГААЛ**  
Асгаралттай харьцангуй өмнө шаардлагатай хувийн хангаалах хэрэгсэл (нүдний шил, маск, бээлий) -ийг бүрэн өмсөж байх
- ТУСГААРЛА**  
Асгаралт шингээгчийг тойруулан асгаралтыг хязгаарлагч хөвөө тавьж тусгаарлах
- АН**  
Асгаралт шингээгч алчуур, уртас зэргийг ашиглах, асгаралт шингээгчийг шингээх, арванг алах
- ХАЯ**  
Хэрэглэсэн асгаралт шингээгч алчуур, уртас, хязгаарлагч хөвөө зэргийг хойно ууганд хийх ба утны амыг сайтар боож, төслийн талбайн аюултай хог хаягдлын цэгт хаях

51

Зураг 4-2: Урьдчилсан зааварчилгаанд хамрагдаж буй байдлыг баримтжүүлсан мэдээлэл







Сургалтын үзэр / Training unit		Хөгжсөн ажилтан хамрагдсан сургалт			
Альба Тосол / Sharynbold P. / Trainer	WFP төсөл / Project	Огноо / Date	2022.12.19		
Хувиараа / Participant	Элчин / Trainer	Дугаар / Training no.			
Суралцагч / Trainee	Н.Ариун / Trainer	Хаварцагч / Trainer	Ү/а		
Сургалтын мэдээлэл / Training details	Төслийн гүйцэтгэл хөгжсөн үйл ажиллагааны төлөвлөгөөг ба мэдээллийг өгөх / Provide background and information on project tasks / description of the WFP project etc.				
Орлог / Outcome	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ба мэдээллийг өгөх / Provide background and information on project tasks / description of the WFP project etc.				
№	Огноо / Date	Компанийн үзэр / Company name	Ажил тусал / Position	Утасны дугаар / Phone number	Гарын үсэг / Signature
1	О.Ариун	WFP	Compl. Sp	78009874	[Signature]
2	Б.Ариун	WFP	SV	89101079	[Signature]
3	У.Ариун	WFP	Trainer	9812345	[Signature]
4	Ц.Ариун	WFP	Engineer	88100894	[Signature]
5	О.Ариун	WFP	Trainer	88100894	[Signature]
6	NERGO	WFP	Engineer	9611797	[Signature]
7	А.Ариун	WFP	Trainer	89130659	[Signature]
8	Bayantsaykh Ch	WFP	Trainer	88876144	[Signature]
9	Adiya P.	WFP	Officer Inspector	9803043	[Signature]
10	Ригорина Т	WFP	DC	8077000	[Signature]
11	Galtmaa B	WFP	Trainer	8912046	[Signature]
12	Бадмаев А.А.А	WFP	Trainer	88106556	[Signature]

Сургалтын гарын үсэг / Trainer's signature: Н.Ариун

Сургалтын үзэр / Training unit		Ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг ба мэдээллийг өгөх / Provide background and information on project tasks / description of the WFP project etc.			
Альба Тосол / Sharynbold P. / Trainer	WFP төсөл / Project	Огноо / Date	2022.06.29		
Хувиараа / Participant	Элчин / Trainer	Дугаар / Training no.			
Суралцагч / Trainee	Н.Ариун / Trainer	Хаварцагч / Trainer	Ү/а		
Сургалтын мэдээлэл / Training details	Төслийн гүйцэтгэл хөгжсөн үйл ажиллагааны төлөвлөгөөг ба мэдээллийг өгөх / Provide background and information on project tasks / description of the WFP project etc.				
Орлог / Outcome	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ба мэдээллийг өгөх / Provide background and information on project tasks / description of the WFP project etc.				
№	Огноо / Date	Компанийн үзэр / Company name	Ажил тусал / Position	Утасны дугаар / Phone number	Гарын үсэг / Signature
1	А.Ариун	MSP-3A	Trainer		[Signature]
2	Б.Ариун	Б.Ариун	Trainer	55051711	[Signature]
3	Б.Ариун	Б.Ариун	Trainer	95797183	[Signature]
4	А.Ариун	Б.Ариун	Trainer	91286757	[Signature]
5	Б.Ариун	MSP	Trainer	80106067	[Signature]
6	Б.Ариун	BMS	Trainer	85759126	[Signature]
7	П.Б.Ариун	MSP	Trainer	86957974	[Signature]
8	П.Ариун	Б.Ариун	Trainer	88792828	[Signature]
9	А.Ариун	Б.Ариун	Trainer	86822416	[Signature]
10	Б.Ариун	BMS	Trainer	88555166	[Signature]
11	А.Ариун	BMS	Trainer	94603814	[Signature]
12	А.Ариун	BMS	Trainer	91655558	[Signature]
13					
14					

Сургалтын гарын үсэг / Trainer's signature: Н.Ариун

### 4.1.3 Давтан зааварчилгааны сургалт

УДБУ-ийн төслийн талбайн урьдчилсан зааварчилгаанд хамрагдсанаас хойш 6 сарын дараа тухайн ажилтны төслийн талбай дах хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, нийгэм жэндэрийн шаардлагуудтай холбоотой мэдлэгийг нь сэргээх, дахин сануулах зорилгоор давтан зааварчилгааны сургалтыг зохион байгуулдаг. Байгаль орчны давтан зааварчилгааны сургалт нь жил бүрийн 5 дугаар сар болон 11 дүгээр саруудад зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байдаг бөгөөд 2023 оны 9-р сарын 25-ны өдрийн байдлаар нийт 36 ажилтан тус сургалтад хамрагдаж байгаль орчны мэдлэгээ сэргээсэн байна. Төслийн гүйцэтгэгч нь 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр дараагийн байгаль орчны давтан зааварчилгааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Зураг 4-4: Байгаль орчны давтан зааварчилгааны сургалтад хамрагдаж буй байдлыг баримтжуулсан мэдээлэл











#### 4.2.2 Химийн бодисын агуулахын үзлэг, шалгалт

УДБҮ-ийн төслийн талбайд барилга угсралтын үе шатанд ашиглах химийн бодисын бараа материал хадгалахад зориулсан химийн бодисын түр агуулах байрладаг. Төслийн гүйцэтгэгч нь 40 тонн бүхий контейнер ашиглан MNS 6458:2014<sup>3</sup> стандартын шаардлагад нийцүүлэн тоногдсон бөгөөд Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсийн улсын байцаагч нарт шалгуулсны үндсэн дээр химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад дотоод хяналтаа хэрэгжүүлж ашиглах зөвшөөрлийг авсан. Иймд, төслийн гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь химийн бодисын агуулахын үзлэгийг захиалагчийн байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран сард тутамд хийж гүйцэтгэж байна. Химийн бодисын агуулахын үзлэг, шалгалтын дотоод хяналтын тайланг **ХАВСРАЛТ 4. УДБҮ-ИЙН ТӨСЛИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН** хэсгээс харна уу.

#### 4.2.3 Асгаралт шингээгч иж бүрдлийн үзлэг, шалгалт

УДБҮ-ийн төслийн талбайд химийн бодис, хүнд машин механизмаас шатах тослох материалын асгаралт хөрсөнд үүссэн тохиолдолд ашиглах асгаралт шингээгч иж бүрдлийг өндөр эрсдэл бүхий дөрвөн байршилд байршуулсан байдаг. Үүнд дараах байршлууд орно:

- Насос станц №1 байгууламжийн баруун талд
- Химийн бодисын агуулахын хажууд
- Аюултай хог хаягдлын цэгийн хажууд
- Төслийн талбайд байрших генераторын хашаанд

Хөрсөнд аливаа төрлийн асгаралт үүссэн тохиолдолд эдгээр асгаралт шингээгч иж бүрдлийн бэлэн байдал чухал ач холбогдолтой бөгөөд тухайн асгаралт нь хөрсний гүнд нэвчихээс сэргийлэх боломжтой юм. Иймд, төслийн гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь асгаралт шингээгч иж бүрдлийн бэлэн байдлыг шалгах болон хангах зорилгоор сар бүр тогтмол шалгах хуудсын дагуу үзлэг, шалгалтыг гүйцэтгэн ажилладаг. 2023 оны 9-р сард гүйцэтгэсэн асгаралт шингээгч иж бүрдлийн шалгах хуудсыг доорх зурагт харуулав.

Зураг 4-7: УДБҮ-ийн төслийн сар бүрийн асгаралт шингээгч иж бүрдлийн үзлэг, 2023.09.18

Төслийн нэр / Project Name: Ус дахин боловсруулах үйлдвэрийн төсөл / Wastewater Recycling Plant Project									
Шалгасан огноо / Inspection Date: 2023.09.18									
Асгаралт шингээгчийн бэлэн байдал Spill Kit Readiness	Spill Kit #1 Y/N		Spill Kit #2 Y/N		Spill Kit #3 Y/N		Spill Kit #4 Y/N		Тайлбар / Notes (if applicable)
Асгаралт шингээгчийн сав нь цэвэрхэн, эвдэрч гэмтээгүй Is the container clean and free of damage?	✓		✓		✓		✓		Spill kit # 1: Near chemical storage Spill kit #2: Near P51 Spill kit #3: Near hazardous waste storage Spill kit #4: Near generator
Асгаралтын иж бүрдэл нь хаягтай, харагдахуйц ил гээгэр байршсан Is the spill kit clearly marked, visible, and unobstructed?	✓		✓		✓		✓		
Асгаралтын иж бүрдлийг хуурай гээгэр эсвэл цаг агаарт тэсвэртэй саванд хадгалсан Is the kit stored in a dry location or in weather resistance container?	✓		✓		✓		✓		
Асгаралт шингээгчийн бүрэн бүтэн байдал Spill Kit Contents	Spill Kit #1 Y/N		Spill Kit #2 Y/N		Spill Kit #3 Y/N		Spill Kit #4 Y/N		Тайлбар / Notes (if applicable)
Тос хэмжээ Quantity	Тогт	Нэмэх, солих Restock, Replace?	Тогт	Нэмэх, солих Restock, Replace?	Тос хэмжээ Quantity	Тогт	Нэмэх, солих Restock, Replace?	Тос хэмжээ Quantity	Нэмэх, солих Restock, Replace?
Ашиглах заавар / Instructions for use	1		1		1		1		
Асгаралт шингээгч үргэс / Spill absorbent sawdust	3		3		3		3		
Асгаралт хязгаарлагч хөвөө / Spill absorbent sock	4+1		2		4+1		4+1		
Асгаралт шингээгч алнуур / Spill absorbent pads	14+1		17		40+1		55+1		
Үртэс ханах шүүр / Vroom	1		0		1		1		
Үртэс ханах тосгуур / Dustpan	1		0		1		1		
Хогийн уут / Disposal bags	5		6		10		8		
Гар хангаалах бээлий / Hand protection	2		1		2		2		
Бусад / Specify others	0		0		0		0		
Шаардлагатай арга хэмжээ Specify Any Necessary Corrective Actions:									
Шалгасан ажилтны нэр, албан тушаал / Name of Inspector and Position: <i>M. Javkhlan (Environmental Officer)</i>									
Гарын үсэг / Signature: <i>M. Javkhlan</i>									

<sup>3</sup> MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага



хугацаанд УДБҮ-ийн төслийн талбайд нийт 3 үл тохирол илэрсэн бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар тухайн үл тохирлуудыг бүрэн хааж, арга хэмжээ авсан байна. Нийт илэрсэн үл тохирлуудыг ангилалаар нь авч үзвэл:

- Төслийн талбайд үүссэн хүнд машин механизмын тос маслын асгаралттай холбоотой 2 үл тохирол
- Шавхаж буй хөрсний усны чанартай холбоотой 1 үл тохирол

тус тус бүртгэгдсэн байна. Дээрх үл тохирлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 4-2-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 4-2: УДБҮ-ийн төслийн хүрээнд бүртгэгдсэн үл тохирлуудыг залруулсан байдал

№	Илэрсэн үл тохирлын мэдээлэл	Үл тохирол илэрсэн огноо	Үл тохирлыг арилгасан байдал	Үл тохирлыг хаасан огноо
1	 <p>Ламелла тунгаагуур барилгын ойролцоо техникийн тос маслоор бохирдсан хог хаягдлыг зориулалтын бус газар байршуулсны улмаас хөрсөнд техникийн тосны асгаралт үүссэн.</p>	2023.06.19	 <p>Тухайн үл тохирлыг үүсгэсэн туслан гүйцэтгэгчид химийн бодисын аливаа төрлийн хог хаягдлыг “Аюултай хог хаягдлын цэг”-т хаяж байх тухай давтан заавар, зөвлөгөө өгсөн ба хөрсөнд үүссэн техникийн тосны асгаралтыг хуулж, цэвэрлүүлэн, бохирдсон хөрсийг шуудайнд цуглуулж, аюултай хог хаягдлын цэгт хаясан.</p>	2023.06.20
2	 <p>Төслийн талбайд ухлагын ажил гүйцэтгэж байсан хүнд машин механизмаас хөрсөнд тос маслын асгаралт үүссэн.</p>	2023.08.16	 <p>Тухайн үл тохирлыг үүсгэсэн туслан гүйцэтгэгчид техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах талаар давтан заавар, зөвлөгөө өгсөн ба хөрсөнд үүссэн техникийн тосны асгаралтыг хуулж, цэвэрлүүлэн, бохирдсон</p>	2023.08.16



			хөрсийг шуудайнд цуглуулж, аюултай хог хаягдлын цэгт хаясан.	
3	2023 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэсэн хөрсний усны шинжилгээнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мл-т илэрсэн.	2023.07.03	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу.	2023.07.21

Төслийн гүйцэтгэгч нь барилгын суурийн ус шавхан зайлуулах ажлыг гүйцэтгэх хугацаанд сар бүр шавхаж буй хөрсний уснаас дээж авч, MNS 4943:2015<sup>4</sup> стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг шалгадаг бөгөөд 2023 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэсэн хөрсний усны шинжилгээнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мл-т илэрсэн. Тус шинжилгээний хариу хүлээж авсан даруй төслийн гүйцэтгэгч нь төслийн захиалагчаас “Талбайн зааварчилгаа 010”-г 2023 оны 7-р сарын 6-ны өдөр хүлээж авсан бөгөөд тус зааварчилгааны дагуу холбогдох хариу арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлсэн. Шавхаж буй хөрсний усны чанарыг дахин нягталж баталгаажуулах үүднээс төслийн гүйцэтгэгч нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Төслийн талбайн 3 цэг (Ундны усны танк, гүний худаг, шавхаж буй хөрсний ус)-ээс төслийн талбайн усны чанарыг баталгаажуулах зорилгоор дахин усны дээж авсан бөгөөд шинжилгээний хариу нь холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангаж байв.
- Төслийн гүйцэтгэгч нь гүний худаг болон талбайн усалгааны системд “Ундны ус биш тул уухыг хориглоно” тэмдгүүдийг байршуулж, төслийн ажил эхлэхийн өмнөх хурлаар нийт ажилтнуудад мэдээлэл хүргэсэн.
- УДБҮ-ийн төслийн талбайн усалгааны системийг барилгын суурийн шавхаж буй хөрсний усаар хангадаг тул хөрсний усны чанарыг дахин баталгаажуулах хүртэл усалгааны системийг түр зогсоож, төслийн талбайн усалгааг усалгааны машин ашиглаж, хийж гүйцэтгэсэн.
- Төслийн талбайд байрлах 2 ш усны танкийг улирал тутамд мэргэжлийн байгууллагаар ариутгаж, халдваргүйжүүлдэг байсныг сард 1 удаа болгож давтамжийг нэмэгдүүлсэн.

#### **4.4 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

Энэхүү тайлангийн 2.1.1-р бүлэгт дурдсаны дагуу 2023 онд УДБҮ-ийн үндсэн барилгажилттай холбоотойгоор барилгын суурийн ухлагын ажлыг 2023.05.18 – 2023.09.19-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн ба нийт 46,024.15 м<sup>3</sup> ухлагын ажил хийгдсэн.

Төслийн барилгын ажлын үед ашиглах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шатах тослох материалын асгаралт үүсэж газрын гадарга, хэвлийг бохирдуулах болон дээрх газар шорооны ажлаас үүссэн шороог зөвшөөрөлгүй газар асгаснаас газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэхээс сэргийлж гүйцэтгэгч нь дараах 13 бүлэг ажлыг төслийн талбайд хэрэгжүүлэн ажилласан.

Төслийн гүйцэтгэгч нь тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна (Хүснэгт 4-3).

<sup>4</sup> MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	УДБҮ барих 1.5 га талбайн газрын гадарга дахин эвдэгдэх	Гүйцэтгэгч нь төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулж ажиллах ба төслийн талбайд тээврийн хэрэгслийг зөвхөн заагдсан зорчих хэсгээр зорчуулах ба олон салаа зам үүсгэхээс сэргийлж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгч нь төсөл хэрэгжих нийт хугацаанд хэрэгжүүлэх “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-г захиалагчаар батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн, УДБҮ-ийн төслийн талбайд барилга угсралтын ажлын хугацаанд ашиглах түр замыг төлөвлөж, талбайн зохион байгуулалтын зурагт тусгасан бөгөөд машин механизм болон явган хүн зорчих замуудыг хатуу хаалт хашилтаар тусгаарлан, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. Барилгын суурийн ухлагын ажлын үед үүссэн ухлагын шороог ШТЦБ-ийн талбайруу зөөж, тээвэрлэхдээ гүйцэтгэгч нь ШТЦБ-аас зөвшөөрсөн тээврийн хэрэгслийн замыг ашигласан бөгөөд шинээр салаа зам үүсгэх нөхцөл үүсээгүй болно.	Төслийн талбайд аливаа тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмыг зөвхөн заагдсан зорчих хэсгээр зорчуулахад ашиглах тэмдэг тэмдэглэгээ, хатуу хаалт хашилт зэргийн холбогдох зардал нь төслийн ХАБЭА-н зардалд багтана.
2	УДБҮ барих үйл ажиллагаанаас 51,090.8 м <sup>3</sup> газрын хэвлий эвдэгдэх	УДБҮ-ийн төслийн газар шорооны ажилд зориулж боловсруулсан аргачлалын хэрэгжилтийг хангуулж, ажиллах. Энэхүү аргачлал нь ухлагын шороог	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Гүйцэтгэгчийн барилга угсралтын баг нь газар шорооны ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө “Газар шорооны ажил гүйцэтгэх ажлын аргачлал”-ийг боловсруулж, захиалагчаар батлуулсан ба тус аргачлалд тусгагдсан байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн	Төслийн газар шорооны ажилд зориулсан аргачлалыг гүйцэтгэгчийн барилга угсралтын баг боловсруулсан ба байгаль орчны

		хадгалах байршил, ухлагын ажлыг гүйцэтгэх аргачлал болон хэрэгжүүлэх байгаль орчны хяналт зэргийг тусгасан байх.			хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан.	хяналтыг гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан гүйцэтгэсэн тул зардал гараагүй.
3		Газар шорооны ажлын үе шатанд барилгын суурь бэлтгэхэд ухаж гаргасан хөрс чулуулгийг зөвшөөрөгдсөн талбайд хадгалах.	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	УДБҮ-ийн төслийн үндсэн барилга байгууламжийн суурийн ухлагаас гарсан шороог доорх 2 цэгт хадгалсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• УДБҮ-ийн төслийн талбайн баруун урд хэсэгт</li> <li>• УСУГ-ын эзэмшил газар болох ШТЦБ-ийн төслийн талбайн урд байрлах илүүдэл шороо хураасан талбайн зүүн талд</li> </ul> тус тус зөөж, хадгалсан. Тус 2 байршилд барилгын суурийн ухлагаас гарсан шороог зөөж, тээвэрлэх ажил гүйцэтгэхээс өмнө НБОГ-т мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг авсан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.1.1-р бүлгийн “Газар шорооны ажил” хэсгээс танилцана уу.	Барилгын суурийн ухлагаас гарсан шороог зөөж, тээвэрлэх ажил нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
4		Газар шорооны ажлаас ухаж гаргасан хөрс чулуулгийн 26.5%-ийг УДБҮ-ийн барилгын суурийн буцаан дүүргэлтэд эргүүлэх ашиглах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	УДБҮ-ийн төслийн барилга угсралтын ажлын явцтай холбоотой 2023 онд үндсэн барилга байгууламжийн суурийн буцаан дүүргэлтийн ажил хийгдээгүй ба 2024 онд тус ажил нь хэрэгжихээр хойшилсон болно. Иймд, тайлант хугацаанд барилгын суурийн ухлагаас гарсан шорооны 2.9%-ийг суурийн нягтруулгын ажилд ашигласан бөгөөд илүүдэл шороог 2024 онд барилгын суурийн буцаан дүүргэлтэд эргүүлэн ашиглахаар дээрх 2 байршилд түр хадгалж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.1.1-р бүлгийн “Газар шорооны ажил” хэсгээс танилцана уу.	Барилгын суурийн буцаан дүүргэлтийн ажил явагдаагүй тул зардал гараагүй.

5		УДБҮ-ийн барилгын суурийн буцаан дүүргэлтээс үлдсэн ухлагын шороог “Шинэ төв цэвэрлэх байгууламж”-ийн барилгын буцаан дүүргэлтэд ашиг олох зорилгогүйгээр ашиглуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Тайлант хугацаанд УДБҮ-ийн үндсэн барилга байгууламжуудын суурийн буцаан дүүргэлтийн ажил явагдаагүй тул илүүдэл шороог 3-р хэсэгт дурдсан 2 байршилд түр хадгалж байна. УДБҮ-ийн гүйцэтгэгч нь үндсэн барилга байгууламжуудын суурийн буцаан дүүргэлтийн ажлаас илүү гарсан шороог ШТЦБ-ийн барилгын буцаан дүүргэлтийн ажилд ашиг олох зорилгогүйгээр ашиглуулах тул энэхүү ажил нь мөн 2024 онд хэрэгжихээр хойшилсон болно.	Барилгын суурийн буцаан дүүргэлтийн ажил явагдаагүй тул зардал гараагүй.
6	Газар шорооны ажлаас үүссэн шороог зөвшөөрөлгүй газар асгаснаас газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Төслийн талбайд ухлагын ажил эхлэхээс өмнө НБОГ-аас “Газар шорооны ажлын үед үүссэн ухлагын шороог зайлуулах зөвшөөрөл” авсан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь үндсэн барилга байгууламжийн барилгын суурийн ухлагын ажил эхлэхээс өмнө буюу 2023 оны 5-р сарын 11-ний өдөр НБОГ-аас холбогдох зөвшөөрлийг авсан ба дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 10-р бүлгээс харна уу.	НБОГ-т албан бичиг хүргүүлж, холбогдох зөвшөөрлийг авсан тул зардал гараагүй.
7		НБОГ-аас олгосон зөвшөөрлийн дагуу холбогдох шаардлагуудыг биелүүлж ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	НБОГ-аас төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг мөрдлөг болгож ажиллахыг даалгасан. Иймд, гүйцэтгэгч нь барилгын ажлын үе шатанд барилгын суурь бэлтгэхэд ухаж гаргасан хөрс чулуулгийг зөвшөөрөгдсөн 2 байршилд түр хадгалж байгаа бөгөөд 2024 онд барилгын суурийн буцаан дүүргэлтэд эргүүлэн ашиглахаар төлөвлөж байна.	-
8	Барилгын ажилд ашиглах	Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь төслийн хугацаанд хэрэгжүүлэх “Гүйцэтгэгчийн байгаль орчин,	Гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн

	тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шатах тослох материал, хөргүүрийн шингэн асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулах	хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх			нийгмийн менежментийн төлөвлөгөө (ГБОНМТ)-г боловсруулж, 2023 оны 4-р сарын 3-ны өдөр захиалагчаар батлуулсан ба хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөө нь 12 төрлийн дэд төлөвлөгөөнүүдээс бүрддэг ба үүний 6 нь байгаль орчны дэд төлөвлөгөө юм. “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө” нь эдгээр төлөвлөгөөний нэг бөгөөд асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед хэрэгжүүлэх арга хэмжээг агуулсан байдаг.	менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэгчийн байгаль орчны баг болон нийгэм, жендэрийн оролцооны баг хамтран боловсруулсан тул зардал гараагүй.
9		Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн байдал (гидр хоолой, гидравлик хөдөлгүүр, гидр банк хөлрөөгүй, тос масло асгаралтгүй, эвдрэлгүй байх)-ыг төслийн талбайд нэвтрэхийн өмнө шалгаж, баталгаажуулах	УДБҮ-ийн төслийн барилгын ажилд ашиглах нийт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.4-р бүлгээс харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудасны дагуу шалгадаг тул зардал гараагүй.
10		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад төслийн урьдчилсан зааварчилгаагаар	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед авах арга хэмжээ болон асгаралт шингээгч иж бүрдлийг ашиглах заавар зэрэг тусгагдсан байдаг ба нийт	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.



		дамжуулан олгосон байх			ажилтнуудад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1.1-р бүлгээс танилцана уу.	
11		Асгаралт шингээгч иж бүрдлийг төслийн талбайд байршуулсан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Тайлант хугацаанд нэмэлтээр 3 ширхэг асгаралт шингээгч иж бүрдлийг УДБҮ-ийн төслийн талбайд байршуулснаар дараах 4 байршилд асгаралт шингээгч иж бүрдэл байршиж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Насос станц №1 байгууламжийн баруун талд</li> <li>• Химийн бодисын агуулахын хажууд</li> <li>• Аюултай хог хаягдлын цэгийн хажууд</li> <li>• Төслийн талбайд байрших генераторын хашаанд</li> </ul> Төслийн гүйцэтгэгч нь асгаралт шингээгч иж бүрдлийн бэлэн байдлыг шалгах болон хангах зорилгоор сар бүр тогтмол асгаралт шингээгч иж бүрдлийн үзлэг, шалгалтыг гүйцэтгэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.3-р бүлгээс харна уу.	2,970,000 (3 ш * 990,000₮)
12	Барилга барихад ашиглагдаж байгаа барилгын материалын хаягдал, тайрдас зэргийн менежментийг хангалтгүй хийснээр газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулж ажиллах (Бүлэг 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө хэсэгт дэлгэрэнгүй тусгав)	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө” нь ГБОНМТ-ний нэг дэд төлөвлөгөө бөгөөд төслийн гүйцэтгэгч нь тус төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хангуулан ажиллаж байна. УДБҮ-ийн төслийн талбайд ахуйн болон барилга угсралтын хог хаягдлын 2 тустай ангилан ялгалтын цэг байрладаг бөгөөд бид нийт 8 төрөлд хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах болон дахин боловсруулах боломжийг нэмэгдүүлэн ажилладаг. Мөн гүйцэтгэгч нь төслийн талбайн хогийн цэгт цугларсан хог хаягдлыг тухай бүр төвлөрсөн хогийн	Энэхүү үйл ажиллагаатай холбогдох зардал нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.

					цэгрүү тээвэрлэх ажил үйлчилгээний гэрээг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй байгуулсан бөгөөд хог хаягдлын бүртгэлийг баримтжуулж хадгалдаг. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 8-р бүлгээс танилцана уу.	
13		Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлсэн байх ба газрын гадарга, хэвлийд нөлөөлөх үл тохирол илэрсэн тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлдэг. Хэрэв үзлэг, хяналтын үеэр байгаль орчны үл тохирол илрүүлсэн тохиолдолд тухай бүрт баримтжуулж, холбогдох талд залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2 болон 4.3-р бүлгээс танилцана уу.	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй.
					<b>Нийт</b>	<b>2,970,000</b>

#### 4.5 Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2023 онд УДБҮ-ийн төслийн барилга угсралтын үйл ажиллагааны хүрээнд энэхүү тайлангийн 2.3-р бүлэгт нэгтгэн харуулсан машин, механизмуудыг ашигласан. Иймд, тус машин, механизмуудын түлшний шаталтаас нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>) ялгарч агаар мандал дах хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлж болзошгүй тул уг болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 4 бүлэг ажлыг тайлант хугацаанд тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-4: Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	УДБҮ-ийг барихад ашиглах тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталтаас CO <sub>2</sub> ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Техникийн улсын үзлэг, оношилгоонд бүрэн хамрагдсан (хөдөлгүүрийн утаа, түүний найрлага дах хорт бодис, тортогжилтын хэмжээ нь MNS 5013, MNS 5014 стандартад тогтоосон хэмжээнээс хэтрээгүй) тээврийн хэрэгслүүдийг төслийн талбайд ашиглах	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна.  Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.4-р бүлгээс харна уу.	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийг түрээслэх буюу туслан гүйцэтгэгчээс нийлүүлэх тул техникийн улсын үзлэг, оношилгоонд хамруулах нь туслан гүйцэтгэгч компанийн үүрэг байна. Мөн төслийн талбайд нэвтрэхийн өмнөх үзлэгийг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэдэг тул зардал гараагүй.

2	Тээврийн хэрэгслийг зогсоолд байрлуулахдаа хөдөлгүүрийг заавал унтраасан байх	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
3	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
4	Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглахыг шаардах ба тус стандартын шатахуун худалдан авсан тухай баримт мэдээллийг гүйцэтгэгчид хүргүүлж байх зохицуулалтыг хийх (Энэхүү шаардлага нь дизель түлш ашигладаг тээврийн хэрэгсэлд хамаарахгүй болно)	УДБҮ-ийн төслийн талбайн холбогдох тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ашиглаж буй гүйцэтгэгчийн өмчийн тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглаж байна. Төслийн үндсэн барилгын явцад ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компаниудын ажил үйлчилгээний гэрээнд холбогдох шаардлагыг тусган оруулсан бөгөөд шатахуун худалдан авсан тухай баримтжуулсан мэдээллийг хүлээн авч, хадгалж байна.  Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.5-р бүлгээс харна уу.	Гүйцэтгэгчийн тээврийн хэрэгсэлд хамаарах шатахууны зардал нь гүйцэтгэгчийн төслийн үйл ажиллагааны зардалд багтана. Туслан гүйцэтгэгчийн холбогдох тээврийн хэрэгслүүдэд тавигдах шаардлагыг ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой тусгаж оруулсан тул зардал гараагүй.
				<b>Нийт</b>	-



#### 4.6 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгаснаар агаарын чанарт нөлөөлөх үндсэн эх үүсвэр нь төслийн талбайд ашиглагдах машин, техникүүд байх ба машин, техникүүдийн хөдөлгөөнөөс тоосонцор (PM<sub>2.5</sub> болон PM<sub>10</sub>), хөдөлгүүрээс бохирдуулагч хийнүүд (SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>) агаар мандалд тархаж, агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Иймд, эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг 2023 онд тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-5: Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Ашиглагдах машин, техникүүдийн хөдөлгөөнөөр агаарт тоосонцор (PM <sub>2.5</sub> болон PM <sub>10</sub> ) үүсэх	Төслийн талбайд автомашины хурдыг 10км/цаг хүртэл хязгаарлах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн түр замын тэмдэгт автомашины хурдыг 10км/цаг хүртэл хязгаарласан тэмдэгийг 2022 онд байрлуулсан ба автомашины хөдөлгөөнд талбайн менежер болон төслийн талбайн харуул хяналт тавин ажилладаг. Төслийн талбайн харуул нь аливаа тээврийн хэрэгсэл төслийн талбайд нэвтрэхэд 10 км/цаг хүртэлх хурдны дээд хязгаарыг жолоочид сануулж мэдэгдсэний дараа нэвтрүүлж ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.1-р бүлгээс харна уу.	Автомашины хөдөлгөөнд талбайн менежер болон харуул хяналт тавьж, шаардлага өгч ажилладаг тул зардал гараагүй.
2		Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	УДБҮ-ийн төслийн талбай, машин зам	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь замын тоосжилтыг бууруулах зорилгоор бороожуулагч ашиглан төслийн талбайд усалгааны системийг угсарсан бөгөөд 2023 оны 5-р сараас эхлэн ажиллуулсан. Тус системийн усны эх үүсвэрийг үндсэн барилга	Төслийн талбайд суурилуулсан усалгааны системийн зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.

3		Дулааны улиралд барилгын ажлын үе шатанд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх (11-р сараас 3-р сарыг дуустал хүйтний улиралд усалгаа багасах болон зогсоно)	УДБҮ-ийн төслийн шаардлагатай бүх зам, талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	байгууламжийн барилгын сууриас шавхаж буй хөрсний усыг эргүүлэн ашигладаг байдлаар шийдсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 438.65 м <sup>3</sup> усыг төслийн талбайн зам талбайн тоосжилт дарах усалгаанд зарцуулсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.2-р бүлгээс харна уу.	
4	Барилгажилтын үед буюу газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Тоосонцор (PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> ), дуу шуугиан, CO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , H <sub>2</sub> S-н хэмжилтийг тогтмол хугацаанд байнгын мониторинг хийх	УДБҮ-ийн төслийн талбай N47°54' 01.3'' E106°45'06''	Тогтмол хэрэгжүүлж байна	Захиалагчийн шаардлагын дагуу төслийн гүйцэтгэгч нь агаарын чанарын автомат хэмжилтийн багажийг 2023 оны 5-р сарын 2-ны өдөр төслийн талбайд байршуулж, агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэж эхэлсэн ба тус багажийг суурилуулах хүртэл сард 1 удаа итгэмжлэгдсэн лабораториор хэмжилт хийлгүүлсэн. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн мэдээллийг энэхүү тайлангийн 9.1-р бүлгээс дэлгэрэнгүй харна уу.	Энэхүү арга хэмжээний зардал нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсан.
5		Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлсэн байх ба үл тохирол илэрсэн тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлдэг. Хэрэв үзлэг, хяналтын үеэр байгаль орчны үл тохирол илрүүлсэн тохиолдолд тухай бүрт баримтжуулж, холбогдох талд залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2-р бүлгээс танилцана уу.	Энэхүү арга хэмжээг гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй.
6	Барилгажилтын талбайгаас техник хэрэгслийн	Хүнд машин механизмын дугуйнд наалдсан бетон, шавар	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь төслийн талбайн нэвтрэх хэсгийн түр замд ойролцоогоор 18 м <sup>3</sup> дайрга дэвсэж, түр замыг сайжруулсан. Ингэснээр,	Төслийн талбайн түр замыг сайжруулахад УДБҮ-ийн төслийн барилгын суурийн

	дугуйнд шавар, бетон зэрэг наалдаж хатуу хучилттай замд тоос шороо үүсгэх	зэргийг төслийн талбайд цэвэрлэсний дараа төслийн талбайгаас гаргах			төслийн талбайгаас гарах хүнд машин механизм нь тус зам дээгүүр зорчиж, дугуйнд наалдсан бетон, шавар зэргийг унагаах боломж бүрдэх юм. Тайлант хугацаанд төслийн талбайгаас гарсан хүнд машин механизмуудтай холбоотой хатуу хучилттай замд тоос шороо үүсгэсэн тухай гомдол болон зөрчил бүртгэгдээгүй болно. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.3-р бүлгээс харна уу.	ухлагаас гарсан шороог ашигласан тул нэмэлт зардал гараагүй.
7	Бараа материал, хог хаягдал, газар шорооны ажлын үед үүссэн шороо зэргийн тээвэрлэлтээс тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Бараа материал, хог хаягдал, газар шорооны ажлын үед үүссэн шороо зэргийг тээвэрлэхдээ ачааны машины тэвшийг хучих	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн барилга угсралтын ажлын хугацаанд ачааны машины тэвшийг бараа материал, хог хаягдал зэргийг тээвэрлэх үед тогтмол хучиж ажилласан бөгөөд тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.4-р бүлгээс харна уу.	Энэхүү арга хэмжээний хэрэгжилтэнд гүйцэтгэгчийн барилга угсралтын хариуцсан инженер болон талбайн менежер хяналт тавьж, шаардлага өгч ажилладаг тул зардал гараагүй.
8	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хийгээр агаар бохирдох	Техникийн улсын үзлэг, оношилгоонд бүрэн хамрагдсан (хөдөлгүүрийн утаа, түүний найрлага дах хорт бодис, тортогжилтын хэмжээ нь MNS 5013, MNS 5014 стандартад тогтоосон хэмжээнээс хэтрээгүй) тээврийн хэрэгслүүдийг	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.4-р бүлгээс харна уу.	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийг түрээслэх буюу туслан гүйцэтгэгчээс нийлүүлэх тул техникийн улсын үзлэг, оношилгоонд хамруулах нь туслан гүйцэтгэгч компанийн үүрэг байна. Мөн төслийн талбайд нэвтрэхийн өмнөх үзлэгийг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг

		төслийн талбайд ашиглах				гүйцэтгэдэг тул зардал гараагүй.
9		Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглахыг шаардах ба тус стандартын шатахуун худалдан авсан тухай баримт мэдээллийг гүйцэтгэгчид хүргүүлж байх зохицуулалтыг хийх (Энэхүү шаардлага нь дизель түлш ашигладаг тээврийн хэрэгсэлд хамаарахгүй болно)	УДБҮ-ийн төслийн талбайн холбогдох тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн үндсэн барилгын явцад ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компаниудын ажил үйлчилгээний гэрээнд холбогдох шаардлагыг тусган оруулсан бөгөөд шатахуун худалдан авсан тухай баримтжуулсан мэдээллийг хүлээн авч, хадгалж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.5-р бүлгээс харна уу.	Туслан гүйцэтгэгчийн холбогдох тээврийн хэрэгслүүдэд тавигдах шаардлагыг ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой тусгаж оруулсан тул зардал гараагүй.
10		Төслийн талбайд хог хаягдал шатаах, ил гал гаргахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
					<b>Нийт</b>	-



#### 4.6.1 Замаас үүсэх тоосжилт бууруулах зорилгоор хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх

Энэ оны байдлаар УДБҮ-ийн талбайд 39 хүнд машин механизм, тоног төхөөрөмж болон төслийн гүйцэтгэгчийн эзэмшлийн суудлын 4, ачааны 1, нийтийн тээврийн 1 буюу нийт 45 хөдөлгөөнт тоног төхөөрөмж төслийн талбайд тогтмол нэвтэрч ажил гүйцэтгэхэд оролцсон. Мөн захиалагчийн болон төслийн гүйцэтгэгчийн ажиллагсдын хувийн унаа нь гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны багаас автомашин төслийн талбайд нэвтрүүлэх хуудас авч, харуулд шалгуулан нэвтэрдэг. Эдгээр тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг зохицуулах, хурдны хязгаарыг баримтжуулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- УДБҮ-ийн төслийн урьдчилсан зааварчилгааны “Талбайн менежмент” хэсгээр дамжуулан нийт ажилтнуудад төслийн талбайд мөрдөгдөх хурдны дээд хязгаарын талаарх мэдээллийг хүргэж ажилладаг (Зураг 4-9).
- УДБҮ-ийн төслийн талбай доторх замуудад хурдны дээд хязгаарын 10 км/ц тэмдгийг 2022 онд байрлуулсан (Зураг 4-10) ба автомашины хөдөлгөөнд талбайн менежер болон төслийн талбайн харуул хяналт тавин ажилладаг. Төслийн талбайн харуул нь аливаа тээврийн хэрэгсэл төслийн талбайд нэвтрэхэд 10 км/цаг хүртэлх хурдны дээд хязгаарыг жолоочид сануулж мэдэгдсэний дараа нэвтрүүлж ажиллаж байна.

Зураг 4-9: УДБҮ-ийн төслийн урьдчилсан зааварчилгааны талбайн менежмент хэсгийн сургалтын агуулга



14

Зураг 4-10: УДБҮ-ийн төслийн талбайд байршуулсан хурдны дээд хязгаарын тэмдэг



#### 4.6.2 УДБҮ-ийн төслийн зам, талбайд тоосжилт дарах усалгаа хийх

Төслийн гүйцэтгэгч нь замын тоосжилтыг бууруулах зорилгоор бороожуулагч ашиглан төслийн талбайд усалгааны системийг угсарсан бөгөөд 2023 оны 5-р сараас эхлэн ажиллагаанд оруулсан. Тус системийн усны эх үүсвэрийг үндсэн барилга байгууламжийн барилгын сууриас шавхаж буй хөрсний усыг эргүүлэн ашигладаг байдлаар шийдсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 438.65 м<sup>3</sup> усыг төслийн талбайн зам талбайн тоосжилт дарах усалгаанд зарцуулсан байна. Энэхүү усалгааны систем нь төслийн талбайн орц, гарцны хэсгээс эхлэн насос станц №2 байгууламжийн баруун тал хүртэлх замыг хамардаг бөгөөд ойролцоогоор 205 метрийн урттай ба нийт 23 ш бороожуулагч ашигласан.

Мөн тоосжилт дарах усалгааны системийг угсарч байх хугацаанд төслийн талбайд 5 тонн бүхий усалгааны машинаар зам, талбайн усалгааг гүйцэтгэж ажилласан.

УДБҮ-ийн төслийн зам, талбайн усалгааг дулааны улиралд өдөр бүр, шаардлагатай тохиолдолд өдөрт 2-3 удаа усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд буюу 11-р сараас 3-р сарыг дуустал усалгаа зогсоох бөгөөд дулааны улирлын бороотой өдрүүдэд мөн зам, талбайн усалгааг зогсоож ажилласан.

Төслийн талбайн усалгааны системийн харагдах байдал, хамрах хүрээ болон усалгааны машин ашиглан зам, талбайн усалгааг гүйцэтгэж буй зурган мэдээллийг доорх хэсгээс харна уу.

Зураг 4-11: УДБҮ-ийн төслийн талбайд суурилуулсан усалгааны системийн харагдах байдал



Ойролцоогоор 205 м урттай шугам хоолойнд 10 м тутамд зурагт харагдах бороожуулагч хошууг суурилуулсан.




Насос станц №2-ийн баруун талын замаар усалгааны систем ажиллаж буй байдал



Насос станц №1-ийн баруун талын замаар усалгааны систем ажиллаж буй байдал





Таних тэмдэг	Усалгааны систем	Гүний худгийн эрүүл ахуйн бүс	Түр гэрэлтүүлэг
--------------	------------------	-------------------------------	-----------------



УДБҮ-ийн төслийн зам, талбайг усалж буй байдал



УДБҮ-ийн төслийн барилгын суурийн ухлагаас гарсан илүүдэл шороог ШТЦБ-ийн төслийн талбайд хадгалахад зорчих хэсгийн зам усалгааг хийж буй байдал

#### 4.6.3 Хүнд, машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийх

Төслийн гүйцэтгэгч нь төслийн талбайн нэвтрэх хэсгийн түр замд ойролцоогоор 18 м<sup>3</sup> дайрга дэвсэж, түр замыг сайжруулсан. Ингэснээр, төслийн талбайгаас гарах хүнд машин механизм нь тус зам дээгүүр зорчиж, дугуйнд наалдсан бетон, шавар зэргийг унагаах боломж бүрдэх юм.

Тайлант хугацаанд төслийн талбайгаас гарсан хүнд машин механизмуудтай холбоотой хатуу хучилттай замд тоос шороо үүсгэсэн тухай гомдол болон зөрчил бүртгэгдээгүй болно.

Зураг 4-14: Автосамосвалаар 18м<sup>3</sup> дайрга буулгаж гарах хаалганы хонхойсон замыг ковшиор түрж тэгшилжэ буй байдал



#### 4.6.4 Ачааны машины тэвшийг бүтээлгэтэй байлгах, хяналт тавих

Төслийн талбайн барилга угсралтын ажлын хугацаанд ачааны машины тэвшийг бараа материал, хог хаягдал зэргийг тээвэрлэх үед тогтмол хучиж ажилласан бөгөөд тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд төслийн талбайн менежер, харуулын ажилтан болон гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь туслан гүйцэтгэгч компаниудын ачааны машинд хяналт тавьж, тухай бүр шаардлага тавьж ажилласан.





#### 4.6.5 Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглах

УДБҮ-ийн төслийн барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэлээс агаарт чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгч компаниудад Евро 5 стандартын шатахуун ашиглахыг шаардаж, ажил гүйцэтгэх гэрээний үе шатнаас эхлэн тухайн шаардлагыг хүргүүлж ажиллаж байна. Ингэхдээ, төслийн үндсэн барилгын явцад ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компаниудын ажил үйлчилгээний гэрээнд холбогдох шаардлагыг тусган оруулсан бөгөөд шатахуун худалдан авсан тухай баримтжуулсан мэдээллийг хүлээн авч, хадгалж байна.

Зураг 4-16: УДБҮ-ийн төслийн ажил үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан евро 5 стандартын шатахуун ашиглах тухай шаардлага

#### БАЙГАЛЬ ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- I. Байгаль орчинтой холбоотой хууль, зохицуулалтын нийцлийг хангах, Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах
  - I.1 Агаар
    - I.1.1. Агвартай холбоотой баримт бичиг. Үүнд:
      - Агаарын төлбөрийн тухай хуулийн дагуу агаар бохирдуулагч эх үүсвэр болох хүнд машин механизм төслийн талбайд ашиглах тохиолдолд тухайн жилийн агаар бохирдуулсаны төлбөрийг улсад төлсөн тухай баримтыг захиалагчийн ХАБЭА-н багт өгнө.
    - I.1.2. Агаарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах. Үүнд:
      - Төслийн талбайд монгол улсад хамгийн ихдээ 10 жил болсон машин механизмыг ажиллуулах ба төслийн талбайд нэвтрэхийн өмнө ХАБЭА-н багийн ХАБЭА инженерээс машин механизм ажиллуулах зөвшөөрөл авна.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас: 10/21

- Төслийн талбайд аливаа тээврийн хэрэгсэл 10 км/цаг дээд хурдын хязгаарыг баримтлана. Бараа материал, цемент, шороо, хог хаягдал зэрэг тоосжилт үүсгэх боломжтой зүйлсийг тээвэрлэх тохиолдолд ачааны машины тэвхийг зайлшгүй хучсан байна.
- Төслийн талбайд ашиглах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нь Евро-5 (Евро-5-92, АИ-95, АИ-98, Евро-ДТ гэх мэт) стандартын түлш ашигладаг байх ба баримтжуулсан мэдээллийг төслийн ХАБЭА-н багт хүргүүлнэ.
- Ажлын байрны дотор орчинд жижиг оврын генератор, дизель халаагуур болон гар хөрөө ажиллуулах, гагнуур хийх зэрэгт ХАБЭА-н багийн ХАБЭА-н инженерээс зөвшөөрөл авах бөгөөд тухайн орчинд ажиллах ажиллагчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангах, ажлын байранд тогтмол агааржуулалт, чийгшүүлэлт хийх, ажиллагчдыг тухайн орчинд ээлж үүсгэн ажиллуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### 4.7 Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн төслийн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд гадаргын усны эх үүсвэр багтаагүй хэдий ч барилгажилтын үе шатанд төслийн талбайн талбайн хог хаягдал, ШТМ-ын хяналтыг дутуу гүйцэтгэснээс гадаргын усанд дам байдлаар нөлөөлж болзошгүй хэмээн БОННУ-нд тусгагдсан. Иймд, болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээнүүдийг тус онд тогтмол хэрэгжүүлэн ажилласан.

Хүснэгт 4-6: Гадаргын усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Хог хаягдлыг ил задгай хаях; тээврийн хэрэгслээс ШТМ асгарах зэргээс хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэж, ширүүн бороо орох үед үерийн усаар угаагдан Туул голын усны чанарт нөлөөлж болзошгүй.	УДБҮ-ийн төслийн хүрээнд аливаа асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний дагуу төслийн талбайд асгаралтаас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажилчдад шаардлагатай мэдлэгийг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1-р бүлгээс харна уу.	Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан боловсруулсан тул зардал гараагүй. Мөн төслийн урьдчилсан зааварчилгааг гүйцэтгэгч зохион байгуулдаг тул зардал гараагүй болно.
2	Хог хаягдлыг ил задгай хаях; тээврийн хэрэгслээс ШТМ асгарах зэргээс хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэж, ширүүн бороо орох үед үерийн усаар угаагдан Туул голын усны чанарт нөлөөлж болзошгүй.	Төслийн талбайд барилгын ажилд ашиглах тоног төхөөрөмжийг шатахуунаар цэнэглэх тохиолдолд тусгай түлшний машин буюу авто цистернээр цэнэглэх ба гүйцэтгэгчийн	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн үндсэн барилга байгууламжийн суурийн ухлагын ажилд ашигласан гинжит экскаватор болон төслийн талбайд тог тасарсан тохиолдолд ажиллуулах зорилготой нөөц генераторыг цэнэглэх зорилгоор төслийн талбайд авто цистернээр түлш цэнэглэлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн. Түлш цэнэглэлтийн үе шатанд хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлж, тухай бүр гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хяналт тавьж	Түлш цэнэглэлтийн үеийн хяналтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэдэг тул зардал гараагүй.

		ХАБЭАБО-ны баг түлш цэнэглэх ажилд хяналт тавьж ажиллах			ажилласан ба тайлант хугацаанд түлшний авто цистерн машинаас хөрсөнд асгаралт үүсгэсэн зөрчил бүртгэгдээгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.7.1-р бүлгээс харна уу.	
3		Төслийн талбайгаас гарах хүнд машин механизмын дугуйг угааж, цэвэрлэхээс бусад тохиолдолд төслийн талбайд машин механизм угаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд машин механизм угаахыг хориглох тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажиллагсдад хүргэдэг. Тайлант хугацаанд төслийн талбайд машин механизм угаасан зөрчил гараагүй.	Төслийн урьдчилсан зааварчилгааг гүйцэтгэгч зохион байгуулдаг тул зардал гараагүй болно.
4		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан оновчтой хэрэгжүүлэх; Ил задгай хог хаяхгүй байх ба өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар батлуулсан ба гүйцэтгэгч нь хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Өдөр бүрийн талбайн ажил дууссаны дараа ажлын байрны эмх цэгцийг хангуулах ажлыг төслийн барилга угсралтын баг болон талбайн менежер хариуцан хэрэгжилтийг хангуулан ажилладаг.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан боловсруулсан тул зардал гараагүй. Мөн өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг холбогдох ажлын багууд тогтмол хийдэг тул нэмэлт зардал гараагүй.
5		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд хог ангилан хаях тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1 болон 8-р бүлгээс харна уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.
					<b>Нийт</b>	-

#### 4.7.1 Төслийн талбайд түлш цэнэглэлт хийх үеийн хяналт тавих

Төслийн талбайн үндсэн барилга байгууламжийн суурийн ухлагын ажилд ашигласан гинжит экскаватор болон төслийн талбайд тог тасарсан тохиолдолд ажиллуулах зорилготой нөөц генераторыг цэнэглэх зорилгоор төслийн талбайд авто цистернээр түлш цэнэглэлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн. Бусад тохиолдолд буюу төслийн талбайгаас гарч түлш цэнэглэлт хийх боломжтой машин механизмын түлш цэнэглэлтийг төслийн талбайд гүйцэтгэхгүй байж, хориглож ажилласан.

Түлш цэнэглэлтийн үе шатанд хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлж, тухай бүр гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хяналт тавьж ажилласан ба тайлант хугацаанд түлшний авто цистерн машинаас хөрсөнд асгаралт үүсгэсэн зөрчил бүртгэгдээгүй байна. Холбогдох зурган мэдээллийг дараах зургаас харна уу.

Зураг 4-17: УДБҮ-ийн төслийн талбайд зориулалтын машинаар түлш цэнэглэлт хийгдэж буй байдал



#### 4.8 Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн төслийн тайлант хугацаанд зарцуулсан нийт усны зарцуулалтыг доорх хүснэгтэд нэгтгэв. Тус хүснэгтэд төслийн талбайд унд, ахуйн болон бетон арчилгааны явцад ашигласан усны нийт зарцуулалтыг харуулсан бөгөөд 2023 онд хийгдсэн үндсэн барилга байгууламжийн барилгын суурийн хөрсний усыг шавхах ажлын хүрээнд шавхсан хөрсний усны хэмжээг энэхүү тайлангийн 2.1.1-р бүлгийн “Хөрсний ус соруулах” ажлын тайланд оруулсан болно.

Хүснэгт 4-7: УДБҮ-ийн нийт усны зарцуулалт, 2023 оны 10-р сарын 23-ны өдрийн байдлаар

№	Усны зарцуулалтын төрөл	Усны зарцуулалт, м <sup>3</sup>	Тайлбар
1	Ундны ус	14.66	Тайлант хугацаанд төслийн нийт ажилчдын ундны усыг “Галшинт ХХК”-ны 18.9 литрийн баллон бүхий цэвэр усаар хангаж байна.
2	Оффист байрших ажилчдын унд, ахуйн усны зарцуулалт	507	Төслийн талбайн түр оффисуудын унд, ахуйн хэрэглээний усыг “Ус сувгийн удирдах газар”-тай байгуулсан аж ахуйн гэрээний дагуу төслийн талбайд нийлүүлж байна.
3	Төслийн талбайн нийтийн ариун цэврийн өрөөний ахуйн усны зарцуулалт	116	Төслийн талбайд байрлах нийтийн ариун цэврийн өрөөний ус хангамжийг 2022 оны 12-р сарын 9-ны өдөр өрөмдсөн төслийн талбай дах гүний худгаас хангадаг. Энэхүү гүний худгийн усыг зөвхөн ахуйн зориулалтаар ашигладаг бөгөөд ундны



			зориулалтаар ашиглахыг хориглож ажиллаж байна.
4	Зам, талбайн усалгаа	438.65	УДБҮ-ийн төслийн талбайн зам талбайн усалгааг төслийн талбайд суурилуулсан усалгааны системийг ашиглаж гүйцэтгэдэг ба энэхүү системийн ус хангамжийг төслийн талбайгаас шавхаж буй хөрсний усыг эргүүлэн ашигладаг байдлаар шийдсэн. Тус усалгааны системд нийт 23 ширхэг бороожуулагч хошуу ашигласан бөгөөд нэг хошууны цагт зарцуулах усны хэмжээ хамгийн ихдээ 0.4 м <sup>3</sup> байна.
5	Барилгын ажлын үед шугам хоолойн туршилт	0	2023 онд барилга угсралтын ажлын явцаас хамааран шугам хоолойн туршилтын ажил хийгдээгүй.
6	Бетон арчилгаа	7.58	2023 онд нийт 1516.5 м <sup>3</sup> бетон цутгалтын ажил хийгдсэн бөгөөд 1 м <sup>3</sup> бетон арчилгаанд ойролцоогоор 5 л ус ашиглахаар тооцсон.
	<b>Нийт</b>	<b>1,083.89</b>	

УДБҮ-ийн төслийн талбайд байршиж буй захиалагчийн болон гүйцэтгэгчийн түр оффисуудын унд ахуйн усыг УСҮГ-тай байгуулсан гэрээний дагуу зөврөөр хангадаг бөгөөд 10 тн багтаамж бүхий ундны усны танкийг төслийн талбайд байршуулан ашиглаж байна.

Тайлант хугацаанд УДБҮ-ийн төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн доорх арга хэмжээнүүдийг төслийн гүйцэтгэгч нь тогтмол авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Суурь бэлтгэх үед газрын доорх ус бохирдох, нөөц багасах	Гүйцэтгэгч нь барилгын суурь бэлтгэх ажлын хүрээнд хөрсний ус шавхах ажлыг гүйцэтгэхээс өмнө “Ус ашиглуулах дүгнэлт” болон “Ус ашиглуулах зөвшөөрөл”-ийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авсан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн гүйцэтгэгч нь барилгын суурийн хөрсний ус шавхах ажлыг төслийн талбайд гүйцэтгэж эхлэхээс өмнө буюу 2023 оны 2-р сарын 3-ны өдөр Усны газраас “Ус ашиглуулах дүгнэлт”, 2023 оны 3-р сарын 9-ны өдөр Туул голын сав газраас “Ус шавхан зайлуулах зөвшөөрөл”-ийг авч, тус байгууллагатай “Барилгын суурийн ус шавхан зайлуулах гэрээ” байгуулан ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 10-р бүлгийн хүснэгт Хүснэгт 10-1-ээс харна уу.	Эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад албан хүсэлт хүргүүлэн холбогдох баримт бичгүүдийн бүрдлийг хангаж ажилласан тул нэмэлт зардал гараагүй.
2		Барилгын суурь бэлтгэхэд шавхах хөрсний усны гаралт дээр тоолуур суурилуулж, шавхсан усны хэмжээг бүртгэлжүүлэхэд ашиглах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	2023 оны 9-р сарын 25-ны өдрийн байдлаар төслийн талбайн хөрсний ус шавхаж буй 3 байршилд нийт 4 ширхэг усны тоолуур суурилуулсан. Насос станц №1 байршилд 2, тогтворжуулах сан байршилд 1 болон насос станц №2 байршилд 1 стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан усны тоолуур ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 2.1.1-р бүлгийн “Хөрсний ус соруулах” хэсгээс болон 4.8.1-р бүлгээс харна уу.	Хөрсний ус шавхаж буй байршилд усны тоолуур суурилуулах ажил нь хөрсний ус шавхан зайлуулах ажил үйлчилгээг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компанийн гэрээний нэг хэсэг тул нэмэлт зардал гараагүй.

3		Барилгын суурь бэлтгэхэд шавхах хөрсний уснаас дээж авч MNS 4943:2015 <sup>5</sup> стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг мэргэжлийн лабораториор тодорхойлуулах	УДБҮ-ийн төслийн талбай, хөрсний ус	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайн барилгын суурийн хөрсний усыг шавхах ажлын хугацаанд сард 1 удаа шавхаж буй хөрсний уснаас дээж авч, MNS 4943:2015 стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн ажилладаг. Хөрсний усны шинжилгээний дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 9.3-р бүлгээс харна уу.	Энэхүү арга хэмжээний зардал нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсан.
4		Хөрсний усыг УСУГ-ын зөвшөөрөлд үндэслэн УДБҮ-ийн төслийн талбайг тойрон урсах төв цэвэрлэх байгууламжийн гаргалгааны далан сувагруу шавхах тул гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь хөрсний ус заагдсан гаргалгааны сувагруу шавхагдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлдэг ба хөрсний ус заагдсан гаргалгааны сувагруу шавхагдаж буй эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. УДБҮ-ийн төслийн талбайд нийт 2 цэгрүү хөрсний усыг шавхаж буй бөгөөд тухайн байршлуудыг энэхүү тайлангийн Зураг 2-1-ээс харах боломжтой.  Хэрэв үзлэг, хяналтын үеэр байгаль орчны үл тохирол илрүүлсэн тохиолдолд тухай бүрт баримтжуулж, холбогдох талд залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Тайлант хугацаанд холбогдох байгаль орчны зөрчил үүсээгүй байна.	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан өдөр бүр талбайн үзлэгийг гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй.
5		Гүйцэтгэгч нь гүний худгаас ашиглах усны зарцуулалтыг хэмнэх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжүүлсэн	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь төслийн талбайн зам, талбайн усалгааг төслийн талбайд	Төслийн талбайд суурилуулсан усалгааны системийн

<sup>5</sup> MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага

		үүднээс шавхсан хөрсний усыг зам, талбайн усалгаанд эргүүлэн ашиглах боломжийг бүрдүүлэх ба эргүүлэн ашигласан усны хэмжээг бүртгэлжүүлэх			суурилуулсан усалгааны системийг ашиглаж гүйцэтгэдэг ба энэхүү системийн ус хангамжийг төслийн талбайгаас шавхаж буй хөрсний усыг эргүүлэн ашигладаг байдлаар шийдсэн. Тайлант хугацаанд нийт 438.65 м <sup>3</sup> бүхий шавхсан хөрсний усыг зам, талбайн усалгаанд эргүүлэн ашигласан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.2-р бүлгээс харна уу.	зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
6	Хог хаягдлыг ил задгай хаях, шатах тослох материалын бохирдол хур борооны усаар нэвчин газрын доорх усыг бохирдуулах	Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн байдал (гидр хоолой, гидр банк хөлрөөгүй, тос масло асгаралтгүй, эвдрэлгүй байх)-ыг төслийн талбайд нэвтрэхийн өмнө шалгаж, баталгаажуулах	УДБҮ-ийн төслийн барилгын ажилд ашиглах нийт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.4-р бүлгээс харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудасны дагуу шалгадаг тул зардал гараагүй.
7		Төслийн талбайд машин, механизмд засвар хийхийг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь “Шатахуун түгээх автоцистернээр шатахуун цэнэглэх болон хадгалах, тоног төхөөрөмжид жижиг засвар үйлчилгээ хийх журам”-ийг боловсруулж, захиалагчаар батлуулсан ба төслийн талбайд	Тус журмыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж, хэрэгжилтийг хангуулахад хяналт тавин ажиллаж буй тул нэмэлт зардал гараагүй.

					<p>хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. УДБҮ-ийн төслийн талбайд тоног төхөөрөмжид дараах жижиг засвар үйлчилгээг хийхийг зөвшөөрч байгаа ба бусад тохиолдолд төслийн талбайгаас тухайн машин механизмыг гаргаж, төслийн талбайд машин, механизмд засвар үйлчилгээ хийхийг хориглож ажилласан.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гэрлийн ламп солих</li> <li>• Агаар шүүгч солих</li> <li>• Шил арчих шингэн нэмэх</li> <li>• Дугуйн боолт чангалгаа хийх</li> </ul>	
8		Асгаралт шингээгч иж бүрдлийг төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	<p>Тайлант хугацаанд нэмэлтээр 3 ширхэг асгаралт шингээгч иж бүрдлийг УДБҮ-ийн төслийн талбайд байршуулснаар дараах 4 байршилд асгаралт шингээгч иж бүрдэл байршиж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Насос станц №1 байгууламжийн баруун талд</li> <li>• Химийн бодисын агуулахын хажууд</li> <li>• Аюултай хог хаягдлын цэгийн хажууд</li> <li>• Төслийн талбайд байрших генераторын хашаанд</li> </ul> <p>Төслийн гүйцэтгэгч нь асгаралт шингээгч иж бүрдлийн бэлэн байдлыг шалгах болон хангах зорилгоор сар бүр тогтмол асгаралт шингээгч иж бүрдлийн үзлэг, шалгалтыг гүйцэтгэн ажиллаж байна.</p>	Асгаралт шингээгч иж бүрдлийн зардал нь газрын гадарга, хэвлийг хамгаалах хэсэгт тусгагдсан.



					Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.3-р бүлгээс харна уу.	
9		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсад урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед авах арга хэмжээ болон асгаралт шингээгч иж бүрдлийг ашиглах заавар зэрэг тусгагдсан байдаг ба нийт ажилтнуудад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1.1-р бүлгээс танилцана уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.
10		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах; Ил задгай хог хаяхгүй байх ба өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар батлуулсан ба гүйцэтгэгч нь хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Өдөр бүрийн талбайн ажил дууссаны дараа ажлын байрны эмх цэгцийг хангуулах ажлыг төслийн барилга угсралтын баг болон талбайн менежер хариуцан хэрэгжилтийг хангуулан ажилладаг.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан боловсруулсан тул зардал гараагүй. Мөн өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг холбогдох ажлын багууд тогтмол хийдэг тул нэмэлт зардал гараагүй.
11		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд хог ангилан хаях тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.

					мэдээллийг энэхүү тайлангийн 4.1 болон 8-р бүлгээс харна уу.	
12		Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлсэн байх ба үл тохирол илэрсэн тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлдэг. Хэрэв үзлэг, хяналтын үеэр байгаль орчны үл тохирол илрүүлсэн тохиолдолд тухай бүрт баримтжуулж, холбогдох талд залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2-р бүлгээс танилцана уу.	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй.
13	Газрын доорх усыг ашигласнаар ашигласан хэмжээгээр гүний усны нөөц багасах, усны хэрэглээний хяналтыг хэрэгжүүлээг үйн улмаас ус ашиглах дүгнэлтэд зааснаас илүү хэмжээний ус ашиглах эрсдэл үүсэж болзошгүй	Харьяа эрх бүхий төрийн байгууллагаас төслийн талбайд шинээр гаргасан гүний худгаас ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах зөвшөөрөл авах ба ус ашиглах гэрээнд заасны дагуу ус ашиглалтын төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөх	Төслийн талбайн гүний худаг	Бүрэн хэрэгжсэн	Төслийн гүйцэтгэгч нь төслийн талбай дах гүний худгаас ус ашиглаж эхлэхээс өмнө дараах баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• 2023 оны 4-р сарын 4-ны өдөр НБОГ-аас олгосон “Ус ашиглуулах дүгнэлт”</li> <li>• 2023 оны 6-р сарын 21-ний өдөр СХД-ийн Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-тай байгуулсан “Ус ашиглах гэрээ”</li> <li>• 2023 оны 6-р сарын 21-ний өдөр СХД-ийн ЗДТГ-ийн олгосон “Ус ашиглах эрхийн бичиг”</li> </ul> Мөн “Ус ашиглах гэрээ”-нд заасны дагуу гүйцэтгэгч нь 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор гүний худгийн ус ашиглалтын тайланг тоолуурын заалтаар тооцож гарган ус ашигласны төлбөрийг эрх бүхий	150,000 (Ус ашиглуулах зөвшөөрөл авч, ус ашиглах гэрээ байгуулахад СХД-ийн Төрийн сангийн дансанд тушаасан төлбөр)  Ашигласан усны хэмжээнээс хамаарч 2023 оны 12-р сарын 25-ны өдрөөс өмнө төлөх тул тодорхойлох боломжгүй.

					мэргэжлийн байгууллагын дансанд төлнө.	
14		Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Төслийн талбайн гүний худаг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн гүний худгийн усыг зөвхөн талбай дах нийтийн ариун цэврийн өрөөний ахуйн ус хангамжийн зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашигласан зөрчил гараагүй болно. Мөн төслийн гүйцэтгэгч нь “Ус ашиглах гэрээ”-нд заасны дагуу гүйцэтгэгч нь 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор ус ашигласны төлбөрийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын дансанд төлнө.	-
15		Усны гаралт дээр усны тоолуур суурилуулж, усны зарцуулалтад тогтмол хяналт тавих	Төслийн талбайн гүний худаг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн гүний худагт стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан тоолуур суурилуулсан ба долоо хоног бүр гүний худгийн усны зарцуулалтыг хянаж, захиалагч талд тайлагнаж ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.8.2-р бүлгээс харна уу.	200,000
16		Худгийн тоолуур хэвийн ажиллах боломжийг бүрдүүлж, худгийг тоноглох буюу халаагуур тавих	Төслийн талбайн гүний худаг	Бүрэн хэрэгжсэн	Төслийн гүйцэтгэгч нь худгийг тоноглохдоо цооногийн гадуур 10 тн бүхий контейнер суурилуулсан ба “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу худгийн тоолуурын хамгаалалтыг дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Усны тоолуурыг түүний заалтыг харах боломжтой байдлаар суурилуулсан</li> <li>• Гэрэлтүүлэг суурилуулсан</li> </ul>	200,000

					<ul style="list-style-type: none"> <li>• Контейнерын агаарын температурыг +5°C-ээс багагүй байлгахын тулд халаагуур суурилуулсан ба хүйтний улиралд тогтмол ажиллуулдаг</li> </ul> <p>Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.8.2-р бүлгээс харна уу.</p>	
17		Гүний худгаас 50 м зайд эрүүл ахуйн бүс тогтоож, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж ажиллах	Төслийн талбайн гүний худаг	Тогтмол хэрэгжүүлж байна	<p>Төслийн талбайн гүний худгаас 50 м радиуст эрүүл ахуйн бүс тогтоож, 4 байршилд тэмдэг байршуулсан бөгөөд эрүүл ахуйн бүсэд хориглох мэдээллийн самбарыг гүний худгийн ойр байршуулсан. Мөн төслийн гүйцэтгэгч нь гүний худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтаар дамжуулан нийт ажилтнуудад олгон ажиллаж байна.</p> <p>Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.8.2-р бүлгээс харна уу.</p>	200,880 (Эрүүл ахуйн бүс тэмдэг: 4 ш * 22,500₮ Мэдээллийн самбар: 1 ш * 110,880₮ )
18		Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	<p>“Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө” нь ГБОНМТ-ний нэг дэд төлөвлөгөө бөгөөд төслийн гүйцэтгэгч нь тус төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хангуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой төслийн гүйцэтгэгч нь дараах арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ус ашиглалттай холбоотой шаардлагатай зөвшөөрлүүдийг эрх бүхий</li> </ul>	-

					<p>мэргэжлийн байгууллагаас авч ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн талбайн гүний худгийг тоноглож, тоолууржуулсан.</li> <li>• Гүний худгийн эрүүл ахуйн бүс тогтоож, нийт ажилтнуудад мэдээлэл хүргэж байгаа ба эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангуулж ажилладаг.</li> <li>• Газрын доорх усны бохирдлоос сэргийлж, асгаралтаас сэргийлэх арга хэмжээ болон хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн ажилладаг.</li> </ul>	
19	Гүйцэтгэгчийн “Ногоон дүрэм”-ийн дагуу ус хэмнэх дадал, арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан олгосон байх	УДБУ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Ногоон дүрэм”-ийн дагуу ус хэмнэх дадал, арга хэмжээний тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1-р бүлгээс харна уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.	
				<b>Нийт</b>	<b>750,880</b>	



#### 4.8.1 Барилгын сууриас шавхаж буй хөрсний усны тоо хэмжээг баталгаажуулах

УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь үндсэн барилга байгууламжийн суурийн хөрсний ус шавхах үйл ажиллагааны хүрээнд шавхаж буй хөрсний усны тоо хэмжээг баталгаажуулах зорилгоор төслийн талбайн хөрсний ус шавхаж буй 3 байршилд нийт 4 ширхэг усны тоолуур суурилуулж, хяналт тавин ажиллаж байна. Тус 4 ширхэг тоолуурыг насос станц №1 байршилд 2, тогтворжуулах сан байршилд 1 болон насос станц №2 байршилд 1 байхаар байршуулсан бөгөөд тус тоолууруудыг стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан болно.

*Зураг 4-18: УДБҮ-ийн төслийн талбайд хөрсний ус шавхан зайлуулах ажлын хүрээнд суурилуулсан тоолуурын мэдээлэл*



Насос станц №1 байршилд суурилуулсан тоолуур



Тогтворжуулах сан байршилд суурилуулсан тоолуур



Насос станц №2 байршилд суурилуулсан тоолуур



4.8.2 УДБҮ-ийн төслийн талбайд ашиглаж буй гүний худгийн тоноглол болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэхтэй холбоотой хяналт тавих

УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь төслийн талбай дах нийтийн ариун цэврийн байгууламжийн усны эх үүсвэрийг хангах зорилгоор 2022 оны 11-р сарын 16-ны өдөр НБОГ-аас “Худаг гаргах зөвшөөрөл” авч Эрдэнэдрилинг ХХК-аар гүний худгийн цооног өрөмдүүлэх ажлыг 40 м-ийн гүнд хийж гүйцэтгүүлсэн. Үүний дараа тухайн өрөмдүүлсэн гүний худгийг Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу тоноглох ажлыг хийж гүйцэтгэсэн ба 2023 оны 4-р сарын 4-ны өдөр НБОГ-аас олгосон “Ус ашиглуулах дүгнэлт”-д үндэслэн шаардлагатай бичиг баримтуудын бүрдлийг хангаж ажилласан (Хүснэгт 10-1).

Төслийн гүйцэтгэгч нь төслийн талбай дах гүний худгийг тоноглохдоо 10 тонн бүхий контейнерыг ашигласан бөгөөд тус контейнерыг усны насос, гэрэлтүүлэг, халаагуур, усны тоолуур болон 1 тонн багтаамж бүхий усны танк байршуулан тоноглосон. Гүний худгийг тоноглосны дараах байдлыг доорх Зураг 4-20-оос харна уу.

Мөн төслийн гүйцэтгэгч нь гүний худгаас 50 метрийн радиуст гүний худгийн эрүүл ахуйн бүсийг тогтоосон бөгөөд эрүүл ахуйн бүсэд хориглох үйл ажиллагаануудын талаар төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажилтнуудад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Мөн гүний худгаас 50 метрийн зайнд эрүүл ахуйн бүсийн тэмдгүүдийг байршуулсан бөгөөд гүний худгийн хажууд эрүүл ахуйн бүсийн дэглэмийг таниулах мэдээллийн самбарыг байршуулсан (Зураг 4-21). Тайлант хугацаанд гүний худгийн эрүүл бүсийн дэглэм зөрчигдсөн ямар нэгэн байгаль орчны зөрчил, тохиолдолд гараагүй байна.





Гүний худгийн гадна талаас харагдах байдал



Гүний худагт 1 тонн багтаамж бүхий усны танк суурилуулсан байдал



Усны насос болон тоолуур суурилуулсан байдал



Гэрэлтүүлэг суурилуулсан байдал



Халаагуур суурилуулсан байдал



Гүний худгийн эрүүл ахуйн бүсэд хориглох үйл ажиллагааны мэдээлэл бүхий самбар байршуулсан.



Гүний худгаас 50 метрийн зайнд эрүүл ахуйн бүс эхэлж буйг анхааруулах тэмдэг байршуулсан

#### 4.9 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ-ний тайланд тусгаснаар УДБҮ-ийн талбайн хөрсөнд хүнд металл болох хром (Cr) нь MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их агууламжтай илэрсэн ба энэхүү агууламжууд нь барилгын ажлын үед талбайд машин, техникүүдийг ашиглах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хэрэгжүүлэх зэргээс үүдэн өмнөх үеэсээ нэмэгдэж болзошгүй хэмээсэн байна. Мөн тус тайланд тодорхойлсноор УДБҮ-ийн барилга байгууламж барих талбай өнгөн хөрсгүй тул өнгөн хөрс хуулалтын ажил хийгдэхгүй.

Тиймээс, 2023 онд хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд ШТМ-ын асгаралт болон хог хаягдлын менежментийг зөв зохистой хийх шаардлагатай тул хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 19 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Барилгын хог хаягдал (бетон зуурмагийн хаягдал, бүх төрлийн будаг, лак зэрэг химийн бодис агуулсан барилгын хаягдал г.м)-ыг ил задгай хаяснаас төслийн талбайн хөрсөн бүрхэвч бохирдох	УДБҮ-ийн төслийн талбайд төмөр бетон угсралтын ажлын үед бетон зуурмаг нийлүүлэх ажлыг туслан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ. Иймд, гүйцэтгэгч нь тухайн туслан гүйцэтгэгчийн техникийн шаардлага, ажил гүйцэтгэх гэрээ зэрэгт төслийн талбайд бетон угаасан ус болон бетон зуурмагийн хаягдлыг асгахгүй байх шаардлагыг нэмэлтээр оруулж, сайтар анхааруулж ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай, төмөр бетон угсралтын ажил	Тогтмол хэрэгжүүлж байна	Төмөр бетон цутгалтын ажлын үед бетон зуурмаг нийлүүлэх ажлыг “Айзава Монгол” ХХК болон “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Тус байгууллагуудтай байгуулсан ажил үйлчилгээний гэрээнд төслийн талбайд бетон угаасан ус болон бетон зуурмагийн хаягдлыг асгахгүй байх шаардлагыг оруулсан ба төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт оператор, ажилтнуудад тус шаардлагыг сайтар анхааруулж ажилласан.	Төслийн туслан гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангаж ажиллах тул зардал гараагүй.
2		Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлсэн байх ба үл тохирол илэрсэн тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилласан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь талбайн үзлэг, хяналтыг өдөр бүр хэрэгжүүлдэг. Хэрэв үзлэг, хяналтын үеэр байгаль орчны үл тохирол илрүүлсэн тохиолдолд тухай бүрт баримтжуулж, холбогдох талд залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй.



					Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2-р бүлгээс танилцана уу.	
3		Төслийн талбайд үүссэн будаг, цемент гэх мэт аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг аюултай хог хаягдлын тустай цэгт хаях ба химийн бодисын хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлж устгалд оруулах.	УДБҮ-ийн төслийн талбай, аюултай хог хаягдал	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч нь төслийн талбайд аюултай хог хаягдлын цэгийг тустай байгуулсан. Төслийн талбайд ашигласан аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдал болон үүссэн асгаралтыг цэвэрлэхэд ашигласан асгаралт шингээгч материал зэргийг тухайн цэгт тусад нь цуглуулдаг. Тайлант хугацаанд цугларсан аюултай хаягдлын хэмжээ бага байгаа тул төслийн гүйцэтгэгч нь 2023 онд багтааж, нийт цугларсан аюултай хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлж, устгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Төслийн гүйцэтгэгч нь “Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ”-г 2022 оны 12-р сарын 30-ны өдөр Элемент ХХК-тай байгуулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 8-р бүлгээс харна уу.	Тайлант хугацаанд аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх ажил хийгдээгүй байгаа тул зардал гараагүй.
4	Машин, механизмуудаас ШТМ гоожсон тохиолдолд тухайн орчмын талбайн хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	УДБҮ-ийн төслийн “Хөрс хамгаалах төлөвлөгөө” болон “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь “Хөрс хамгаалах төлөвлөгөө” болон “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тогтмол хангуулж ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.9.1 болон 8-р бүлгээс харна уу.	-

5		Төслийн талбайд нэвтрэх машин, механизмын техникийн бүрэн байдлыг шалгаж, баталгаажуулсны дараа талбайд нэвтрүүлэх	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.4-р бүлгээс харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь “Тоног төхөөрөмж, машин механизм” шалгах хуудасны дагуу шалгадаг тул зардал гараагүй.
6		Төслийн талбайд машин, механизмд засвар хийхийг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь “Шатахуун түгээх автоцистернээр шатахуун цэнэглэх болон хадгалах, тоног төхөөрөмжид жижиг засвар үйлчилгээ хийх журам”-ийг боловсруулж, захиалагчаар батлуулсан ба төслийн талбайд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. УДБҮ-ийн төслийн талбайд тоног төхөөрөмжид дараах жижиг засвар үйлчилгээг хийхийг зөвшөөрч байгаа ба бусад тохиолдолд төслийн талбайгаас тухайн машин механизмыг гаргаж, төслийн талбайд машин, механизмд засвар үйлчилгээ хийхийг хориглож ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Гэрлийн ламп солих</li> <li>• Агаар шүүгч солих</li> <li>• Шил арчих шингэн нэмэх</li> </ul> Дугуйн боолт чангалгаа хийх	Тус журмыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж, хэрэгжилтийг хангуулахад хяналт тавин ажиллаж буй тул нэмэлт зардал гараагүй.

7		Их, бага аль ч хэмжээний ШТМ-ын асгаралт үүсгэж буй техникийн хэрэгсэлд төслийн багаас хяналт тавьж, үл тохирлыг арилгах арга хэмжээг авах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Хэрэв хөрсөнд ШТМ-ын асгаралт үүсгэж буй техникийн хэрэгсэл төслийн талбайд ашиглагдаж байвал тухайн техникийг төслийн талбайгаас гаргаж, засвар үйлчилгээг зориулалтын газар гүйцэтгүүлсний дараа төслийн талбайд дахин ашиглах арга хэмжээг авч ажилласан. Тайлант хугацаанд УДБҮ-ийн талбайд бага хэмжээний ШТМ-ын асгаралтууд үүссэн бөгөөд тухай бүр нь цэвэрлүүлж, бохирдсон хөрсийг хуулж, аюултай хаягдлын цэгт шилжүүлэх арга хэмжээг авч ажилласан.	Төслийн талбайд асгаралт үүссэн тохиолдолд цэвэрлэх арга хэмжээг асгаралт үүсгэгч хариуцдаг бөгөөд техникийн засвар үйлчилгээг хариуцах туслан гүйцэтгэгч байгууллага хийх тул нэмэлт зардал гараагүй.
8		Асгаралт шингээгч иж бүрдлийг төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн 4 цэгт асгаралт шингээгч иж бүрдлийг байрлуулж, бэлэн байдлыг хангасан. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.3-р бүлгээс харна уу.	Холбогдох зардал нь газрын гадарга, хэвлийг хамгаалах хэсэгт тусгагдсан.
9		Асгаралт үүсэж хуулсан хөрс, асгаралтыг шингээсэн шингээгч материал зэргийн хаягдлыг аюултай хог хаягдлын хэсэгт хаях	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн хүрээнд асгаралт үүсэж хуулсан хөрс, асгаралтыг шингээсэн шингээгч материал зэрэг нь аюултай хаягдлын төрөлд хамаарах тул төслийн талбайн аюултай хог хаягдлын цэгт цуглуулдаг ба нийт ажилчдад төслийн урьдчилсан зааварчилгаа болон ажил эхлэхийн өмнөх өглөөний хурлаар дамжуулан мэдээлэл олгон ажиллаж байна.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.
10		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад сургалтаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед авах арга хэмжээ болон асгаралт шингээгч иж бүрдлийг ашиглах заавар зэрэг	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.

					тусгагдсан байдаг ба нийт ажилтнуудад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1.1-р бүлгээс танилцана уу.	
11	Машин, механизмуудыг шатахуунаар цэнэглэх үед гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвч бохирдох	Төслийн талбайд барилгын ажилд ашиглах тоног төхөөрөмжийг шатахуунаар цэнэглэх тохиолдолд тусгай түлшний машин буюу авто цистернээр цэнэглэх ба гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг түлш цэнэглэх ажилд хяналт тавьж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн үндсэн барилга байгууламжийн суурийн ухлагын ажилд ашигласан гинжит экскаватор болон төслийн талбайд тог тасарсан тохиолдолд ажиллуулах зорилготой нөөц генераторыг цэнэглэх зорилгоор төслийн талбайд авто цистернээр түлш цэнэглэлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн. Түлш цэнэглэлтийн үе шатанд хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлж, тухай бүр гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хяналт тавьж ажилласан ба тайлант хугацаанд түлшний авто цистерн машинаас хөрсөнд асгаралт үүсгэсэн зөрчил бүртгэгдээгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.7.1-р бүлгээс харна уу.	Түлш цэнэглэлтийн үеийн хяналтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэдэг тул зардал гараагүй.
12	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяснаас хөрсөн бүрхэвч бохирдох	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө” нь ГБОНМТ-ний нэг дэд төлөвлөгөө бөгөөд төслийн гүйцэтгэгч нь тус төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хангуулан ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 8-р бүлгээс харна уу.	Энэхүү үйл ажиллагаатай холбогдох зардал нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.
13		Төслийн талбайд нэгдсэн хогийн цэг байгуулах ба хог хаягдлыг ангилан хаях хэсэгтэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ахуйн болон барилга угсралтын хог хаягдлын 2 тустай ангилан ялгалтын цэг байрладаг бөгөөд бид нийт 8 төрөлд хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах болон дахин боловсруулах боломжийг	Энэхүү үйл ажиллагаатай холбогдох зардал нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.

					нэмэгдүүлэн ажилладаг. Мөн гүйцэтгэгч нь төслийн талбайн хогийн цэгт цугларсан хог хаягдлыг тухай бүр төвлөрсөн хогийн цэгрүү тээвэрлэх ажил үйлчилгээний гэрээг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй байгуулсан бөгөөд хог хаягдлын бүртгэлийг баримтжуулж хадгалдаг. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 8-р бүлгээс танилцана уу.	
14		Төслийн талбайгаас гарах хүнд машин механизмын дугуйг угааж, цэвэрлэхээс бусад тохиолдолд төслийн талбайд машин механизм угаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд машин механизм угаахыг хориглох тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажиллагсдад хүргэдэг. Тайлант хугацаанд төслийн талбайд машин механизм угаасан зөрчил гараагүй.	Төслийн урьдчилсан зааварчилгааг гүйцэтгэгч зохион байгуулдаг тул зардал гараагүй болно.
15		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд хог ангилан хаях тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1 болон 8-р бүлгээс харна уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.
16		Хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тээвэрлүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь төслийн талбайн түр хогийн цэгээс хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт шилжүүлэх “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх гэрээ”-г СХД-ийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-тай байгуулсан.	Төслийн үйл ажиллагааны зардалд багтана.



17		Дахивар хаягдлыг ангилан ялгаж, дахивар хүлээн авах цэг болон байгууллагуудад хүлээлгэн өгөх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд цугларсан хуванцар, шил/лааз, цаас болон төмөр зэрэг дахивар хаягдлыг тогтмол дахин боловсруулах үйлдвэр болон дахивар хүлээн авах цэгүүдэд хүлээлгэн өгч ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 8-р бүлгээс харна уу.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.
18	Хүнд металл хром (Cr)-ын агууламж барилгын ажлын өмнөх хэмжээнээс нэмэгдэж болзошгүй тул барилгын талбайн	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь төслийн талбайд ажиллах ажилчдын хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь талбайн ХАБЭА-н үзлэгийг өдөр тутам хийж гүйцэтгэдэг бөгөөд хяналт, шалгалтын үед аливаа үл тохирол илэрсэн тухай бүр залруулах арга хэмжээг авч ажилладаг.	Энэхүү арга хэмжээнд гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хяналт тавьж ажиллах тул зардал гараагүй.
19	амьсгалын замаар болон арьсаар дамжин эрүүл мэндэд сөрөг нөлөөллүүдийг үүсгэх эрсдэлтэй	Төслийн 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан давтамж болон байршлын дагуу төслийн талбайн хөрсөнд хүнд металлын шинжилгээ хийлгүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн нийт 3 цэгээс хөрсний дээж авч, улирал бүр шинжилгээнд хамруулж байгаа ба тайлант хугацаанд хөрсөн дэх хүнд металлын агууламж нь холбогдох стандартын шаардлагыг 100% хангаж байгаа болно. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 9.4-р бүлгээс харна уу.	Энэхүү төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд тусгасан.
<b>Нийт</b>						-

#### 4.9.1 Хөрсөнд асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

УДБҮ-ийн төслийн талбайд баримталж буй “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний дагуу хадгалагдах болон ашиглагдаж буй аливаа химийн хортой болон аюултай бараа материалын ойролцоо асгаралтын үед ашиглах зорилготой асгаралт шингээгч иж бүрдлийг байрлуулж ажиллаж байна. Тайлант хугацаант нэмэлтээр 3 ширхэг асгаралтын иж бүрдлийн худалдан авалт хийгдсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 4 ширхэг асгаралтын иж бүрдэл төслийн талбайд байршсан байна. Үүнд дараах байршлууд орно:

- Насос станц №1 байгууламжийн баруун талд
- Химийн бодисын агуулахын хажууд
- Аюултай хог хаягдлын цэгийн хажууд
- Төслийн талбайд байрших генераторын хашаанд

Мөн төслийн гүйцэтгэгч нь хөрсөнд тоног төхөөрөмжийн тос маслын асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлж, төслийн талбайд машин механизм нэвтэрхээс өмнө үзлэг шалгалт хийж баталгаажуулдаг (4.2.4-р бүлэг).

Үүнээс гадна төслийн талбайд бетон цутгалтын ажил хийгдэх үед бетоны үлдэгдэл хөрсөнд асгарахаас сэргийлж, автопомп болон бетон зуурмагийн холигч машины доор дэвсгэр дэвсэж, хөрсөнд асгаралт үүсэхээс сэргийлж ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний баримтжуулсан зурган мэдээллийг доорх зургаас харна уу. Мөн бетон цутгалтын ажлын явцад үүссэн хаягдал бетоны үлдэгдэлийг урьдчилж бэлтгэсэн дэвсгэр дээр цуглуулж, төслийн талбайн барилгын хогийн цэгийн бусад ангилалын хэсэгт хаядаг бөгөөд тухай бүр нэгдсэн хогийн цэгрүү тээвэрлүүлж, устгалд оруулдаг.

Зураг 4-22: Бетон цутгалтын ажлын үед хөрсийг хамгаалж буй байдал



Хөрсөнд тос маслын болон бетоны асгаралт үүсэхээс сэргийлж, хучлага дэвссэн ажилладаг.



Бетон цутгалтын ажлын үед автопомп гацах тохиолдол үүссэн тул хөрсөнд бетоны асгаралт үүсэхээс сэргийлж, эрсдэл бүхий газруудад хучлага дэвсэж ажилласан.

#### 4.10 Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн талбай нь ШТЦБ-ийн барилгын ажлын нөлөөлөлд аль хэдийн өртөж, байгалийн унаган төрхөө алдсан ба барилгажих талбайгаас хуулах өнгөн хөрс, ургамлан нөмрөг байхгүй тул УДБҮ барих үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй гэж БОННУ-нд тусгасан байна.

УДБҮ-ийн цахилгааны ажлын хүрээнд төлөвлөгдөж байгаа Толгойт дэд станцаас төслийн талбай хүртэлх цахилгаан дамжуулах ажлыг газраар буюу кабель шугамаар шийдэх болсон хэдий ч энэхүү ажил нь 2024 онд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа ба 2023 онд тус ажил гүйцэтгэгдээгүй болно. Иймд, тайлант хугацаанд төслийн талбай дах харшил үүсгэх чадвартай хөл газрын ургамлуудыг цэвэрлэх, туслан гүйцэтгэгч нарын ашиглах бэлдцийн талбайг тэгшилж бэлтгэх ажлыг 5,000 м<sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэв. Энэхүү ажлын зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд хамаарна.

#### 4.11 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Эко Трейд ХХК-ны гүйцэтгэсэн БОННУ-нд дурдсанаар төслийн талбайд ажиглагдсан 2 зүйл мэрэгчид (Дагуур огдой, Үлийн цагаан оготно)-ийн мэдрэг байдал нь бага болон маш бага буюу бусад экосистемийн үйл ажиллагаанд чухал биш юм. Тиймээс эдгээрт үндэслэн УДБҮ-ийн төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшинг Бага гэж үнэлжээ. УДБҮ-ийн төслийн талбайд хийсэн тухайн үнэлгээгээр ямар нэгэн шувууны үүр илрээгүй байна. Мөн УДБҮ-ийн цахилгааны ажлын хүрээнд төлөвлөгдөж байгаа Толгойт дэд станц хүртэлх цахилгаан дамжуулах ажлын техникийн нөхцөл гарч тус ажлыг кабель шугамаар газраар шийдэх болсон ба энэхүү ажил нь 2024 онд хийгдэхээр төлөвлөгдөж байна. Иймд, 2023 оны амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 3 бүлэг ажлыг тайлант хугацаанд тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-10: Амьтны аймагт нөлөөлөх болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Төслийн газар шорооны ажлын үед төслийн талбайд ажиглагдсан мэрэгчид дайжих, тэдгээрийн нүх эвдрэлд өртөх	Мэрэгчид устах, дайжих болон тэдгээрийн нүх эвдрэлд өртөхөөс сэргийлэхийн тулд мэрэгч амьтад олноор бүртгэгдсэн шороон	Төслийн талбайд ажиглагдсан мэрэгчид, тэдгээрийн нүх	Бүрэн хэрэгжсэн	Тайлант хугацаанд төслийн гүйцэтгэгч нь үндсэн барилга байгууламжийн барилгын суурийн ухлагын ажил хийсэн бөгөөд тус ажил нь мэрэгч амьтад олноор бүртгэгдсэн шороон далангаас зайтай хийгдсэн. Иймд, мэрэгчид устах, дайжих болон	Төслийн үйл ажиллагааны зардалд багтана.

		далан, түүний ойролцоох газруудад шаардлагагүй газар хөндөлтөөс зайлсхийх			тэдгээрийн нүх эвдрэлд өртөх нөхцөл үүсээгүй болно.	
2	Барилгын үеийн дуу шуугиан, доргио чичиргээ нь төслийн талбайд ажиглагдсан хөхтөн амьтад, шувуудад саад учруулж болзошгүй	Дуу чимээний хэмжилтийг өдөр бүр заагдсан байршлуудад гүйцэтгэж, баримтжуулах	ОХШХ-г тусгагдсан байршлуудад	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн хүрээнд дуу чимээний хэмжилтийг автомат суурин багаж болон зөөврийн гар багаж ашиглан гүйцэтгэсэн. Хэмжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 9.2-р бүлгээс харна уу.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан.
3	Ил задгай хаясан хоолны үлдэгдэл дээр амьтан ихээр цугларах	УДБҮ-ийн төслийн гал тогооноос гарах хоолны үлдэгдлийг төслийн талбайн хогийн цэгт битүү тагтай саванд хийж хаях ба эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тогтмол тээвэрлүүлж, устгалд оруулах	Төслийн талбайд байршуулсан хүнсний хаягдлын хогийн сав болон тогтмол тээвэрлүүлж, устгалд оруулах арга хэмжээний биелэлт	Тогтмол хэрэгжүүлж байна	Ил задгай хаясан хоолны үлдэгдэл дээр амьтан ихээр цугларахаас сэргийлж, түр оффисын гал тогооноос гарсан хүнсний хаягдлыг ууталж, амсарыг сайтар боосны дараа төслийн талбайн баруун хойно байрлах ахуйн хаягдлын нэгдсэн цэгт хадгалсан. Тайлант хугацаанд төслийн талбайд ил задгай хаясан хоолны үлдэгдлийн зөрчил илрээгүй болно.	-
					<b>Нийт</b>	-

#### **4.12 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

Төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Тиймээс энэ төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно (БОННУ, Эко Трейд ХХК).

#### **4.13 Дуу шуугианаас нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

БОННУ-нд тусгаснаар дуу шуугианд хамгийн их өртөгчид бол барилгын ажилчид, төслийн талбайд ойр байрлах аж ахуйн нэгжүүд байна. Дуу шуугианы голомтод эрчим нь 93 дБ хүрэх боломжтой тул дуу шуугианы тархалтын нөлөөгөөр амьтад, тухайлбал мэрэгч, шувууд дайжих эрсдэлтэй боловч төслийн талбай нь олон төрлийн шувууд, ховор болон нэн ховор амьтдын амьдрах орчин биш юм. Харин одоо байгаа мэрэгч, зарим төрлийн шувууд нь хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд аль хэдийн өртсөн, тухайн орчиндоо дасан зохицох чадвартай болсон. Эдгээр амьтад нөлөөлөлд өртөж, дайжих тохиолдол гарсан ч барилгажилтын үе богино тул эргэн суурьших боломжтой.

Тиймээс 2023 онд дуу шуугианаас нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд барилгын ажилчид болон УДБҮ-ийн төслийн талбайн шууд нөлөөллийн бүсэд байрлах аж ахуйн нэгжүүдийг анхаарч дараах 5 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Ажилчид болон УДБҮ барих талбай орчмын иргэд, аж ахуйн нэгжүүд ашиглагдах машин техник, барилгын үйл ажиллагаанаас ялгарах дуу шуугианы сөрөг нөлөөлөлд өртөх	Ажилчдын шуугианы даралтын эквивалент түвшин 80 дБ болон үүнээс өндөр шуугианы нөлөөлөлд байх тохиолдолд сонсгол хамгаалах хэрэгсэл буюу чихний бөглөө заавал хэрэглүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	80 дБ болон үүнээс өндөр шуугианы нөлөөлөлд өртөх тохиолдолд хэрэглэх 200 ш чихний бөглөөний бэлэн байдлыг хангаж төслийн талбайд байршуулсан.	132,000 (200 ш * 660₮)
2		Төслийн талбайд дуу шуугианы хэмжилтийг зөөврийн хэмжигч төхөөрөмжөөр өдөр бүр хийж, баримтжуулах	УДБҮ-ийн төслийн талбай болон нөлөөллийн бүсийн ойр орчим	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь дуу чимээний хэмжилтийг өдөр бүр гүйцэтгэж, төслийн өдрийн тайланд мэдээллийг оруулан ажиллаж байна.	Дуу чимээ хэмжигч зөөврийн багажийг 2022 онд худалдан авсан тул тайлант хугацаанд зардал гараагүй.
3		Туслан гүйцэтгэгчдийн хөдөлгүүрийн яндангийн дуу чимээ ихтэй хүнд машин механизмуудад тохирох дуу намсгагч суурилуулахыг шаардах ба хэрэгжилтийг хангуулах (Ажил гүйцэтгэх гэрээнд шаардлагыг тусгасан байх)	УДБҮ-ийн төслийн талбайд ашиглах хөдөлгүүрийн яндангийн дуу чимээ ихтэй хүнд машин механизм	Тогтмол хэрэгжүүлж байна	Ажил гүйцэтгэх гэрээнд холбогдох шаардлагыг тусгасан ба тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
4		Гомдол гарсан тохиолдолд GRM-гомдол барагдуулах	УДБҮ-ийн төслийн талбай,	Тогтмол хэрэгжүүлж байна	Гомдол хүлээн авах сувгуудын мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаанд	GRM-гомдол барагдуулах механизмын хэвийн

		механизм (Бүдүүвч 2)-ын дагуу шийдвэрлэх ба GRM-ийн талаарх мэдээллийг нийт ажилтан, нөлөөллийн бүсийн ААН болон бүхий л оролцогч талуудад нээлттэй байлгах	оролцогч талууд		багтаасан ба нийт ажилчдад мэдээлэл хүргэж ажиллаж байна. Мөн төслийн хэмжээнд санал, гомдол хүлээн авах утсыг 24/7 цагийн турш ажиллуулж байна. Тайлант хугацаанд байгаль орчны асуудлаар санал, гомдол бүртгэгдээгүй байна.	ажиллагаатай холбоотой үүсэх зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
5		Дуу чимээ, доргио чичиргээний өртөлт болон тэдгээрийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан нийт ажилтнуудад мэдээлэх, сонсгол хамгаалах хэрэгслийн хэрэглээг идэвхжүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгаанд дуу чимээ, чичиргээний үед ашиглах хувийн хамгаалах хэрэгслийн мэдээлэл багтсан бөгөөд төслийн талбайд ХАБЭА-н ажилтан хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээнд хяналт, шаардлага тавин ажиллаж байна.	-
					<b>Нийт</b>	<b>132,000</b>

#### **4.14 Цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал уснаас гарах үнэрээс нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

УДБҮ-ийн төслийн талбай нь төв цэвэрлэх байгууламжийн баруун талд байрладаг бөгөөд төслийн талбай орчмоос хүхэрт устөрөгч ( $H_2S$ )-ийн үнэр үнэртдэг. Энэхүү хийн эх үүсвэр ТЦБ-ын одоогийн ашиглаж байгаа лаг хатаах талбай юм. Хүхэрт устөрөгч нь өнгөгүй, муудсан өндөгтэй төстэй үнэртэй, агаараас 1.19 дахин хүнд, маш хортой, идэмхий, шатамхай, тэсрэмтгий хий бөгөөд агаараас хүнд учир агааржуулалт муутай орчны ёроолд хуримтлагдах хандлагатай.

Тиймээс, гүйцэтгэгч нь 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 02-ны хооронд “Ус дахин боловсруулах үйлдвэрийн барилгын ажил хийгдэх төслийн ажлын байруудын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-г Хэлт энд Сэфти Солушинс ХХК мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Тус ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнгээр үнэлгээнд хамрагдсан бүх ажлын байр “Хэвийн” нөхцөлтэй үнэлэгдсэн.

Хэдийгээр УДБҮ-ийн төслийн ажлын байр нь хэвийн нөхцөлтэй үнэлэгдсэн ч ТЦБ-ын лаг хатаах талбайгаас ялгарч буй хүхэрт устөрөгчийн хий нь УДБҮ-ийн төслийн барилгажилтын явцад төслийн ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй тул 2023 онд дараах 5 бүлэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Төслийн талбайд үнэртдэг хүхэрт устөрөгч нь төслийн нийт ажилчдын эрүүл мэнд, ажиллах орчинд сөргөөр нөлөөлөх	УДБҮ-ийн төслийн хүрээнд үнэрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	“Үнэрийн менежментийн төлөвлөгөө”-нд төслийн талбай дах үнэрийн нөлөөллөөс ажилчдын эрүүл мэндийг хэрхэн хамгаалах болон үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө тусгагдан боловсруулагдсан. Тус төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна.	Төслийн гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулсан тул нэмэлт зардал гараагүй.
2		Төслийн талбайд өдөр бүр зөөврийн багажаар хүхэрт устөрөгчийн хэмжилтийг хийж, 2ppm-ээс давсан тохиолдолд нийт ажилтнуудад мэдээлдэг байх. Мэдээлэл дамжуулах хэлбэр нь өглөөний цугларалт/pre-start meeting, viber, мэдээлэх самбар дээрх H <sub>2</sub> S үзүүлэлтийн хэмжээ гэх мэт.	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд хүхэрт устөрөгчийн хэмжилтийг зөөврийн багажаар болон суурийн автомат багажаар хэмжиж байгаа ба 2 ppm давсан тохиолдол илрээгүй байна. Хэмжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 9.1-р бүлгээс харна уу.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсан.
3		Төслийн талбайд ашиглах шүүлтүүртэй маскийн бэлэн байдлыг хангах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ковид-19 цар тахлаас сэргийлэх үүднээс амны хаалтыг төслийн талбайд тогтмол байршуулж, нөөцөөр ханган ажиллаж байна. Мөн үнэрийн менежментийн хүрээнд төслийн талбайд 100 ш	720,000 (100 ш * 7,200₮)

					шүүлтүүртэй маск худалдан авч, бэлэн байдлыг хангасан.	
4		Хүхэрт устөрөгчийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нийт ажилтнуудад таниулах, мэдээлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	2023 оны 12-р сард багтаан тус мэдээллийг хүргэхээр төлөвлөж байна.	-
5		Оффист байрлах агааржуулагчийн шүүлтүүрийг улиралд 1 удаа тогтмол давтамжтай цэвэрлэдэг байх	УДБҮ-ийн төслийн талбайн оффис	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгчийн үйлчлэгч нар нь оффист байрлах агааржуулагчийн шүүлтүүрийг улирал бүр авч, цэвэрлэж байна.	-
					<b>Нийт</b>	<b>720,000</b>



#### 4.15 Нийгэм эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэд, нийгэм, эдгийн засгийн үр шимийг тэгш хүртэх, болзошгүй нийгэм, жендэрийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (ГБОНМТ)”-г ОУСК, Дэлхийн банк, МСК болон Монголын МСС-гийн шаардлагын дагуу боловсруулан, захиалагчаар хянуулж, батлуулсан. Энэхүү ГБОНМТ нь нийгэм, жендэрийн асуудлаар тусгайлсан нийт 6 менежментийн төлөвлөгөөнөөс бүрдэх ба үүнд дараах төлөвлөгөөнүүд багтана.

1. Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөө  
Энэхүү төлөвлөгөө нь УДБҮ-ийн төсөл хэрэгжих хугацаанд нийгэм, жендэрийн асуудалтай холбогдох дүн шинжилгээ, оролцоо, хүний нөөц, шаардлагатай сургалтууд, жендэр, нийгмийн оролцоотой холбогдох асуудлууд, салбарын хүрээний холбогдох эрсдэлүүдийг тусгаснаас гадна эмэгтэйчүүд болон бусад бүлгүүдийн хүртэж болохуйц үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлсон.
2. Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө  
Тус төлөвлөгөөний зорилго нь ажилтнуудынхаа хөдөлмөрийн харилцааг мэргэжлийн түвшинд удирдахаас гадна Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөөнд тусгагдсан эмэгтэй ажилчдын оролцоог 30%-д хүргэх, орон нутгийн ажилчдыг богино хугацаанд ажиллуулах боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд эрх тэгш, аюулгүй, зохистой орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
3. Сургалтын төлөвлөгөө  
Сургалтын төлөвлөгөөний зорилго нь Гүйцэтгэгч төслийн сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй удирдах, ажилтнууд болон оролцогч талуудад байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, нийгэм, жендэрийн холбогдох сургалт, мэдлэг, мэдээлэл, ур чадварыг олгоход оршино.
4. Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө  
Тус төлөвлөгөөний зорилго нь төслийн туршид оролцох оролцогч талуудын хоорондын харилцааг тууштай, тодорхой зохистой түвшинд байлгах буюу оролцогч талуудад үнэн зөв шаардлагатай мэдээллийг өгөх, тайлагнах, санал хүсэлтийг цуглуулах, шаардлагатай бол харилцаа холбоо тогтооход оршино.
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх төлөвлөгөө  
Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Гүйцэтгэгч нь төсөл хэрэгжих хугацаанд Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, ХХГХ-тэй холбоотой зөрчил гомдлыг хүлээж авах, шийдвэрлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах боломж бүрдэх юм.
6. Гомдол барагдуулах механизм  
Гомдол барагдуулах механизмын зорилго нь орон нутгийн иргэд, ажилчид, ханган нийлүүлэгчид, туслан гүйцэтгэгчид болон нөлөөлөлд өртсөн бүхий л оролцогч талуудад бүх төрлийн гомдол гаргах болон гүйцэтгэгч нь тухайн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх боломжийг олгоход оршино.

##### 4.15.1 Оролцогч талуудын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах

М-Си-Эс Проперти ХХК нь Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн хүрээнд засгийн газар буюу холбогдох салбарын яам, хэрэгжүүлэгч агентлагаас эхлээд орон нутгийн иргэд хүртэл олон төрлийн оролцогч талуудтай хамтран ажиллахаар төлөвлөсөн.

Эдгээр оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах, зөвлөлдөх боломжийг бий болгох зорилгоор Оролцогч талуудын менежментийн төлөвлөгөө боловсруулан Захиалагчаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 9-р сарын байдлаар дараах оролцогч талуудад чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд;

- Захиалагч буюу Мянганы сорилтын сан (МСС)-ийн техникийн болон өргөтгөсөн хурал уулзалт, 7 хоногийн болон сар бүрийн тайлан мэдээ бэлтгэн илгээх
- СХД-ийн 20-р хорооны иргэдийн уулзалт зохион байгуулсан
- СХД-т үйл ажиллагаа эрхэлж буй болон эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд чиглэсэн уулзалт семинар зохион байгуулсан
- Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан (Хүйсийн тэгш эрхийн төв, Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв)
- Их дээд сургуулиудын хөдөлмөрийн яармагт оролцож мэдээлэл түгээсэн
- СХД-ийн 20-р хорооны Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран төслийн сул орон тооны талаарх мэдээлэл түгээсэн

#### 4.15.2 Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах

Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн хэрэгжилттэй холбоотой орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой дараах таван зорилго бүхий нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

- Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах;  
**Нийт ажилчдын 43% буюу 251 орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байна.**
- Нийт ажилчдынхаа 30 ба түүнээс дээш хувьд эмэгтэйчүүдийг авч ажиллуулах, сургахыг дэмжих;  
**Нийт ажилчдын 20.9% буюу 109 эмэгтэйг 11 төрлийн ажлын байранд авч ажлуулж байна.**
- Орон нутгийн болон эмэгтэй эзэмшигчтэй Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих;  
**Нийт 176 төслийн нөлөөллийн бүст үйл ажиллагаа эрхэлж буй болон 52 эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжээс ажил үйлчилгээ авсан.**
- Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн болон Их дээд сургуулийн төгсөгчдийн ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх, дадлага хийх боломжийг бий болгох  
**Нийт 5 оюутан цалинтай дадлага хийснээс 2 нь ажлын байрны санал авсан.**
- Ус дахин боловсруулах төсөлтэй холбоотой нийгэм жендэрийн эрсдэлийг, тодорхойлох нөлөөллийг бууруулах;  
**Хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүн худалдаалах гэмт хэрэг болон ажлын байрны бэлгийн дарамтыг үл тэвчих бодлого боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.**

#### 4.15.3 Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах

Ус дахин боловсруулах үйлдвэрийн нийт ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн түвшинд удирдах, хяналт тавих мөн Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Гүйцэтгэгч нь Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Үүнд;

- Ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод болгох замаар бүх ажилчдад эрх тэгш боломжийг бий болгосон.
- Төслийн нийт ажилчид хууль ёсны хөдөлмөрийн болон холбогдох гэрээг байгуулан ажиллаж байна.
- Төсөлд эмэгтэй ажилчдын оролцоог нэмэгдүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулсан
- Дадлага болон дагалднаар ажиллах боломжийг бий болгосон.
- Ажилчдыг мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамруулсан.
- Ажил эхлэхээс өмнө бүх ажилчдыг ХАБЭА, байгаль орчин, нийгэм жендэрийн урьдчилсан зааварчилгаанд хамруулж байна.
- Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран ажилчдыг Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн сургалт 6 сар тутамд хамруулж байна

- Ажилчдын аюулгүй, таатай ажиллах орчинг бий болгож хүйсээр ангилсан хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, амрах хэсэг, усанд орох хэсэг болон анхны тусламжийн өрөөг барьж байгуулж тохижуулсан.

## **5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Ус дахин боловсруулах үйлдвэр (УДБҮ)-ийн төслийн талбай нь Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын нөлөөлөлд аль хэдийн өртөж, байгалийн унаган төрхөө алдсан ба барилгажих талбайгаас хуулах өнгөн хөрс, ургамлан нөмрөг байхгүй талбайд баригдана.

УДБҮ-ийн төслийн барилга угсралтын ажлын дараах орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж эхлэх хугацаа 2024 оны 5-р сараас эхэлж байгаа тул 2023 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ямар нэгэн ажил хийгдээгүй болно.

## **6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан төслийн нийт ажилчдад санамсаргүй байдлаар түүх дурсгалын үнэт өв илрүүлсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний мэдээллийг хүргэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1 хэсгээс харна уу. Тайлант хугацаанд төслийн талбайгаас ямар нэг палеонтологи болон археологийн олдвор илрээгүй.

## **7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 онд УДБҮ-ийн төслийн барилгын ажлын үе шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг доорх хүснэгтэд тусгав. Осол, аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилав. Үүнд:

- Үйлдвэрийн буюу барилгын үйл ажиллагааны явцад үүсэх осол
- Гал түймэр гарах
- Химийн хортой болон аюултай бодис асгаралт
- Тээврийн хэрэгслийн осол гарах
- Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс /ган, үер/ болон газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгаас үүдэн төслийн талбайн үйл ажиллагаа доголдох, зогсох
- Халдварт өвчний тархалт

Иймд, 2023 онд осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах 32 бүлэг ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Барилгын үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж барилгын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Удирдлагын баг; ХАБЭА-н баг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн барилга угсралтын үе шатанд төслийн ХАБЭАБО-ны баг хөдөлмөр хамгааллын аюулгүй байдалд өдөр бүр хяналт тавин, төслийн ХАБЭА-н төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үл тохирол үүсэхээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
2		Хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах	БУ-ын баг; ХАБЭА-н баг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭАБО-ны баг нь талбайн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хяналтыг өдөр бүр гүйцэтгэдэг бөгөөд тус хяналтаар хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянаж ажиллаж байна.	
3		Нийт ажиллагсад компанийн “Алтан дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллах	Төслийн нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	Алтан дүрмийн мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулан нийт ажилчдад мэдээлэл түгээж байгаа бөгөөд өдөр тутамд дагаж мөрдөхийг уриалан ажиллаж байна.	Төслийн урьдчилсан зааварчилгаа болон өндөр эрсдэлтэй ажлын сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг олгох тул зардал гарахгүй.
4		Төслийн талбайд шинээр ирж буй ажилтныг төслийн урьдчилсан зааварчилгаанд заавал хамруулах ба өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх ажилтнуудыг өндөр эрсдэлийн сургалтад хамруулснаар төслийн	Нийт ажилчид; өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд нийтдээ 618 шинэ ажилтан 112 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан байгаль орчны мэдлэг олгох сургалтад хамрагдсан байна.	

		талбайд ажил хийх эрх олгох; Нийт ажилтны ХАБЭА-н сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах				
5		Төслийн талбайд анхны тусламж үзүүлэх өрөө тохижуулж, тоноглон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн гүйцэтгэгчийн түр оффист анхны тусламж үзүүлэх өрөө тохижуулж, тоноглон ба дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 7.1-р бүлгээс харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
6		Төслийн талбайд анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшиж, сертификатаар баталгаажсан ажилтнуудтай байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	УДБҮ-ийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшиж, сертификатаар баталгаажсан нийт 4 ажилтан ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
7		Төслийн талбайд ашиглах машин, механизмын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, баримтжуулсан байх	УДБҮ-ийн төслийн талбайд ашиглах машин, механизм тээврийн хэрэгслүүд	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэх тул зардал гарахгүй.
8		Зохих стандартын шаардлага хангасан хайс, хашлага, замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай гэж үзсэн газруудад байрлуулах	УДБҮ-ийн төслийн барилгажилтын талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭА-н баг нь төслийн талбайд үүссэн ил нүх, аюул бүхий хэсгүүдэд тухай бүр хатуу хаалт хашилт болон анхааруулах мэдээллийн хуудас байрлуулан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн төслийн талбайд зохих замын тэмдгүүд байршуулсан.	400,000 (5 ш * 80,000)



9	Гал түймэр	Төслийн талбайд тамхи татах тусгай цэг төлөвлөх ба бусад зөвшөөрөгдөөгүй газар тамхи татахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд тамхи татах тусгай 3 цэгийг байршуулан тэмдэгжүүлсэн ба бусад зөвшөөрөгдөөгүй газар тамхи татахыг хориглож ажиллаж байна.	Төслийн талбайд тамхины цэгийг 2022 онд байгуулсан тул 2023 онд нэмэлт зардал гараагүй.
10		Аливаа халуун боловсруулалтын ажлыг галын харуул болон гал унтраагуур байрлуулан гүйцэтгэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭА-н баг хэрэгжилтийг тогтмол хангуулан ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
11		Стандартын шаардлагын дагуу гал унтраах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Түр байгууламжид 50 м <sup>2</sup> тутамд 1 галын хор байршуулсан бөгөөд галын хорын ашиглалтын бэлэн байдалд төслийн ХАБЭА-н баг хяналт тавин үзлэг, шалгалт хийн ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
12		Төслийн талбайд хог шатаах болон ил задгай гал гаргахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
13	Химийн бодисын зохисгүй хадгалалт, болон химийн бодисын асгаралт үүсэх	Химийн бодисын асгаралт шингээх иж бүрдэл төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн 4 байршилд химийн бодисын асгаралт шингээгч иж бүрдлийг байршуулан, сар бүр үзлэг шалгалт хийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.
14		Төслийн талбайд нэвтрэх химийн бодис бүр ХАЛМ-тэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх химийн бодисуудын ХАЛМ-ын хураангуй тайланг бэлтгэн, холбогдох ажилчдад танилцуулан ажиллаж байна.	Химийн бодисын нийлүүлэгч компаниас олгогдох тул зардал гараагүй.
15		Барилгын ажилд ашиглах химийн бодис бүрийг ХАЛМ-д заасан шаардлагыг хангасан нөхцөлд зориулалтын	УДБҮ-ийн төслийн талбайн химийн бодисын агуулах	Бүрэн хэрэгжсэн	Төслийн гүйцэтгэгч нь барилга угсралтын үе шатанд ашиглах химийн бодис хадгалах зориулалт бүхий химийн бодисын агуулахыг тохижуулж ашиглалтанд оруулсан ба СХД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсийн улсын	Гүйцэтгэгч нь 40 тн багтаамж бүхий өөрсдийн бэлэн контейнерыг зориулалтын дагуу тоногдсон ба тус

		химийн бодисын агуулахад хадгалах			байцаагч нарт шалгуулсан. Шалгалтын үр дүнд Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хүрээнд барилга угсралтын ажилд ашиглагдах бараа материал, химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад дотоод хяналтаа хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн.	зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
16		Төслийн талбайд 2023 онд барилга угсралтын үйл ажиллагаанд ашиглахаар урьдчилан тооцсон химийн бодис дотор “Аюултай” ангилалд хамаарах даралтад савласан хий болох хүчилтөрөгч багтсан байгаа тул тус хийг ашиглах болон хадгалах үед аюулгүй ажиллагааг төслийн “Гал түймрээс сэргийлэх төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу хангаж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байна	Тайлант хугацаанд барилга угсралтын ажлын явцаас хамааран даралтад савласан хийг төслийн талбайд ашиглах нөхцөл байдал үүсээгүй.	Гүйцэтгэгчийн ХАБЭА-н төсөвт багтана.
17		Химийн хорт болон аюултай бодисын ангилалд багтсан бодисыг төслийн талбайд хадгалах, ашиглах, устгахдаа “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг мөрдөж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбайд ашиглах химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүн	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ашиглагдах химийн бодис бүр гүйцэтгэгчийн химийн бодисын агуулахад хадгалагдаж буй бөгөөд тухайн химийн бодисыг барилга угсралтын ажилд ашиглахдаа тухайн ажлыг гүйцэтгэх ажлын багийн гишүүн бүр ХАЛМ-тэй танилцаж, холбогдох аюул болон хяналтын арга хэмжээг ажлын аюулын дүн шинжилгээнд тусгасны дараа ашиглаж байна. Мөн төслийн гүйцэтгэгч нь аюултай хаягдлыг тээвэрлэх, устгах ажил үйлчилгээний гэрээг тусгай зөвшөөрөл бүхий Элемент ХХК-тай байгуулсан.	Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах зардал нь төслийн ХАБЭА-н болон үйл ажиллагааны зардалд багтана.

18		Төслийн талбайн химийн бодисын агуулахад эрх бүхий мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргуулж авах	УДБҮ-ийн төслийн талбайн химийн бодисын агуулах	Бүрэн хэрэгжсэн	Барилга угсралтын үе шатанд ашиглах химийн бодисын түр агуулахыг дотоод хяналтаа хэрэгжүүлэн ашиглах тухай зөвшөөрлийг 2023 оны 6-р сарын 8-ны өдөр буюу химийн бодисын агуулахыг ашиглаж эхлэхээс өмнө СХД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсээс авсан.	Холбогдох байгууллагад албан хүсэлт хүргүүлэн зөвшөөрлийг авсан тул зардал гараагүй.
19		Химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтанд тогтмол хяналт тавих	УДБҮ-ийн төслийн талбайн химийн бодисын агуулах	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь захиалагч талын байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран сард 1 удаа химийн бодисын агуулахын үзлэг шалгалтыг гүйцэтгэдэг бөгөөд тус үзлэг шалгалтаар химийн бодисын хадгалалт, ашиглалт зэрэгт хяналт тавин ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.2.2-р бүлгээс харна уу.	Төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
20		Химийн бодистой харьцах, асгаралтаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг олгох сургалтыг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажилтанд олгох	УДБҮ-ийн төслийн нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад химийн бодистой харьцах, асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед авах арга хэмжээ болон асгаралт шингээгч иж бүрдлийг ашиглах заавар зэрэг тусгагдсан байдаг ба нийт ажилтнуудад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1.1-р бүлгээс танилцана уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг орох тул зардал гарахгүй.
21	Тээврийн хэрэгслийн осол	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах ба төслийн талбайд хурдны дээд хязгаарыг 10 км/ц-аас хэтрүүлэхгүй байх	УДБҮ-ийн төслийн талбайд нэвтрэх нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө” батлагдсан бөгөөд талбайд холбогдох тэмдэг, тэмдэглээг байршуулан, хурдны хязгаарт хяналт тавин ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.6.1-р бүлгээс харна уу.	Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.

22		Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг баримталж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбайд нэвтрэх нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө” батлагдсан бөгөөд жолооч нарт тавигдах шаардлагыг ажил үйлчилгээний гэрээнд тусгаж, шаардлага тавин ажиллаж байна.	-
23		Төв замаар зүүнээс баруун тийш яваа тээврийн хэрэгсэл УДБҮ-ийн төслийн талбай руу хүрэх туслах зам руу орохдоо зүүн гар тийш эргэж ордог тул замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж осолд холбогдох, эсвэл осолд орох эрсдэлтэй. Иймд, барилга угсралтын үйл ажиллагаа эхэлж, төслийн талбайг зорих аливаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрчимжихээс өмнө тус асуудлыг шийдэж, ажилчдад мэдээлэл өгөх	УДБҮ-ийн төслийн талбайд нэвтрэх нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь Нийслэлийн авто замын хөгжлийн газартай уулзаж, төв замаар зүүнээс баруун тийш яваа тээврийн хэрэгсэл УДБҮ-ийн төслийн талбай руу хүрэх туслах зам руу орох хэсэгт тасархай шугам бий болгох боломжтой эсэх талаар хэлэлцсэн хэдий ч зөвшөөрөл олгоогүй байна. Иймд, төслийн гүйцэтгэгч нь нийт ажилтнуудад төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан анхаарал болгоомжтой зорчих анхааруулга өгөн ажиллаж байна.	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг төслийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэх тул нэмэлт зардал гарахгүй.
24	Цаг агаарын гэнэтийн үзэгдэл /ган, үер/ болон газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгаас	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн талбайн бэлтгэл ажлын явцад тогтмол ашиглах	Улаанбаатар хот, УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Шаардлагатай тохиолдолд төслийн талбайн ажлыг урьдчилан төлөвлөхөд ашиглаж байна.	Зардал төлөвлөх шаардлагагүй. Tsag-agaar.gov.mn-ээс цаг агаарын урьдчилсан мэдээг авч үйл ажиллагаандаа ашиглана.
25	үүдэн төслийн талбайн үйл ажиллагаа	Төслийн талбайд газар хөдлөлт болсон тохиолдолд авч	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны	Гүйцэтгэгчийн төслийн ХАБЭА-н зардалд багтана.

	доголдох, зогсох	хэрэгжүүлэх арга хэмжээ болон төслийн талбайн цуглах цэгийн байршил, таних тэмдэгийн талаар мэдээллийг нийт ажилчдад төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан мэдээлэх			сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад онцгой байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон холбоо барих ажилтан, утасны жагсаалт, цуглах цэгийн байршил зэрэг мэдээлэл тусгагдсан байдаг. Мөн урьдчилсан зааварчилгаанд хамрагдсан нийт ажилтнуудад каскан дотроо хийх онцгой байдлын үеийн утасны жагсаалт, гал гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээ болон талбайн зохион байгуулалтын зураг бүхий мэдээллийн хуудсыг тарааж ажиллаж байна.	
26	Халдварт өвчин тархах (Ковид-19 халдварын тархалт дахин дэгдэх)	Ковид-19 халдвараас сэргийлж KN95/ N95/ P2 төрлийн амны хаалт зүүх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд амны хаалтын бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн төслийн ХАБЭА-н зардалд багтана.
27		Оффисын орчинд гар ариутгагч байршуулах ба гар угаах саванг ариун цэврийн өрөөнд байршуулж, ажилчдын гар угаах боломжийг бүрдүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ариун цэврийн өрөөнүүдэд гар угаах хэрэгслийн бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна.	
28		Ковид-19 халдварт өвчний түргэн оношлуурын бэлэн байдлыг хангах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд Ковид-19 халдварт өвчний түргэн оношлуурын бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна.	
29		Ковид-19 эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ковид-19 эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг төслийн “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний 6.6.10 хэсэгт тусгасан бөгөөд тус төлөвлөгөө нь 2022.10.13-ны өдөр батлагдсан. Төслийн барилга угсралтын үе шатанд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	
30	БОННУ-ээр УДБҮ-ийн төслийн	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг нь төслийн талбайд	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭАБО-ны баг нь талбайн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хяналтыг өдөр бүр гүйцэтгэдэг бөгөөд тус	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг төслийн



	талбайн хөрсөнд хүнд металл хром (Cr)-ын агууламж стандартын зөвшөөрөгдөх түвшинөөс давсан үзүүлэлттэй гарсан тул барилгын талбайн	ажиллах ажилчдын хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах ба ялангуяа хөрс, чулуулагтай шууд харьцаж ажиллах ажилчдад N95 амны хаалт болон бээлийтэй ажиллаж буй эсэхэд хяналт тавих			хяналтаар хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянаж ажиллаж байна.	ХАБЭАБО-ны баг гүйцэтгэх тул нэмэлт зардал гарахгүй.
31	талбайн ажилчдын амьсгалын замаар болон арьсаар дамжин эрүүл мэндэд нь сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй	Хөрс, чулуулагтай шууд харьцаж ажилласны дараа гараа тогтмол угааж хэвшихийг нийт ажилчдад мэдээлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Нийт ажилчдад хувийн ариун цэврийг сахиж, гараа тогтмол угааж ариутгаж байх тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаа, өглөөний хурал эхлэхийн өмнөх хурал болон ариун цэврийн өрөөнд байршуулсан мэдээлэх хуудсуудаар дамжуулан тогтмол мэдээлэл хүргэн ажиллаж байна.	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг төслийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэх тул нэмэлт зардал гарахгүй.
32		Төслийн талбайд тоосжилт дарах усалгааг дулааны улиралд тогтмол хэрэгжүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд 4-р сараас 10-р сарын хугацаанд зам, талбайн тоосжилт дарах усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн ба тайлант хугацаанд нийт 438.65 м <sup>3</sup> ус ашигласан.	Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө хэсэгт тусгасан.
					<b>Нийт</b>	<b>400,000</b>

## 7.1 УДБҮ-ийн төслийн анхны тусламжийн өрөө болон анхны тусламж үзүүлэгчдийн мэдээлэл

УДБҮ-ийн төслийн талбайд анхны тусламж авах тохиолдол үүссэн нөхцөлд ашиглах зорилготой анхны тусламжийн өрөөг тохижуулж бэлэн болгосон бөгөөд тус өрөөний зурган мэдээллийг доорх Зураг 7-1-т харуулав. Тус өрөө нь төслийн гүйцэтгэгчийн түр оффисын нэг давхарт байршдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх эрх бүхий сертификаттай, томилогдсон ажилтан ашиглах боломжтой байхаар зохицуулж, өрөөний түлхүүрийг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хадгалдаг.

Зураг 7-1: УДБҮ-ийн төслийн анхны тусламжийн өрөө



УДБҮ-ийн төслийн анхны тусламж үзүүлэх өрөөний харагдах байдал





Шаардлагатай тохиолдолд ашиглах эвхэгддэг дамнуурга болон хаалт



Анхны тусламж үзүүлэх хэрэгслэлийн бэлэн байдал

УДБҮ-ийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэгчийн сургалтад хамрагдаж, сертификаттай, төслөөс томилогдсон нийт 4 ажилтан байгаа бөгөөд тухайн ажилтнуудын холбогдох мэдээллийг доорх Хүснэгт 7-2-т нэгтгэн харуулав.

Ажилтны нэр	Анхны тусламж үзүүлэгчийн сертификат	Анхны тусламж үзүүлэгчийн ТОМИЛГОО
<p>Б.Ганзолбоо /Талбайн зохицуулагч/</p>		<p>MCSproperty Wastewater Recycling Plant Project</p> <p><b>ХАБЗАБО-НЫ АЛБАН ТУШААЛЫН ТОМИЛГОО</b> LETTER OF APPOINTMENT TO HSE ROLE</p> <p>АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ / М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК FIRST AIDER – WASTEWATER RECYCLING PLANT PROJECT / MCS PROPERTY LLC</p> <p>Талбайн зохицуулагч Батбаяр овогтой Ганзолбоо-г дээр дурдсан албан тушаалд 2023 оны 03 сарын 02-ны өдрөөс эхлэн томилох болохыг баталж байна. This letter is to confirm that Ganzolboo Batbayar, Site Supervisor, MCSPP appointed to the role identified above effective from 02 March 2023.</p> <p>Томилгогдон өмчитэн нь Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй тусламжийг үзүүлэн ажиллана. The dedicated first aider shall provide immediate assistance in the event of an emergency situation requiring first aid at the Wastewater Recycling Plant Project site.</p> <p>Батбаяр овогтой Ганзолбоо нь энэхүү ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтанд (Анхны тусламж үзүүлэгчийн сургалт) хамрагдаж амжилттай суралцсан болно. Ganzolboo Batbayar has successfully completed the required training (First Aider) to hold this role.</p> <p>Энэхүү томилгоог хүлээн зөвшөөрч ойлгосон гэдгээ нотолж дор гарын үсэг зурна уу. Please sign and date below to indicate your acceptance and understanding of this appointment.</p> <p>Томилгогдон/ Appointee: Б.Ганзолбоо /Талбайн зохицуулагч/ Гарын үсэг / Signature: <i>B. Ganzolboo</i> Огноо / Date: 2023.03.02</p> <p>Баталсан / Approver: О.Батзориг /Төслийн менежер/ Гарын үсэг / Signature: <i>O. Batzorig</i> Огноо / Date: 2023/03/02</p> <p>1/1</p>
<p>Н.Дармаадалай /Шугам хоолойн инженер/</p>		<p>MCSproperty Wastewater Recycling Plant Project</p> <p><b>ХАБЗАБО-НЫ АЛБАН ТУШААЛЫН ТОМИЛГОО</b> LETTER OF APPOINTMENT TO HSE ROLE</p> <p>АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ / М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК FIRST AIDER – WASTEWATER RECYCLING PLANT PROJECT / MCS PROPERTY LLC</p> <p>Шугам хоолойн инженер Наранбаатар овогтой Дармаадалай-г дээр дурдсан албан тушаалд 2023 оны 03 сарын 02-ны өдрөөс эхлэн томилох болохыг баталж байна. This letter is to confirm that Darmaadalai Naranbaatar, Piping Engineer, MCSPP appointed to the role identified above effective from 02 March 2023.</p> <p>Томилгогдон өмчитэн нь Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй тусламжийг үзүүлэн ажиллана. The dedicated first aider shall provide immediate assistance in the event of an emergency situation requiring first aid at the Wastewater Recycling Plant Project site.</p> <p>Наранбаатар овогтой Дармаадалай нь энэхүү ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтанд (Анхны тусламж үзүүлэгчийн сургалт) хамрагдаж амжилттай суралцсан болно. Darmaadalai Naranbaatar has successfully completed the required training (First Aider) to hold this role.</p> <p>Энэхүү томилгоог хүлээн зөвшөөрч ойлгосон гэдгээ нотолж дор гарын үсэг зурна уу. Please sign and date below to indicate your acceptance and understanding of this appointment.</p> <p>Томилгогдон/ Appointee: Н.Дармаадалай /Шугам хоолойн инженер/ Гарын үсэг / Signature: <i>N. Darmaadalai</i> Огноо / Date: 2023/03/02</p> <p>Баталсан / Approver: О.Батзориг /Төслийн менежер/ Гарын үсэг / Signature: <i>O. Batzorig</i> Огноо / Date: 2023/03/02</p> <p>1/1</p>

Б.Ням-Оргил  
/ХАБЭАХ ахлах  
ажилтан/



MCSproperty

Wastewater Recycling Plant Project

**ХАБЭАБО-НЫ АЛБАН ТУШААЛЫН ТОМИЛГОО**

LETTER OF APPOINTMENT TO HSE ROLE

АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ

УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ / М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХОК

FIRST AIDER – WASTEWATER RECYCLING PLANT PROJECT / MCS PROPERTY LLC

ХАБЭА харуусан ажилтан Батсуурь овогтой Ням-Оргил-г дээр дурдсан албан тушаалд 2023 оны 02 сарын 02-ны өдөрөөс ажил томилсон боловч баталж байна.  
This letter is to confirm that Nyam-Orgil Batsum, Health and Safety Officer, MCSPP appointed to the role identified above effective from 02 March 2023.

Томилгосон ажилтан нь Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн дэрүү тусламжийг үзүүлэн ажиллана.

The dedicated first aider shall provide immediate assistance in the event of an emergency situation requiring first aid at the Wastewater Recycling Plant Project site.

Батсуурь овогтой Ням-Оргил нь энэхүү ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад (Анхны тусламж үзүүлэгчийн сургалт) хамрагдаж амжилттай суралцсан болно.  
Nyam-Orgil Batsum has successfully completed the required training (First Aider) to hold this role.

Энэхүү томилгоог хүлээн зөвшөөрч ойлгосон гэдгээ нотолж доор гарын үсгээ зурна уу.  
Please sign and date below to indicate your acceptance and understanding of this appointment.

Томилгосон / Appointee: Б.Ням-Оргил /ХАБЭА харуусан ажилтан/

Гарын үсэг / Signature: *[Signature]* Огноо / Date: 2023/02/02

Баталсан / Approver: О.Батзориг /Төслийн менежер/

Гарын үсэг / Signature: *[Signature]* Огноо / Date: 2023/02/02

1/1

М.Хулан  
/Байгаль орчны  
ахлах ажилтан/



MCSproperty

Wastewater Recycling Plant Project

**ХАБЭАБО-НЫ АЛБАН ТУШААЛЫН ТОМИЛГОО**

LETTER OF APPOINTMENT TO HSE ROLE

АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ

УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ / М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХОК

FIRST AIDER – WASTEWATER RECYCLING PLANT PROJECT / MCS PROPERTY LLC

Байгаль орчны ажилтан Мөнхсэлэ овогтой Хулан-г дээр дурдсан албан тушаалд 2023 оны 03 сарын 02-ны өдөрөөс ажил томилсон боловч баталж байна.  
This letter is to confirm that Kulan Munkhsela, Environmental Officer, MCSPP appointed to the role identified above effective from 02 March 2023.

Томилгосон ажилтан нь Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талбайд анхны тусламж үзүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн дэрүү тусламжийг үзүүлэн ажиллана.

The dedicated first aider shall provide immediate assistance in the event of an emergency situation requiring first aid at the Wastewater Recycling Plant Project site.

Мөнхсэлэ овогтой Хулан нь энэхүү ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад (Анхны тусламж үзүүлэгчийн сургалт) хамрагдаж амжилттай суралцсан болно.  
Kulan Munkhsela has successfully completed the required training (First Aider) to hold this role.

Энэхүү томилгоог хүлээн зөвшөөрч ойлгосон гэдгээ нотолж доор гарын үсгээ зурна уу.  
Please sign and date below to indicate your acceptance and understanding of this appointment.

Томилгосон / Appointee: М.Хулан /Байгаль орчны ажилтан/

Гарын үсэг / Signature: *[Signature]* Огноо / Date: 2023/02/02

Баталсан / Approver: О.Батзориг /Төслийн менежер/

Гарын үсэг / Signature: *[Signature]* Огноо / Date: 2023/02/02

1/1




## 7.2 УДБҮ-ийн төслийн талбайн онцгой байдлын сургууллт

Төслийн гүйцэтгэгч нь төслийн “Онцгой байдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, захиалагчаар батлуулсан ба хуулийн шаардлагын дагуу төслийн талбайн онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангахтай холбоотой “Онцгой байдлын сургууллт”-ыг 2023 оны 8-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус онцгой байдлын сургууллтыг СХД-ийн онцгой байдлын хэлтэсээс УДБҮ-ийн төслийн талбайд зохион байгуулсан бөгөөд төслийн нийт 126 ажилтан хамрагдсан ба галын аюулгүй ажиллагааны танхимийн сургалтад нийт 11 ажилтан (галын харуул, анхны тусламж үзүүлэгч, ХАБЭА-н ажилтан) хамрагдсан байна.

Зураг 7-2: Онцгой байдлын сургууллт явагдаж буй байдал



Зураг 7-3: Галын аюулгүй байдлын танхимийн сургалт явагдаж буй байдал



## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УДБҮ-ийн төслийн талбайд хог хаягдлыг зохицуулахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх буй арга хэмжээ нь төслийн талбайд хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд ажилчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж хог хаягдлыг ангилан ялгах зан төлөвийг хэвшүүлэх явдал юм. Энэхүү ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгч нь дараах арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хог хаягдлыг ангилан хаях мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан олгож байгаа ба 2023 оны 10-р сарын 23-ны өдрийн байдлаар нийт 618 ажилтанд 112 удаагийн урьдчилсан зааварчилгааны сургалтыг зохион байгуулсан байна.
- Төслийн туслан гүйцэтгэгч нарын түр оффисыг нэг стандартын хог ангилан хаях зурагт хуудсаар хангаж, хогийн сав бүрийн харалдаа байршуулсан.
- Өглөөний ажил эхлэхийн өмнөх хурлаар дамжуулан нийт ажилтнуудад төслийн талбайд хог хаягдлыг зөв ангилан хаях талаар мэдээлэл хүргэж ажилладаг.



Төслийн талбайн түр оффист ахуйн хог хаягдлыг цаас, хуванцар, хаягдал зай хураагуур болон бусад гэсэн төрлүүдэд ангилан ялгаж байгаа бөгөөд ангилан ялгалтын талаарх мэдээллийг зурагт хуудас хэлбэр хогийн сав бүрийн харалдаа байршуулсан (Зураг 8-1). Мөн барилгын хог хаягдлыг төмрийн хаягдал, модны хаягдал, аюултай хаягдал болон бусад хаягдал гэсэн төрлүүдэд ангилан хаяж буй бөгөөд ангилан ялгасан бусад төрлийн хаягдлыг тухай бүрд нь устгалд оруулан ажиллаж байна. Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр болон дахивар хүлээн авах цэгүүдэд нийлүүлэн ажиллаж байна.

Зураг 8-1: Түр оффисын хүрээнд хог хаягдлыг ангилан хаях заавар



Төслийн гүйцэтгэгч нь тайлант хугацаанд хог хаягдлыг устгалд оруулахдаа дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага болох СХД-ийн татварын хэлтэс, СХД-ийн Засаг даргын дэргэдэх “Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хог хаягдал зөөж, устгах ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан.
- Ахуйн шингэн хаягдлыг бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий Ус Сувгийн Удирдах Газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тогтмол соруулсан.
- Барилга угсралтын үйл явцад ашиглах аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдал болон тос масло, химийн бодисын асгаралт зэргийг цэвэрлэхэд үүссэн хаягдлыг УДБҮ-ийн төслийн хүрээнд барилгын аюултай хаягдал гэж тооцдог бөгөөд төслийн талбайн аюултай хог хаягдал цуглуулах тустай цэгт түр хадгалж ажилласан. Төслийн талбайд цугларсан дээрх хаягдлыг аюултай хог хаягдал тээвэрлэх, устгалд оруулах тусгай зөвшөөрөл бүхий Элемент ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан.

Ажил үйлчилгээний гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 8-1: Хог хаягдлыг тээвэрлэх, устгалд оруулахтай холбоотой байгуулсан гэрээний мэдээлэл

№	Ажил үйлчилгээний мэдээлэл	Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж	Гэрээний хүчинтэй хугацаа
1	Ахуйн хатуу хог хаягдлыг тээвэрлэх	Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ” ОНӨААТҮГ	2023.01.01 – 2023.12.31
2	Барилгын хатуу хог хаягдлыг тээвэрлэх	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ” ОНӨААТҮГ	2023.01.01 – 2023.12.31

3	Барилга угсралтын ажилд ашигласан химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг тээвэрлэж, устгалд оруулах	Элемент ХХК	2022.12.31 – 2023.12.31
4	Бохир ус татан зайлуулах	Ус Сувгийн Удирдах Газар	2022.09.14 – Төсөл дуусах хүртэл

Хүснэгт 8-2: Дахин боловсруулсан болон устгалд оруулсан нийт хог хаягдлын хэмжээ, 2023 оны 10-р сарын 23-ны байдлаар

№	Хог хаягдлын төрөл	Хэмжээ (2023.01-2023.10)	Тайлбар
Дахивар хаягдал			
1	Төслийн талбайд хуримтлуулж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн хуванцар хаягдал	297.15 кг	Дахивар хаягдлыг төслийн талбайн ангилан ялгалтын хогийн цэгт цуглуулж, Эс И Эс Эл смарт солишн ХХК (РД:6990916)-д тогтмол нийлүүлж байна. Энэхүү компани нь “Аюулгүй хог хаягдал цуглуулах” болон “Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд гарган авах” үйл ажиллагааны чиглэл бүхий компани юм.
2	Төслийн талбайд хуримтлуулж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн төмөр хаягдал	393 кг	Дахивар хаягдлыг төслийн талбайн ангилан ялгалтын хогийн цэгт цуглуулж, Говь Ерлөг Хайрхан ХХК (РД:8333831)-д нийлүүлсэн. Энэхүү компани нь “Хоёрдогч түүхий эд боловсруулах” үйл ажиллагааны чиглэл бүхий компани юм.
Ахуйн шингэн хаягдал			
3	Шингэн хаягдал-ахуйн бохир ус	720 тн	Төслийн талбайн ахуйн бохир усыг 2022 оны 9-р сарын 14-ны өдөр “Ус сувгийн удирдах газар (УСУГ)”-тай байгуулсан аж ахуйн гэрээний дагуу төслийн талбайн бохир ус цуглуулах танкнаас соруулан УСУГ-ын тээврээр бохир ус нийлүүлэх цэг рүү тээвэрлүүлж байна.
Аюултай хаягдал			

4	Төслийн талбайд хуримтлагдсан барилгын материалын сав баглаа боодлын аюултай хаягдал	30 кг	Төслийн талбайд хуримтлагдсан барилгын материалын сав баглаа боодлын аюултай хаягдлыг хөрсөнд асгаралт үүсгэхгүй байхаар тустай хогийн цэгт цуглуулж байна. Аюултай хаягдлыг тээвэрлэх тодорхой хэмжээнд хүрсний дараа аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Элемент ХХК-д 2023 онд багтаан шилжүүлэн устгалд оруулахаар төлөвлөж байна.
5	Төслийн талбайд хуримтлагдсан хаягдал хуруу зай	1.5 кг	Хаягдал хуруу зай цуглуулах сав түр оффист байршуулан цуглуулж байгаа бөгөөд устгалд оруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөхөөр судалж байна. (Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой холбогдсон боловч хаягдал хуруу зайг цаашид цуглуулах боломжгүй болсон тухай мэдэгдсэн)
<b>Наран төвлөрсөн хогийн цэгт устгалд оруулсан дахин боловсруулах боломжгүй хаягдал</b>			
6	Ахуйн бусад хог хаягдал	12.2 тн	Төслийн талбайд үүссэн дахин боловсруулах боломжгүй бусад ангилалын хог хаягдлыг “Наран төвлөрсөн хогийн цэг”-т устгалд оруулсан.
7	Барилгын бусад хог хаягдал	37.96 тн	

### 8.1 Хатуу хог хаягдлын менежмент

УДБҮ-ийн төслийн талбайд хатуу хог хаягдлыг нийт 8 ангилалд ялган хаяж буй бөгөөд төслийн талбайд байрлах хог хаягдлын түр цэгт хадгалж, тогтмол давтамжтайгаар хог тээврийн зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлүүлж, устгалд оруулан ажиллаж байна. Гүйцэтгэгч нь гал тогооноос гарах хүнсний хаягдлыг ахуйн хог хаягдлын нэгдсэн цэгийн хүнсний хаягдал хэсэгт хогийн уутыг сайтар боож баглан хаяж байгаа ба ингэснээр амьтад цуглархаас сэргийлж байгаа юм.

Хүснэгт 8-3-т төслийн талбайн хог хаягдлын ангилан ялгалтын мэдээлэл, Зураг 8-2 – Зураг 8-4-т төслийн талбайн ахуйн болон барилгын хогийн цэгийн харагдах байдал болон байршлын мэдээллийг тус тус үзүүлэв.

Хүснэгт 8-3: УДБҮ-ийн төслийн талбайн хатуу хог хаягдлын ангилан ялгалт

№	Хог хаягдлын эх үүсвэр	Хог хаягдлын ангилан ялгалт	Хог хаягдал хадгалах байршил
1	Ахуйн хатуу хог хаягдал	Хуванцар, гялгар уут	Түр оффист ангилан ялгалтын хогийн саванд цугларсан дахин боловсруулах хаягдлыг төслийн талбайн баруун хойно байрлах ахуйн хаягдлын нэгдсэн цэгт түр хадгалдаг.
2		Шил, лааз	
3		Цаас	
4		Хүнсний хаягдал	

			төслийн талбайн баруун хойно байрлах ахуйн хаягдлын нэгдсэн цэгийн хүнсний хаягдал хэсэгт түр хадгалдаг.
5	Барилгын хаягдал	Төмөр	Төслийн талбайн зүүн талд байрлах барилгын хаягдлын нэгдсэн цэгийн ангилан ялгалтын хэсэгт түр хадгалдаг.
6		Мод	
7		Барилга угсралтын ажилд ашигласан химийн бодисын сав баглаа боодлын хаягдал	Төслийн талбайн зүүн талд байрлах барилгын хаягдлын нэгдсэн цэгийн аюултай хаягдлын хэсэгт түр хадгалдаг.
8	Ерөнхий	Бусад хаягдал	Дахин боловсруулах болон дахин ашиглах боломжгүй хаягдлыг бусад ангилалд хаяж байна. Ахуйн хог хаягдлаас гарах бусад хаягдлыг төслийн талбайн баруун хойно байрлах ахуйн хаягдлын нэгдсэн цэгийн бусад ангилан ялгалтын хэсэгт, барилгын хаягдлын бусад хаягдлыг төслийн талбайн зүүн талд байрлах барилгын хаягдлын нэгдсэн цэгийн бусад ангилан ялгалтын хэсэгт тус тус түр хадгалдаг.


Зураг 8-2: УДБҮ-ийн төслийн талбайн барилгын хог хаягдлын нэгдсэн цэгийн харагдах байдал (Зүүн талаас төмөр, модны хаягдал, бусад хаягдал, аюултай хаягдал)



Зураг 8-3: УДБҮ-ийн төслийн талбайн ахуйн хог хаягдлын нэгдсэн цэгийн харагдах байдал (Зүүн талаас шил/лааз, хуванцар/гялгар, цаас, бусад хаягдал)



Зураг 8-4: УДБҮ-ийн төслийн талбайн нэгдсэн хогийн цэгийн байршил



## 8.2 Шингэн хаягдлын менежмент

УДБҮ-ийн төслийн талбайн 2 байршилд тус бүр 20 тонн бүхий багтаамжтай ахуйн хаягдал ус цуглуулах танк байршуулсан ба хаягдал ус соруулах ажлыг УСУГ-тай хаягдал ус шавхан зайлуулах гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажиллаж байна.

УДБҮ-ийн төслийн нэг хоногт гаргах хаягдал усны хэмжээ нь 50 м<sup>3</sup>-ээс бага тул Усны тухай хуулийн 24.2-т заасны дагуу дараах дүгнэлт болон зөвшөөрлийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авч ажилласан. Үүнд:

- Туул голын сав газрын захиргаанаас хаягдал усны дүгнэлтийг 2023 оны 1-р сарын 31-ний өдөр
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг 2023 оны 2-р сарын 16-ны өдөр

тус тус авч, баримт бичгийн бүрдлийг хангасан.

Мөн гүйцэтгэгч нь Усны тухай хуулийн 25.1-д заасны дагуу 2022 онд ус бохирдуулсны төлбөр болох 80,560₮-ийг хаягдал усны дүгнэлтэд үндэслэн харьяалах Татварын хэлтэсийн дансанд 2023 оны 2-р сарын 14-ны өдөр тушаасан. 2023 оны ус бохирдуулсны төлбөрийг 2024 оны эхний улиралд багтаан харьяалах Татварын хэлтэсийн дансанд тушаахаар төлөвлөн ажиллаж байна.

УДБҮ-ийн төслийн талбайд бетон зуурмаг нийлүүлэх ажлыг туслан гүйцэтгэгч компани гүйцэтгэх бөгөөд төслийн талбайд бетон зуурмагийн машин угаасан хаягдал ус асгахыг хориглож ажилласан ба тайлант хугацаанд байгаль орчны зөрчил гараагүй байна.



2023 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд хог хаягдлын менежменттэй холбоотой доорх 17 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 8-4: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Ахуйн хатуу хог хаягдал (Дахин боловсруулах хаягдал)	Төслийн талбайн түр оффисоос гарч байгаа ахуйн хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба түр оффисын хүрээнд хаягдлыг бичгийн цаас, хуванцар, хаягдал хуруу зай, бусад гэсэн 4-н төрөлд ангилан хаях	УДБҮ-ийн төслийн талбай, түр оффис	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн түр оффисын хүрээнд цаас, хуванцар, хаягдал зай, бусад гэсэн 4-н төрлийн ангилан ялгалтын хогийн сав байрлуулан, дахивар хаягдлыг цуглуулж байна.	2022 онд хогийн савнуудыг байршуулсан тул 2023 онд нэмэлт зардал гараагүй.
2	Ахуйн хатуу хог хаягдал (Дахин боловсруулах боломжгүй хаягдал)	Төслийн талбайн түр оффисоос гарч байгаа дахин ашиглах болон дахин боловсруулах боломжгүй бусад хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар төвлөрсөн хогийн цэг рүү гээвэрлүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай, түр оффис	Тогтмол хэрэгжүүлж байна	Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй ажил үйлчилгээний гэрээ байгуулсан.	2,805,000
3	Ахуйн шингэн хаягдал	Төслийн талбайд 20 тн багтаамжтай бохир ус цуглуулах танкыг 2 байршилд байршуулж, бохир усыг хуримтлуулж байгаа ба тусгай зөвшөөрөл бүхий байгууллага болох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд нийт 720 тн бохир ус хуримтлуулж УСУГ-аар тогтмол соруулж ажилласан.	3,764,160 (72 удаагийн бохир соруулалт * 52,280₮)

		УСУГ-аар тогтмол давтамжтай соруулж ажиллах				
4		Төслийн талбайн бохир ус цуглуулах танкнаас хаягдал усны дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай, бохир ус цуглуулах танк	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн гүйцэтгэгч нь улиралд 1 удаа төслийн талбай дах бохир ус цуглуулах танкнаас бохир усны дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор MNS 6561:2015 <sup>6</sup> стандартын нийцлийг шинжлүүлж ажилласан. Шинжилгээний үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 9.5-р бүлгээс харна уу.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсан.
5		Хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт болон зөвшөөрөл авах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Туул голын сав газрын захиргаанаас хаягдал усны дүгнэлтийг 2023 оны 1-р сарын 31-ний өдөр</li> <li>• Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг 2023 оны 2-р сарын 16-ны өдөр тус тус авч, баримт бичгийн бүрдлийг хангасан.</li> </ul>	150,000 (Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж)
6		Ус бохирдуулсны төлбөр төлөх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Мөн гүйцэтгэгч нь Усны тухай хуулийн 25.1-д заасны дагуу 2022 онд ус бохирдуулсны төлбөр болох 80,560₮-ийг хаягдал усны дүгнэлтэд үндэслэн харьяалах Татварын хэлтэсийн дансанд 2023 оны 2-р сарын 14-ны өдөр тушаасан. 2023 оны ус бохирдуулсны төлбөрийг 2024 оны эхний улиралд багтаан харьяалах Татварын хэлтэсийн дансанд тушаахаар төлөвлөн ажиллаж байна.	80,560 (Хаягдал усны дүгнэлт дээр заасны дагуу)
7	Үйлдвэрийн буюу барилгын хаягдал	Төслийн талбайд нэгдсэн хогийн цэг байгуулсан тул хог хаягдлыг ангилан зөв	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд барилгын хог хаягдлыг 4 төрөлд ангилан ялгаж буй бөгөөд ангилан ялгалтын талаарх мэдээллийг төслийн урьдчилсан	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан болон талбайн менежер нь

<sup>6</sup> MNS 6561 : 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага

		хаях ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх			зааварчилгаа, өглөөний ажил эхлэхийн өмнөх хурал зэргээр дамжуулан нийт ажилтнуудад мэдээлэн ажиллаж байна.	тогтмол давтамжтай талбайн үзлэг хийх тул зардал гараагүй.
8		Барилгын хаягдлыг хог хаягдал зөөж, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан, устгалд оруулах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх “Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй ажил үйлчилгээний гэрээ байгуулсан.	Төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
9		Бетон зуурмаг нийлүүлэх туслан гүйцэтгэгч байгууллагад төслийн талбайд бетон зуурмагийн машин угаасан хаягдал ус болон бетон зуурмагийн хаягдал асгахыг хориглох ба гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь өдөр тутмын үзлэг, шалгалтаар тогтмол хяналт тавьж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ажил гүйцэтгэхээс өмнө туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын үе шатанд энэхүү шаардлагыг сайтар танилцуулсан ба ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж оруулсан. Ингэснээр, тайлант хугацаанд төслийн талбайд бетон зуурмагийн машин угаах үйлдэл гараагүй бөгөөд бетон зуурмагийн машин болон автопомп зэргээс зөвхөн хатуу бетоны үлдэгдэлийг хөрсөнд бохирдол үүсгэхгүйгээр хучлага дэвсэж, цэвэрлэсэн.	Мөн гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан нь тогтмол давтамжтай талбайн үзлэг хийж, хяналт тавьж ажилласан тул зардал гараагүй.
10		Барилгын хог хаягдлыг мод, төмөр, аюултай хаягдал, бусад гэсэн 4 төрөлд ангилан хаях ба дахин ашиглах.	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд барилгын хог хаягдлыг мод, төмөр, аюултай хаягдал, бусад гэсэн 4 төрөлд ангилан хаяж байгаа ба тайлант хугацаанд нийт 393 кг хаягдал төмрийг дахивар хүлээн авдаг цэгт хүлээлгэн өгсөн. Мөн өвлийн улирал эхэлж буйтай холбоотой төслийн талбайд цугларсан хаягдал модыг гүйцэтгэгчийн ажилтнуудад тарааж өгөх ажлыг эхлүүлээд байгаа ба эхний ажилтанд амжилттай хүлээлгэж өгсөн.	Дахивар хаягдлыг дахивар хүлээн авах цэгт шилжүүлэхдээ төслийн ачааны машиныг ашиглаж байгаа бөгөөд үүнтэй холбоотой зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд хамаарна.
11		Төслийн талбайд үүссэн будаг, цемент гэх мэт аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг төслийн талбайн аюултай	УДБҮ-ийн төслийн талбай, барилгын ажилд	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд аюултай хаягдлын цэгийг тустай байрлуулсан бөгөөд төслийн талбайд үүссэн будаг, цемент гэх мэт аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг	Элемент ХХК-д шилжүүлээгүй байгаа тул холбогдох зардал гараагүй байна.

		хог хаягдлын тустай цэгт хаях ба химийн бодисын хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлж устгалд оруулах	ашиглах химийн бодисын аюултай хог хаягдал		тухайн цэгт цуглуулж байна. Тайлант хугацаанд ойролцоогоор 30 кг аюултай хаягдал үүссэн бөгөөд тухайн хаягдлыг 2023 онд багтаан Элемент ХХК-д шилжүүлж, устгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
12	Ерөнхий арга хэмжээ	Талбайн өдөр бүрийн ажлын дараа талбай цэвэрлэх журам/зааврын хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Талбайн өдөр бүрийн ажлын дараа талбайг цэвэрлэж, эмх цэгцийг хангуулан ажиллаж байна.	-
13		Төслийн талбайд нийт ажилчдад зориулсан нийтийн ариун цэврийн байгууламжийг шийдэх ба бохирын гаргалгааг төслийн талбай дах бохир ус цуглуулах танктай холбох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламжийг бий болгож, бохир усыг бохир ус цуглуулах танканд цуглуулж байна.	Нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламж бий болгох зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
14		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд хог ангилан хаях тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1-р бүлгээс харна уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.
15		Төслийн талбайд хог хаягдал шатаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
16		Аливаа асгаралт үүссэн тохиолдолд захиалагч талд мэдэгдэх ба онц байдал үүссэн тохиолдолд ОБЕГ болон түргэн тусламж дуудах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ШТМ-ын бага хэмжээний асгаралтууд үүссэн бөгөөд тухай бүр туслан гүйцэтгэгч компанид зааварчилгаа өгч, нэн даруй хөрсийг цэвэрлүүлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан. Онц байдал үүссэн тохиолдолд үүсээгүй болно.	Талбайн үзлэг, шалгалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэдэг тул нэмэлт зардал гараагүй. Мөн үүссэн асгаралтыг цэвэрлэх үүрэг нь

						асгаралт үүсгэсэн талд хамаарах тул нэмэлт зардал гараагүй.
17		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад сургалтаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	УДБҮ-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэх ажилтан бүр ажиллаж эхлэхийн өмнө төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтад хамрагддаг. Энэхүү сургалтын агуулгад асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед авах арга хэмжээ болон асгаралт шингээгч иж бүрдлийг ашиглах заавар зэрэг тусгагдсан байдаг ба нийт ажилтнуудад мэдлэг олгон ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 4.1.1-р бүлгээс танилцана уу.	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулдаг тул зардал гараагүй.
					<b>Нийт</b>	<b>6,799,720</b>



## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

УДБҮ-ийн төслийн барилгажилтын үйл ажиллагааны үр дүнд агаарын чанар, дуу шуугиан, усны чанар болон хөрсөн бүрхэвч зэрэгт гарч болох өөрчлөлт мөн дээрх үзүүлэлтүүдийн чанар нь холбогдох стандартуудын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээтэй холбоотой доорх 5 бүлэг ажлыг 2023 онд төлөвлөж, хэрэгжилтийг хангуулж ажилласан.

*Хүснэгт 9-1: 2023 онд хэрэгжүүлсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задаргаа*

№	Орчны хяналт шинжилгээ	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	14,400,000	22,925,775
2	Дуу шуугианы хяналт шинжилгээ	-	-
3	Усны чанарын хяналт шинжилгээ	1,000,000	1,245,000
4	Хөрсний хяналт шинжилгээ	1,035,000	836,100
5	Бохир усны чанарын хяналт шинжилгээ	-	987,000
	<b>Нийт дүн</b>	<b>16,435,000</b>	<b>25,993,875</b>

## 9.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Эко трейд ХХК-ын гүйцэтгэсэн БОННУ-нд тусгаснаар агаарын чанарт нөлөөлөх үндсэн эх үүсвэр нь төслийн талбайд ашиглагдах машин, техникууд байх ба машин, техникуудийн хөдөлгөөнөөс тоосонцор (PM<sub>2.5</sub> болон PM<sub>10</sub>), хөдөлгүүрээс бохирдуулагч хийнүүд (SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>) агаар мандалд тархаж, агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй гэж тодорхойлсон. Тиймээс, эдгээрийн агаарын чанарт үзүүлэх нөлөө, цаашлаад агаарын чанарын холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд УДБҮ-ийн төслийн талбайд агаарын чанарын хэмжилтийн суурин төхөөрөмж байршуулж, өдөр тутамд тогтмол хяналт шинжилгээ хийн ажиллаж байна.

Хүснэгт 9-2: УДБҮ-ийн төслийн 2023 онд хэрэгжүүлэх агаарын чанарын хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Зарцуулагдсан төсөв, төг	Тайлбар
CO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , H <sub>2</sub> S, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> , Тоосонцор	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06'')	Өдөр бүр автомат төхөөрөмжөөр	1 байршилд	Тогтмол хэрэгжүүлж байна	20,525,775 (Автомат агаарын чанар хэмжигч төхөөрөмжийн үнэ)	Захиалагчийн шаардлагын дагуу төслийн гүйцэтгэгч нь агаарын чанарын автомат хэмжилтийн багажийг 2023 оны 5-р сарын 2-ны өдөр төслийн талбайд байршуулж, агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэж эхэлсэн ба тус багажийг суурилуулах хүртэл сард 1 удаа итгэмжлэгдсэн лабораториор хэмжилт хийлгүүлсэн.
CO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , H <sub>2</sub> S, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> , Тоосонцор	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06'')	1 сард 1 удаа; Шаардлагатай тохиолдолд нэмэлт давтамжаар хэмжилт хийх	1 байршилд	Бүрэн хэрэгжсэн	2,400,000 (3 удаагийн хэмжилт * 800,000₮)	Дээрх төхөөрөмжийг суурилуулах хүртэлх 2023 оны 1-р сараас 3-р сарын хооронд сард 1 удаа итгэмжлэгдсэн лабораторит хүсэлт гарган хэмжилтийг хийлгэсэн.
<b>Хэсгийн дүн</b>					<b>22,925,775</b>	

### 9.1.1. Итгэмжлэгдсэн лабораторийн агаарын чанарын хэмжилтийн үр дүн


УДБҮ-ийн төслийн талбайд агаарын чанарын автомат хэмжилтийн багажийг суурилуулах хүртэл сард 1 удаа итгэмжлэгдсэн лаборатори болох “Ногоон титэм ХХК”-аар агаарын чанарын хэмжилт хийлгэж хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан.

“Ногоон титэм ХХК”-ийн лабораторийн сорилтын тайланд тусгаснаар 2023 оны 1-р сарын шинжилгээний хариу Монгол улсын холбогдох стандартын зөвшөөрөгдөх түвшин давсан үзүүлэлт бүртгэгдээгүй буюу MNS 4585:2016 болон MNS 5885:2008 стандартуудын шаардлагад нийцэж байв. 2023 оны 2-р сард болон 3-р сард хийгдсэн агаарын чанарын шинжилгээний үр дүнгээс үзэхэд PM2.5 болон PM10 тоосонцрын хэмжээ стандартын зөвшөөрөгдөх түвшнээс давсан үзүүлэлттэй байгаа бол бусад бүх үзүүлэлт нь MNS 4585:2016 стандартуудын шаардлагад нийцэж байв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын орчны шинжилгээний хэлтсээс бэлтгэн гаргадаг “Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал”-ийн мэдээнээс үзэхэд Улаанбаатар хотын хүйтний улирал дах PM2.5 болон PM10 тоосонцрын хэмжээ стандартын зөвшөөрөгдөх түвшнээс их байдаг байна. Тус хэлтсээс нэгтгэн гаргасан 2018 оноос 2023 оны хоорондох хүйтний улирлын PM2.5 болон PM10 тоосонцрын сарын дундаж агууламжийн мэдээллийг Зураг 9-1 болон Зураг 9-2-оос харна уу.


УДБҮ-ийн төслийн талбайд 2023 оны 2-р сард болон 3-р сард хийгдсэн агаарын чанарын хэмжилтийн явцад тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөн, газар шорооны ажил зэрэг тоосжилт үүсгэж болзошгүй үйл ажиллагаа төслийн талбайд явагдаагүй. Иймд, дээр дурдсан саруудад хийсэн агаарын чанарын хэмжилтийн PM2.5 болон PM10 тоосонцрын үзүүлэлт нь MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх түвшнээс давсан нь Улаанбаатар хотын улирлын чанартай хүчин зүйлсээс шалтгаалсан байх боломжтой юм.

Зураг 9-1: Улаанбаатар хотын хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он<sup>7</sup>



<sup>7</sup> Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын орчны шинжилгээний хэлтсээс бэлтгэн гаргадаг “Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал /2023 оны 02 дугаар сар/” мэдээ

Зураг 9-2: Улаанбаатар хотын хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он<sup>8</sup>



Агаарын чанарын хяналт шинжилгээний үеийн баримтжуулсан мэдээллийг Зураг 9-3 - Зураг 9-5-аас, итгэмжлэгдсэн лабораторийн хэмжилтийн баталгаажуулсан тайланг *ХАВСРАЛТ 5. АГААРЫН ЧАНАРЫН ЛАБОРАТОРИЙН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН*-ээс дэлгэрэнгүй танилцана уу.

Хүснэгт 9-3: 2023.01 сараас 2023.03 сар хүртэл хийгдсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан

Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.01)	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.02)	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.03)	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	10.14 мкг/м <sup>3</sup>	5.31 мкг/м <sup>3</sup>	70.45 мкг/м <sup>3</sup>	200 мкг/м <sup>3</sup>
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	34.48 мкг/м <sup>3</sup>	116.98 мкг/м <sup>3</sup>	49.64 мкг/м <sup>3</sup>	450 мкг/м <sup>3</sup>
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	<1000 мкг/м <sup>3</sup>	<1000 мкг/м <sup>3</sup>	<1000 мкг/м <sup>3</sup>	60,000 мкг/м <sup>3</sup>
PM <sub>2.5</sub> тоосонцор	41.57 мкг/м <sup>3</sup>	83.84 мкг/м <sup>3</sup>	66.47 мкг/м <sup>3</sup>	50 мкг/м <sup>3</sup>
PM <sub>10</sub> тоосонцор	68.82 мкг/м <sup>3</sup>	234.14 мкг/м <sup>3</sup>	112.16 мкг/м <sup>3</sup>	100 мкг/м <sup>3</sup>
Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.01)	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.02)	Сорилтын дүн, хэмжих нэгж (2023.03)	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
Хүхэрт устөрөгч H <sub>2</sub> S	0.00 мкг/м <sup>3</sup>	0.00 мкг/м <sup>3</sup>	0.00 мкг/м <sup>3</sup>	10 мкг/м <sup>3</sup>

<sup>8</sup> Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын орчны шинжилгээний хэлтэсээс бэлтгэн гаргадаг “Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал /2023 оны 02 дугаар сар/” мэдээ

Зураг 9-3: Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал, 2023.01.23



\*  $H_2S$ -ийн хэмжилт



\*  $PM_{10}$ ,  $PM_{2.5}$ ,  $NO_2$ ,  $SO_2$ ,  $CO$ -ийн хэмжилт

Зураг 9-4: Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал, 2023.02.27



\*  $H_2S$ -ийн хэмжилт



\*  $PM_{10}$ ,  $PM_{2.5}$ ,  $NO_2$ ,  $SO_2$ ,  $CO$ -ийн хэмжилт

Зураг 9-5: Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал, 2023.03.29



\*  $H_2S$ -ийн хэмжилт



\*  $PM_{10}$ ,  $PM_{2.5}$ ,  $NO_2$ ,  $SO_2$ ,  $CO$ -ийн хэмжилт

#### 9.1.2. Агаарын чанар хэмжигч суурин автомат багажийн мэдээлэл

УДБҮ-ийн төслийн талбайд агаарын чанар хэмжигч суурин автомат багаж (AQM-09) 2023 оны 5-р сарын 2-ны өдөр төслийн талбайд байршсан бөгөөд өдөр бүр тус багажаар агаарын чанарын хэмжилтийг дараах үзүүлэлтүүдийн хүрээнд хэмжиж байна. Үүнд:

- Бохирдуулагч хий: Азотын давхар исэл ( $NO_2$ ), Хүхэрлэг хий ( $SO_2$ ), Нүүрстөрөгчийн дутуу исэл ( $CO$ ), Хүхэрт устөрөгч ( $H_2S$ )
- Тоосонцор:  $PM_{2.5}$  тоосонцор,  $PM_{10}$  тоосонцор




Зураг 9-6: Агаарын чанар хэмжигч багажийн харагдах байдал болон багажийн хэмжилт тохируулгын гэрчилгээ



Henan Oceanus Import&Export Co., Ltd.																					
Calibration Certification																					
Product	Metro Air Quality Monitoring Station	Model	AQ04-09																		
Quantity	1PC	Cal-date	March 24th, 2023																		
Product no.	OC02024219039																				
Appearance	☑Clean ☑No corrosion ☑No damage																				
Gas type	CO: ppm, SO <sub>2</sub> : ppb, NO <sub>2</sub> : ppb, H <sub>2</sub> S: ppm, PM <sub>2.5</sub> : ug/m <sup>3</sup> , pm <sub>10</sub> : ug/m <sup>3</sup> , TSP: ug/m <sup>3</sup> , Temperature/Humidity: °C/50%RH																				
Accuracy	±3%±3																				
Resolution	0.1ppm±1ppb±0.1ug/m <sup>3</sup>																				
Response time	≤5S																				
Survey range	NO: 0~2000ppb, NO <sub>2</sub> : 0~2000ppb, NO <sub>2</sub> : 0~2000ppb, CO: 0~200ppm, H <sub>2</sub> S: 0~100ppm, pm <sub>2.5</sub> : 0~1000ug/m <sup>3</sup> , pm <sub>10</sub> : 0~1000ug/m <sup>3</sup> , TSP: 0~1000ug/m <sup>3</sup> , Temperature: -30~50°C, Humidity: 0%~100%RH																				
Signal output mode	4G LTE																				
Power supply voltage	AC 220V/50Hz																				
Power dissipation	≤30W																				
Working temperature and humidity range	-30°C~50°C / 10%RH~95%RH																				
Testing condition	Temperature: 30°C, Humidity: 65%RH																				
Calibration gas	NO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, H <sub>2</sub> S																				
Cal gas test	<table border="0"> <tr> <td>1. NO: Call gas concentration: 1000ppb</td> <td>Inspect concentration: 1000ppb</td> </tr> <tr> <td>2. NO<sub>2</sub>: Call gas concentration: 2100ppb</td> <td>Inspect concentration: 1187ppb</td> </tr> <tr> <td>3. SO<sub>2</sub>: Call gas concentration: 1800ppb</td> <td>Inspect concentration: 1578ppb</td> </tr> <tr> <td>4. CO: Call gas concentration: 100ppm</td> <td>Inspect concentration: 99.7ppm</td> </tr> <tr> <td>5. H<sub>2</sub>S: Call gas concentration: 55.8ppm</td> <td>Inspect concentration: 55.7ppm</td> </tr> <tr> <td>6. PM<sub>2.5</sub>: Measured value: 53ug/m<sup>3</sup></td> <td>PM<sub>10</sub>: Measured value: 62ug/m<sup>3</sup></td> </tr> <tr> <td>7. TSP: Measured Value: 70ug/m<sup>3</sup></td> <td></td> </tr> <tr> <td>8. Noise: Measured Value: 31.4dB</td> <td>Humidity: Measured Value: 50%RH</td> </tr> <tr> <td>9. Temperature: Measured Value: 27.4°C</td> <td></td> </tr> </table>			1. NO: Call gas concentration: 1000ppb	Inspect concentration: 1000ppb	2. NO <sub>2</sub> : Call gas concentration: 2100ppb	Inspect concentration: 1187ppb	3. SO <sub>2</sub> : Call gas concentration: 1800ppb	Inspect concentration: 1578ppb	4. CO: Call gas concentration: 100ppm	Inspect concentration: 99.7ppm	5. H <sub>2</sub> S: Call gas concentration: 55.8ppm	Inspect concentration: 55.7ppm	6. PM <sub>2.5</sub> : Measured value: 53ug/m <sup>3</sup>	PM <sub>10</sub> : Measured value: 62ug/m <sup>3</sup>	7. TSP: Measured Value: 70ug/m <sup>3</sup>		8. Noise: Measured Value: 31.4dB	Humidity: Measured Value: 50%RH	9. Temperature: Measured Value: 27.4°C	
1. NO: Call gas concentration: 1000ppb	Inspect concentration: 1000ppb																				
2. NO <sub>2</sub> : Call gas concentration: 2100ppb	Inspect concentration: 1187ppb																				
3. SO <sub>2</sub> : Call gas concentration: 1800ppb	Inspect concentration: 1578ppb																				
4. CO: Call gas concentration: 100ppm	Inspect concentration: 99.7ppm																				
5. H <sub>2</sub> S: Call gas concentration: 55.8ppm	Inspect concentration: 55.7ppm																				
6. PM <sub>2.5</sub> : Measured value: 53ug/m <sup>3</sup>	PM <sub>10</sub> : Measured value: 62ug/m <sup>3</sup>																				
7. TSP: Measured Value: 70ug/m <sup>3</sup>																					
8. Noise: Measured Value: 31.4dB	Humidity: Measured Value: 50%RH																				
9. Temperature: Measured Value: 27.4°C																					
Test result	Qualified																				
Remark																					
Check:	Li Xiang	Approval:	Wang Jinyang																		
Company: Henan Oceanus Import & Export Co., Ltd.																					
Date: March 24 <sup>th</sup> , 2023																					
2023-10-03 09:00:08																					

Зураг 9-7: Агаарын чанар хэмжигч багажийн онлайн системийн харагдах байдал

WRP						UpdateTime : 2023-10-03 09:00:08
PM2.5	PM10	TSP	HUM	TEMPER	NO2	
22 ug/m <sup>3</sup>	35 ug/m <sup>3</sup>	50 ug/m <sup>3</sup>	72 %RH	2.4 °C	40.9 ug/m <sup>3</sup>	
SO2	CO	AIRPPE	noise	H2S		
3 ug/m <sup>3</sup>	0 mg/m <sup>3</sup>	8.79 hPa	48.5 dB	0.097 ppm		



### 9.1.3. Агаарын чанар хэмжигч суурин автомат багажийн агаарын чанарын хэмжилтийн үр дүн

УДБҮ-ийн төслийн талбайд суурин багаж ашиглан агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэхэд агаарын чанарын хэмжилтийн үр дүн нь бүх үзүүлэлтийн хувьд MNS 4585:2016 стандартын нийцлийг хангаж байна.

2023 оны 9-р сарын 6-ны өдөр PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн нь дээрх стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг давсан боловч энэ нь төслийн үйл ажиллагааны нөлөөллөөс хамааралгүй бөгөөд тухайн өдөр нь хүчтэй салхитай, шороон шуургатай өдөр байсан тул цаг агаарын хүчин зүйлс нөлөөлсөн болно. Тус цаг агаарын нөхцөл байдлын баримтжуулсан мэдээллийг Хүснэгт 9-4-оос харна уу.



**Шороон шуурга:** 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 12:33 цаг дах цаг агаарын байдал




**Салхины хурд:** 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 12:03 – 12:04 цагийн байдлаар


УДБҮ-ийн төслийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнг доорх зургуудад үзүүлэлт тус бүрээр харуулав.

УДБҮ-ийн төслийн дах агаарын чанар хэмжигч төхөөрөмжид бүртгэгдсэн мэдээллээр хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )-н үзүүлэлт нь 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн их хэмжээгээр нэмэгдсэн байгаа хэдий ч MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх түвшинг даваагүй байна.


Зураг 9-8: УДБҮ-ийн төслийн талбайн хүхэрлэг хийн хэмжилтийн үзүүлэлт




Зураг 9-9: УДБҮ-ийн төслийн талбайн азотын давхар исэлийн хэмжилтийн үзүүлэлт




Зураг 9-10: УДБҮ-ийн төслийн талбайн нүүрстөрөгчийн дутуу исэлийн хэмжилтийн үзүүлэлт




Зураг 9-11: УДБҮ-ийн төслийн талбайн хүхэрлэг хийн хэмжилтийн үзүүлэлт



Зураг 9-12: УДБУ-ийн төслийн талбайн PM2.5 тоосонцрын хэмжилтийн үзүүлэлт



Зураг 9-13: УДБУ-ийн төслийн талбайн PM10 тоосонцрын хэмжилтийн үзүүлэлт





## 9.2 Дуу шуугианы хяналт шинжилгээ


Эко трейд ХХК-ны хийсэн судалгаагаар орчны дуу шуугианы бохирдлын хэмжээ 72-75 дБ буюу MNS 4585:2016 стандартаас 12-15 дБ-ээр болон Дэлхийн Банкны үйлдвэржсэн районд тавигддаг стандартаас их байсан нь төсөл хэрэгжих талбай дуу шуугианы бохирдолд өртсөн байгааг илтгэнэ. МУ-ын дуу шуугианы бохирдлын өдрийн хугацааны зөвшөөрөгдөх хэмжээ 60 дБ (MNS 4585:2016) байдаг бол Дэлхийн Банкны стандартаар 70 дБ, дуу чимээтэй газар ажиллаж байгаа хүнд хүрэх долгионы хэмжээ 85 дБ байна. Иймд, УДБҮ-ийн төслийн талбайн дуу шуугианы түвшин нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор дуу шуугианы хяналт шинжилгээтэй холбоотой доорх хүснэгтэд дурдсан ажлуудыг 2023 онд хэрэгжүүлж ажиллаж байна.

Хүснэгт 9-5: УДБҮ-ийн төслийн 2023 онд хэрэгжүүлэх дуу шуугианы хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Зарцуулагдсан төсөв, төг	Тайлбар
Дуу шуугиан	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06'')	Өдөр бүр автомат төхөөрөмжөөр	1 байршилд	Тогтмол хэрэгжүүлж байна	Агаарын чанарын хяналт шинжилгээний зардалд тусгагдсан.	Захиалагчийн шаардлагын дагуу төслийн гүйцэтгэгч нь агаарын чанарын автомат хэмжилтийн багажийг 2023 оны 5-р сарын 2-ны өдөр төслийн талбайд байршуулж, дуу чимээний хэмжилтийг гүйцэтгэж эхэлсэн.
Дуу шуугиан	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06''), төслийн талбайн бэлтгэл ажлын ойр орчимд 1 цэг буюу нийт хамгийн багадаа 2 цэгт)	Төсөл хэрэгжих хугацаанд тогтмол	Тогтмол, өдөрт 2 удаа (Шаардлагатай тохиолдолд давтамжийг нэмэх)	Тогтмол хэрэгжүүлж байна	Гүйцэтгэгчийн зөөврийн дуу хэмжигч төхөөрөмжөөр хэмжих тул зардал гарахгүй.	УДБҮ-ийн төслийн талбайн гадна орчинд үндсэн барилга байгууламжийн барилгын ажлын ойр хэмжилтийг хийж гүйцэтгэдэг.
Хэсгийн дүн					-	



Зураг 9-15: УДБҮ-ийн төслийн талбайн дуу чимээний хэмжилтийн үр дүн



### 9.3 Усны чанарын хяналт шинжилгээ

УДБҮ-ийн төслийн газрын доорх усны түвшин гадаргатай ойр тул аливаа их хэмжээний бохирдуулагч бодисын алдрал, ялангуяа шингэн төлөвт байгаа шатах тослох материал хөрсийг бохирдуулснаар газрын доорх ус бохирдох үндэс болох ба их хэмжээний бороо орсон тохиолдолд бохирдох эрсдэлийн эрчим нэмэгдэнэ. Тиймээс, төслийн үйл ажиллагаанаас усны чанарт үзүүлэх нөлөө, мөн усны чанар нь холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд УДБҮ-ийн төслийн талбайн дараах байршлуудад мэргэжлийн байгууллагаар усны хяналт шинжилгээг тогтмол хийлгэхээр төлөвлөсөн билээ. Иймд, усны чанарын хяналт шинжилгээ дараах байршлуудад хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- УДБҮ-ийн төслийн барилгын ажлын нийт хугацаанд ахуйн зориулалтаар (төслийн ажилчдын нийтийн ариун цэврийн өрөөний усны хэрэгцээг хангах) болон цаашдын барилга угсралтын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор 2022 онд нэг гүний худаг гаргасан. 2023 онд төслийн талбайд гаргасан гүний худгийг ашиглаж эхэлснээс хойш

улирал тутамд итгэмжлэгдсэн лабораториор усны чанарт хяналт шинжилгээ хийлгүүлж ажилласан.

- Эко трейд ХХК-ын гүйцэтгэсэн БОННУ-нд тусгаснаар ХУДБ төслийн талбайн ойр орчимд хийгдсэн худгийн усны дээжид хүнд металлын агууламж зөвшөөрөгдөх түвшнээс их үзүүлэлттэй (2.1.4 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан) гарсан тул УДБҮ-ийн төслийн талбайд ажиллах нийт ажилчдын ундны усыг зөөврийн ундны усаар хангадаг бөгөөд 10 тн багтаамж бүхий ундны усны нөөцийн сав байршуулсан. Иймд, ундны усны чанарын хяналт шинжилгээг төслийн талбайд байршуулсан ундны усны нөөцийн сав дах уснаас дээж авч, улиралд 1 удаа шинжлүүлдэг ба MNS 0900:2018<sup>9</sup> стандартын нийцлийг шинжлүүлж ажилласан.
- УДБҮ-ийн төслийн барилгын суурийн хөрсний ус шавхах үйл ажиллагааны явцад сард 1 удаа шавхаж буй хөрсний уснаас дээж авч, MNS 4943:2015<sup>10</sup> стандартын нийцлийг шинжлүүлж ажилласан.

ХУДБ төслийн БОННУ-нд тусгасан гадаргын усны хяналт шинжилгээ хийх байршил нь УДБҮ-ийн төслийн байршлаас голын урсгалын дээд хэсэгт байршсан тул УДБҮ-ийн төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох боломжгүй юм. Иймд, захиалагч талтай зөвлөцөсний дагуу гадаргын усны чанарын хяналт шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэхгүй байх шийдвэр гарсан. УДБҮ-ийн төслийн үйл ажиллагаанаас гадаргын усны чанарт шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой эх үүсвэр нь УДБҮ-ийн төслийн барилгын сууриас шавхаж буй хөрсний ус тул тус хөрсний уснаас сард 1 удаа дээж авч, MNS 4943:2015 стандартын нийцлийг шинжлүүлж ажиллаж байна.

Мөн төслийн талбайд гаргасан гүний худгаас хагас жилд 1 удаа газрын доорх усны түвшний хэмжилт хийх бөгөөд энэхүү хэмжилтийг Solinst's Levelogger 5 загварын багажаар гүйцэтгэж байгаа ба тайлант хугацаанд 2 удаагийн хэмжилт хийгдсэн. Хэмжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 9-6-т, хэмжилт хийж байх үеийн баримтжуулсан зурган мэдээллийг Зураг 9-16-д тус тус харуулав.

Хүснэгт 9-6: Газрын доорх усны түвшингийн өөрчлөлт

	Хэмжилтийн үр дүн (2023.04.25)	Хэмжилтийн үр дүн (2023.08.10)	Төлөв байдлын тойм (Эх сурвалт: БОННУ)
Газрын доорх усны түвшин	(- 5.40 м)	(- 7.94 м)	БОННУ-ний тайланд тусгаснаар газрын доорх усны түвшин нь газрын гадаргаас ойролцоогоор 1.5 м - 5.5 м доош байх бөгөөд улирлын нөлөөллөөр хэлбэлздэг.

<sup>9</sup> MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

<sup>10</sup> MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага



2023 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд хэрэгжүүлсэн усны чанарын хяналт шинжилгээг Хүснэгт 9-7-аас дэлгэрэнгүй танилцана уу.

Усны чанарын хэмжилтийн үр дүнгийн тайланг дараах хавсралтуудаас дэлгэрэнгүй танилцана уу. Үүнд:

- ХАВСРАЛТ 6. ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЧАНАРЫН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН (УДБҮ-ИЙН ТӨСЛИЙН ТАЛБАЙ ДАХ ГҮНИЙ ХУДГИЙН ДЭЭЖ)
- ХАВСРАЛТ 7. УНДНЫ УСНЫ ЧАНАРЫН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН (УДБҮ-ИЙН ТӨСЛИЙН УНДНЫ УСНЫ ТАНКНААС АВСАН ДЭЭЖ)
- ХАВСРАЛТ 8. ШАВХАЖ БУЙ ХӨРСНИЙ УСНЫ ЧАНАРЫН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮН (УДБҮ-ИЙН ТӨСЛИЙН БАРИЛГЫН СУУРИАС ШАВХАЖ БУЙ ХӨРСНИЙ УСНЫ ДЭЭЖ)

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Зарцуулагдсан төсөв, төг	Тайлбар
Газрын доорх усны чанар (Хими, хүнд металл, бактери)	Төслийн талбайд шинээр гаргасан гүний худаг	Улиралд 1 удаа	1 байршилд нийт 5 удаа	Тогтмол хэрэгжүүлж байна	325,000 (5 удаагийн шинжилгээ * 65,000₮)	УДБҮ-ийн төслийн гүний худгаас тайлант хугацаанд нийт 5 удаагийн дээж авч, MNS 0900:2018 стандартын нийцлийг шинжлүүлсэн.
Гадаргын усны чанар (Хими, хүнд металл, бактери)	Туул гол Нисэх орчимд (SW-4) 106° 45' 5.5" 47° 52' 32.8"	Хагас жилд 1 удаа	1 байршилд нийт 2 удаа	Усны чанарын хяналт шинжилгээнээс хассан.	-	ХУДБ төслийн БОННУ-нд тусгасан гадаргын усны хяналт шинжилгээ хийх байршил нь УДБҮ-ийн төслийн байршлаас голын урсгалын дээд хэсэгт байршсан тул УДБҮ-ийн төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох боломжгүй юм. Иймд, захиалагч талтай зөвлөлцөсний дагуу гадаргын усны чанарын хяналт шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэхгүй байх шийдвэр гарсан.
Ундны усны чанар (Хими, хүнд металл, бактери)	Ундны усны нөөцийн сав	Улиралд 1 удаа	1 байршилд нийт 5 удаа	Тогтмол хэрэгжүүлж байна	325,000 (5 удаагийн шинжилгээ * 65,000₮)	УДБҮ-ийн төслийн ундны усны нөөцийн савнаас тайлант хугацаанд нийт 5 удаагийн дээж авч, MNS 0900:2018 стандартын нийцлийг шинжлүүлсэн.
Шавхаж буй хөрсний усны чанар (Хими, бактери)	Барилгын сууриас шавхаж буй хөрсний усны гаргалгаа	Сард 1 удаа	Хөрсний ус шавхах үйл ажиллагаа эхэлснээс дуусах хүртэл	Тогтмол хэрэгжүүлж байна	595,000 (7 удаагийн шинжилгээ * 85,000₮)	УДБҮ-ийн төслийн насос станц №1 байгууламжийн барилгын суурийн хөрсний ус шавхаж буй гаргалгаанаас хөрсний усны дээж авч, сард 1 удаа MNS 4943:2015



			сар бүр буюу 1 байршилд нийт 7 удаа			стандартын нийцлийг шинжлүүлсэн. Тайлант хугацаанд нийт 7 удаагийн дээжид шинжилгээ хийсэн.
7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаарыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хойгийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

### НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадаагүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувиар алданги тооцно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан дүүргийн "Тохийлт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНБААТҮГ" төлөөлж:

Албан тушаал: Хуулийн зөвлөх  
Нэр: Ж. Амарсанаа  
Гарын үсэг /...../

Аж ахуй нэгж, байгууллагын төлөөлж:  
Албан тушаал: Төрийн захирал  
Нэр: Д. Батзориг  
Гарын үсэг /...../  
Утас: 81025275  
Хаяг:



Дугаар 855/20

Улаанбаатар хот

### ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

#### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж өчих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

#### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 10/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

#### 2.2 Энэхүү гэрээг

**НЭГ ТАЛААС:** Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /давшид татварын байцаагч гэх/, Сонгинохайрхан Дүүргийн Засаг даргын даргадэх "Тохижилт Цэвэрлэгч Үйлчилгээ" ОНБААТҮГ /давшид тээвэрлэгч гэх/

**НӨГӨӨ** *М.С.Х. Мунуш* **ТАЛААС:** иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага /доогуур зурал/ *Баруун үйлдвэр* үйл ажиллагааны чиглэлтэй /давшид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

#### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2023 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 12-р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

#### ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЗРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд завсан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийж эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч байгууллагатай тооцоо нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурааж тээвэрлэгч байгууллагын ажилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дарва сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

#### ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЗРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцоо нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог, тээвэрлэлтийн зардал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлэгчтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тээвэрлэлтийн баримтаар нотлогдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.



5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхмэлзэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэст өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

### ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818; дугаарын тусанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушвасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцвасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх, Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

### ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /Иргэйн/ үйлчилгээний хураамжийг Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн.....төгрөг/, /улиралд.....төгрөг/, /хонд.....төгрөг/, /ажилгаар..... /төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкнд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

### НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛЭГХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргвэныг харилцан тохиролцоо бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувиар алданги тооцно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан дүүргийн "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ" төлөөлөгч:  
Албан тушаал: Хуулийн зөвлөх  
Нэр: Ж. Амарсанаа  
Гарын үсэг /...../

Аж ахуй нэгж, байгууллагыг дэлгэвч:  
Албан тушаал: .....  
Нэр: .....  
Гарын үсэг /...../

Утас: 88025029  
Хаяг:

## **ХАВСРАЛТ 13. ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ БОЛОН ЗӨВШӨӨРӨЛ**



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГАА

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингунжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,  
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714  
E-mail: TuulRBA@gmail.com

2023.01.31 № 04/71  
танай 2023.01.25-ны № 36 -т

“М-СИ-ЭС ПРОПЕРТИ” ХХК-ИЙН  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР О.БАТЗОРИГ  
ТАНАА

Монгол Улсын Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаартай албан бичгийн дагуу танай компанийн “Ус дахин боловсруулах үйлдвэр”-ийн 2022 оны хаягдал усны дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хаягдал усны дүгнэлтээр тавигдсан шаардлагыг хангаж ажиллана уу.

Хувийг, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт... хуудастай, .... хувь.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  Д.НЯМДОРЖ





ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
"М-СИ-ЭС ПРОПЕРТИ" ХХК-ИЙН УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2023 оны 01 дүгээр  
сарын 31

Дугаар ХУД 23/16

Улаанбаатар хот  
Утас:70003714, 70003716

**1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг:**

- "М-Си-Эс проперти" ХХК-ийн төслийн менежер О.Батзориг, Утас 7070-0065, Улсын бүртгэлийн дугаар 9011012015, Регистрийн дугаар 5040159.

**2. Төслийн нэр, байршил:**

- "М-Си-Эс проперти" ХХК-ийн Ус дахин боловсруулах үйлдвэр нь Сонгинохайрхан дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг.

**3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**

- Түр барилга байгууламжаас гарах шингэн хаягдлыг 20 м<sup>3</sup> багтаамжтай доторлогоотой цооногт хуримтлуулж, Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээг "Ус сувгийн удирдах газар"-тай 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан.

**4. Цэвэрлэгээний арга, түвшин:**

- Байхгүй.

**5. Хаягдал усны хэмжээ:**

- 2022 оны хаягдал усны нийт хэмжээ: 2'014.0 м<sup>3</sup> /2022 оны төслийн талбайн ажлын тайлан/.

**6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**

- Бохирдуулах бодисын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Барилга хот байгуулалтын Сайдын 2019 оны А-816/218 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай" жишиг хэмжээгээр тооцов. Бохирдуулах бодисын төрөл, Органик бодис /Химийн хэрэгцээт хүчилтөрөгч/, Бохирдуулах бодисын жишиг хэмжээ: 0.8 кг/м<sup>3</sup>.

**7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:**

Унд, ахуйн хаягдал усны хэрэглээ: 231 хүн x 80 л/хүн x 109 хон = 2'014.0 м<sup>3</sup>

Хаягдал усны хэмжээ (м <sup>3</sup> )	Жишиг хэмжээ (кг/м <sup>3</sup> )	Бохирдуулах бодис (кг)	Ус бохирдуулсны төлбөр (төг/кг)	Нийт төлбөр, төг
2'014.0	0.8	1'611.2	50.0	80'560

- Ус бохирдуулсны төлбөрт ногдуулсан 80'560 /Наян мянга таван зуун жаран/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.10, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

**8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж:**

- Хаягдал усны бохирдуулах бодисын агууламж нь "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаас давсан тохиолдолд Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны эх үүсвэрийг тоолууржуулах;



- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны эх үүсвэрийг тоолууржуулах;

**9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:**

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаас хаягдал ус хаях зөвшөөрөл авах;

- Хаягдал усны дүгнэлтийг жил бүрийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, улирлын сүүлийн сарын 15-ны дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүнгүүд, хаягдал усны төлбөр төлсөн баримтыг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

ХЯНАСАН:

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ  
АЛБАНЫ ДАРГА



П.ЭНХБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ  
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



Э.МЯГМАРСҮРЭН



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Барилга, хог байгуулалтын сайдын  
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
А/719/189 дүгээр тушаалын хавсралт



## ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 23/06

.....**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**..... -ын гаргасан  
/ Дүгнэлт гаргасан байгууллага /  
20.~~23~~ны ~~01~~дугаар сарын ~~31~~ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах~~23/16~~... тоот  
дүгнэлтийг үндэслэн .....**Улаанбаатар**..... аймаг/нийслэл .....**Сонгинохайрхан**  
сум/дүүргийн~~20~~ дугаар хорооны нутаг дэвсгэрт..... байршилтай  
/ хаяг /  
.....**Ус дахин боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын төсөл**  
/ үйл ажиллагааны чиглэл /  
чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа .....**“М-Си-Эс.Проперти” ХХК**.... -д  
/ хүн, хуулийн этгээдийн нэр /  
.....**Улаанбаатар**..... аймаг/нийслэл, .....**Сонгинохайрхан** сум/дүүргийн  
.....**Төвлөрсөн бохир усны шугамын коллектор**т байршилтай хаягдал  
ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны  
шугамд жилд .....**2014.0**..... мян.м<sup>3</sup> хаягдал усыг “Хүрээлэн байгаа  
орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”,  
“Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд  
нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар  
тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг  
/ аль нь болохыг доогуур нь зурах /  
нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон  
дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.  
Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны  
шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

.....**СХД-ЗДТГ-ын дарга**.....**Д.ТӨМӨРБААТАР**..... /  
/ Зөвшөөрөл олгосон байгууллага / ..... / Гарын үсэг / ..... / Гарын үсгийн тайлал /  
Тамга

20 ~~23~~ны ~~01~~ сарын ~~16~~ны өдөр



СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Огноо	Гарын үсэг / тамга

**ХАВСРАЛТ 14. БАРИЛГЫН СУУРИЙН УС ШАВХАН ЗАЙЛУУЛАХТАЙ  
ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГҮҮД**





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

Чингунжавын гудамж, 2 дугаар хороо,  
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050  
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,  
Цахим шуудан: office@water.gov.mn,  
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.02.03 № 01/133  
танай 2023.01.26-ны № 35 -Т

“М СИ ЭС ПРОПЕРТИ” ХХК-Д

Танай байгууллагын 2023 оны 35 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд, Усны тухай хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжих “Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх” төслийн барилга угсралтын суурийн ухлагын ажлыг гүйцэтгэх үед хөрсний ус шавхан зайлуулахад шүүрлээр гарах усны дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Туул голын сав газрын захиргаанд.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  ЯБОЛДБААТАР



## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 02 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар- 09

Улаанбаатар  
хот

**1. Аж ахуйн нээж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

"М Си Эс Проперти" ХХК, Төслийн менежер О.Батзориг, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг-8, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 16 давхар. ИМЭЙЛ: admin@mcsr.mn. Утас: 7070-0065, ФАКС: 11321656. Улсын бүртгэлийн дугаар: 9011012015, регистрийн дугаар: 5040159.

**2. Төслийн нэр, байршил:**

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт Төв цэвэрлэх байгууламжийн баруун талд байрлана. Туул голын сав газарт хамаарагдана.

**3. Төсөл хэрэгжүүлэгч:**

"М Си Эс Проперти" ХХК;

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X,Y/**

Эдэлбэр газар: 619179.0 м<sup>2</sup> . Талбайн хэмжээ: 12000.0 м<sup>2</sup>

№	Солбилцол		Тал урт(м)
	X	Y	
1	630955.451	5306963.559	1-2=255.76
2	630994.190	5306710.749	2-3=230.19
3	630766.655	5306875.883	3-4=181.14
4	630745.600	5306855.791	4-5=81.58
5	630736.117	5306936.814	5-1=220.96

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:**

Ус дахин боловсруулах үйлдвэр;

**6. Үйлдвэрийн техник, технологи: /ажиллах горим, хүчин чадал/**

Барилгын суурийн усыг 2023 оны 4-р сараас 11-р сарын хугацаанд нийт 5 барилгын суурийн ажлыг хийж гүйцэтгэх үед нэг насосны бүтээмж нь 40 м<sup>3</sup> /цаг бүхий нийт 38 цооногоос усыг 4 үе шаттайгаар хөрсний усыг 24 цаг шавхан зайлуулахаар төлөвлөсөн байна.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ**

-

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/**

-

**9. Усны барилга байгууламжууд: /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/**

Шүүрлийн усыг шавхаж төв цэвэрлэх байгууламжийн гаргалгааны сувгаар дамжуулан Туул голд нийлүүлнэ. Барилгын суурийн нүхнээс 40-80 м<sup>3</sup>/ц хүчин чадалтай насосоор 150 мм голчтой НДР хоолойгоор, 500 м зайд Туул голд нийлүүлнэ.

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур/насосны хүчин чадал, марк/**

-

**11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг "Эко Трейд" ХХК 2021 онд гүйцэтгэсэн.

**12. Онцгой нөхцөл:**

Шавхалт хийсэн усыг Туул голд нийлүүлэх явцад нийслэл Улаанбаатар хотын Геодези, Усны барилга байгууламж ОНӨААТҮГ-г мэдэгдэх.

**13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:** Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход шавхан зайлуулахад:

Д/д	Тооцооллын нэрс	Хугацаа							
		2023.04.10- 2023.04.30	2023.05.01- 2023.05.31	2023.06.01- 2023.06.30	2023.07.01- 2023.07.31	2023.08.01- 2023.08.31	2023.09.01- 2023.09.30	2023.10.01- 2023.10.31	2023.11.01- 2023.11.30
1	Насос ажиллахаар төлөвлөсөн хугацаа (хоног)	20	30	31	31	31	30	31	30
2	Төлөвлөгдсөн хугацаанд зэрэг ажиллах насосны тоо (ширхэг)	7	9	9	12	10	5	5	5
3	Нэг насосны бүтээмж (м3/цаг)	40	40	40	40	40	40	40	40
4	Нэг цагт зайлуулагдах хөрсний усны зарцуулалт (м3/цаг)	280	360	360	480	400	200	200	200
5	Нэг хоногт зайлуулагдах хөрсний усны зарцуулалтын хамгийн их утга (м3/хон)	6720	8640	8640	11520	9600	4800	4800	4800
6	Төлөвлөгдсөн саруудад зайлуулагдах хөрсний усны хамгийн их утга (м3/хон)	134,400	259,200	267,840	357,120	297,600	144,000	148,800	144,000
7	Төлөвлөгдсөн нийт хугацаанд шавхан зайлуулах хөрсний усний хэмжээ (м3/хон)	<b>1,752,960.0 м<sup>3</sup> Нийт шавхалт хийх усны хэмжээ</b>							

**14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:**

Шавхан зайлуулах 1,752,960.0 м<sup>3</sup> газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Усны нөөц шавхан зайлуулсны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9440 \text{ төг} \times 0.15 \times 0.7 = 991.2 \text{ төг}$$

9440 төг – Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

(15%) – 326-р тогтоолын 7в-д заасан усыг шавхан зайлуулахад газрын доорх ус ашигласныг тооцох хувь, хэмжээ;

0.7– Туул голын сав газарт ус шавхан зайлуулахад тооцох итгэлцүүр;

$$1,752,960.0 \text{ м}^3 \times 991.2 \text{ төг} = 1,737,533,952.0 \text{ төг}$$

**Нийт төлбөр: 1,737,533,952.0 төг**

*/Нэг тэрбум долоон зуун гучин долоон сая таван зуун гучин гурван мянга есөн зуун тавин хоёр төгрөг/*

**15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:**

-

**16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:**

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглуулах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу ус ашиглах гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;

- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.3.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийх, эргэн ажиллах үед сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт [office@water.gov.mn](mailto:office@water.gov.mn) хаягаар цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;
- Усны тухай хуулийн 28.6, 28.11 дэх хэсгүүдэд заасны дагуу М Си Эс Проперти ХХК-д ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах гэрээ байгуулахдаа АНУ-ын Мянганы сорилтын корпораци болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулагдсан Компакт гэрээний 2.8 дахь хэсэгт заасныг баримтлан ажиллахад анхаарч ажиллах.

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Р. Мансжав* Х.МЯГМАРЖАВ





ТУУЛ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Ус шавхан зайлуулах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, "Усны газар"-ын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/208 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 09 тоот "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

НЭГ. Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20 хороо, Төв цэвэрлэх байгууламжийн баруун талд байрлах "Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх" төслийн барилга угсралтын суурийн ухлагаас 1'752'960.0 м<sup>3</sup> усыг 2023 оны 04 дүгээр сараас 2023 оны 11 дүгээр сарыг дуустал шавхан зайлуулахыг зөвшөөрсүгэй.

ХОЁР. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах алба /П.Энхбаяр/, Туул голын сав газрын захиргааны менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Жаргал/ нарт үүрэг болгосугай.

ГУРАВ. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, ус ашиглалтын тайланг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг "М Си Эс Проперти" ХХК /О.Батзориг/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ

БАТЛАВ  
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
  
Д.НЯМДОРЖ  
2023 оны 05 дугаар сарын 25  
УЖА0053

"М-СИ-ЭС БАТЛАВ И" ХХК  
"М СИ ЭС ПРОПЕРТИ" ХХК-ИЙН  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  
  
О.БАТЗОРИГ  
2023 оны 05 дугаар сарын 25  
ТТА1619-д: 5040153

БАРИЛГЫН СУУРИЙН УС ШАВХАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ №1

Дугаар УНТ 23/06-01

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

АНУ-ын Мянганы сорилтын корпораци болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулагдсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний 2.8 дахь хэсэг, Монгол улсын Сангийн яамны 2023 оны 05-р сарын 12-ны 05/3184 дугаартай албан бичиг, "Усны газар"-ын 2023 оны 05-р сарын 15-ны өдрийн 01/539 дугаартай "Тодруулга өгөх тухай албан бичиг"-үүдийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж "М Си Эс Проперти" ХХК-ийн Хууль нийцэл хариуцсан захирал Э.Уянга нар Талуудын 2023 оны 03-р сарын 09-ний өдөр байгуулсан Барилгын суурийн ус шавхан зайлуулах гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Нэмэлт өөрчлөлт

2.1. 2023 оны 03-р сарын 09-ний өдөр байгуулсан Барилгын суурийн ус шавхан зайлуулах гэрээний 2.7.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

2.7.1 "Усны нөөцийг шавхан зайлуулсны төлбөр нь 1'737'533'952.0 /нэг тэрбум долоон зуун гучин долоон сая таван зуун гучин гурван мянга есөн зуун тавин хоёр/ төгрөг байх ба АНУ-ын Мянганы сорилтын корпораци болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулагдсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний 2.8 дахь хэсэгт заасны дагуу тус төлбөрөөс "М Си Эс Проперти" ХХК-ийг чөлөөлж байгаа болно. Энэхүү төлбөрийн чөлөөлөлт нь гэрээний 2.7.3-т заасан төлбөрт нэгэн адил хамаарна."

Гурав. Бусад


3.1. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр өөрчилснөөс бусад Барилгын суурийн ус шавхан зайлуулах гэрээний заалтууд хүчин төгөлдөр хэвээр байна.

3.2. Талууд энэхүү нэмэлт өөрчлөлтийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Туул голын сав газрын захиргааны менежер

  
...../Д.ЖАРГАЛ/

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"М Си Эс Проперти" ХХК-ийн Хууль нийцэл хариуцсан захирал

  
...../Э.УЯНГА/

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны дарга

...../П.ЭНХБАЯР/

Усны үнэ тариф, төлбөрийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

...../Н.БОЛОР-ЭРДЭНЭ/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р  
хороо, Чингүнжавын гудамж, Туул голын  
сав газрын захиргааны байр, 203 тоот  
өрөө

Харилцах утас: (976) 70003716  
(976) 70003714

Хаяг: Улаанбаатар хот 14200,  
Сүхбаатар дүүрэг-8, Сүхбаатарын  
талбай, Сентрал тауэр 16 давхар

Харилцах утас: (976) 70700065  
(976) 89008183

**ХАВСРАЛТ 15. ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ҮЕД ҮҮССЭН УХЛАГЫН  
ШОРООГ ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ**





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Нийслэлийн Засаг захиргааны III байр,  
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0011  
Утас: (976-11) 32 37 80, Факс: (976-11) 31 80 03  
Цахим шуудан: admin@environment.ub.gov.mn  
Цахим хуудас: www.environment.ub.gov.mn

2023 05 11 № 02/1112  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**"М СИ ЭС ПРОПЕРТИ" ХХК-Д**

Танай компаниас ус дахин боловсруулах үйлдвэрийн барилгын суурь бэлтгэхэд ухаж гарсан хөрс, чулуулгийг хэрхэн шийдвэрлэх талаар ирүүлсэн хүсэлттэй танилцлаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас баталсан "Хаягдал ус дахин боловсруулах төсөл"-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу барилгын суурийн ухмалын ажлыг хэрэгжүүлэхдээ газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллана уу.

ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Р.ЭНХТАЙВАН



1150390521

## ХАВСРАЛТ 16. ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ





ЭМ СИ ЭС ПРОПЕРТИ ХХК-Д

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

Тоосгоны гудамж, 6 дугаар хороо,  
Сонгинохайрхан дүүрэг,  
Улаанбаатар хот, 18060 0010  
Утас/Факс: (976) 7017 4405  
Цахим шуудан: shdxxvx@gmail.com  
Цахим хуудас: www.halamj.ub.gov.mn

2023. 06. 08 № 797  
танай 2023. 06. 02 -ны № 236 -т

**Хариу хүргүүлэх тухай**

Танай компаниас ирүүлсэн химийн бодисын агуулахад дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг хүлээн авч танилцлаа.

Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотой хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт чиг үүргийнхээ дагуу тус хэлтэст харьяалагдаж ирсэн. Одоогоор химийн бодисын агуулахад хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь дүгнэлт гаргах талаар шийдвэр гараагүй байна.

Иймд Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хүрээнд барилга угсралтын ажилд ашиглагдах бараа материал, химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад дотоод хяналтаа хэрэгжүүлж ажиллана уу.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЭНХТУУЛ

9180930440

**ХАВСРАЛТ 17. СХД-ИЙН 20-Р ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**



<b>Хурлын сэдэв</b>	Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны иргэдийн нийтийн хурал	
<b>Байршил</b>	Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны байр	
<b>Өдөр &amp; Цаг</b>	2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00 цагаас 17:00 цагийн хооронд явагдав.	
<b>Хуралд оролцогчид</b>	<ul style="list-style-type: none"> <li>- СХД-ийн 55 өрхийн төлөөлөл</li> <li>- РМС: Б.Одонтуяа (Байгаль орчны мэргэжилтэн)</li> <li>- МССП: М.Хулан (Байгаль орчны ажилтан)</li> <li>- МССП: А.Булган (Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан багийн ахлах)</li> <li>- МССП: Г.Амгаланзаяа (Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан ажилтан)</li> <li>- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ</li> </ul>	
<b>Хурлыг зохион байгуулсан</b>	УДБҮ-ийн төслийн гүйцэтгэгч "М-Си-Эс Проперти" – МССП Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ	<b>Хурлын тэмдэглэл хөтөлсөн</b> "М-Си-Эс Проперти" – МССП Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ
<b>Хурлын тэмдэглэлийг оролцогч талуудад тараах</b>	"М-Си-Эс Проперти" - МССП	
<b>Хурлын зорилго</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талаарх товч танилцуулга хүргэх</li> <li>• Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулахтай холбоотой 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах</li> <li>• Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн нийгэм, жендэрийн оролцоог хангах үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл хүргэх болон 2023 онд хэрэгжүүлсэн нийгэм жендэрийн оролцоог хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах</li> </ul>	

## ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

<b>1-р хэсэг: МССП: УДБҮ төслийн танилцуулга 14:00-14:10</b>		
1.	УДБҮ-ийн төслийн танилцуулга болон барилгын ажлын явцын талаарх мэдээлэл	10 мин
<b>2-р хэсэг: МССП: БО, НЖОХ багийн танилцуулга 14:10-14:40</b>		
1.	<b>Байгаль орчны ажилтан М. Хулан</b> <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчныг хамгаалах хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ерөнхий тойм</li> <li>- 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны танилцуулга</li> </ul>	15 мин
2.	<b>Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан багийн ахлах А. Булган</b> <b>Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан ажилтан Г. Амгаланзаяа</b> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгэм, жендэрийн оролцоог хангах үйл ажиллагааны зорилго</li> <li>- 2023 онд хэрэгжүүлсэн нийгэм жендэрийн оролцоог хангах үйл ажиллагааны танилцуулга</li> </ul>	15 мин
<b>3-р хэсэг: ХЭҮТ: "МЭДЬЕ, МЭДСЭНЭЭ ТҮГЭЭЕ!" нээлттэй өдөрлөг 14:40-17:00</b>		



1	<b>Нээлтийн үйл ажиллагаа</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ийн танилцуулга</li> <li>- Гэрээт ажлын танилцуулга / сургалтын зорилго</li> <li>- Даван туулагчын урлагын үзүүлбэр</li> </ul>	10 мин
2	<b>Жендэрт суурилсан хүчирхийллийн төрөл: Ажлын байрны бэлгийн дарамтын сургалт</b> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх суурь мэдлэг олгох түүнээс урьдчилан сэргийлэх</li> <li>- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх</li> </ul>	80 мин
3	<b>Оролцогчдыг идэвхижүүлэх</b> <ul style="list-style-type: none"> <li>- Даван туулагчын урлагын үзүүлбэр</li> <li>- Дасгал ажил</li> </ul>	10 мин
4	<b>Хүүхдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх</li> <li>- Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд</li> </ul>	40 мин
5	<b>Цогц үйлчилгээ</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн зөвлөгөө</li> <li>- Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө</li> <li>- Эмчийн үзлэг, зөвлөгөө</li> </ul>	60 мин

## ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№	Item	Хэлэлцсэн нь
1	Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн талаарх товч танилцуулга	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК-ийн нийгэм, жендерийн оролцоо хариуцсан багийн ахлах А.Булган хурлыг эхлүүлж, төслийн гүйцэтгэгч компанийн талаар ерөнхий мэдээлэл өгөв.</li> <li>- Төслийн гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК-ийн байгаль орчны ажилтан М.Хулан нь төслийн товч танилцуулгын хүрээнд төслийн санхүүжүүлэгч, төслийн зорилго, хүчин чадал, төслийн хэрэгжих хугацаа болон байршлын талаар мэдээлэл өгч, төслийн танилцуулга бичлэгийг үзүүлэв. Мөн 2023 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хоорондох тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төслийн үе шатны хэрэгжилтийг танилцуулав.</li> </ul>
2	Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн байгаль орчныг хамгаалах хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ерөнхий тойм	Төслийн гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК-ийн байгаль орчны ажилтан М.Хулан нь төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудыг тоймлон мэдээлэл өгөв.





3	<p>Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тайлан</p>	<p>Төслийн гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК-ийн байгаль орчны ажилтан М.Хулан нь тайлант хугацаа болох 2023 оны 1 дүгээр сараас 2023 оны 9 дүгээр сар хүртэлх хугацааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлуудын талаар дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчны холбогдох хуулийн болон захиалагчийн шаардлагыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт</li> <li>- Төслийн нийт ажиллагчдад байгаль орчны мэдлэг олгох ажлын хэрэгжилт</li> <li>- Төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн талаар мэдээлэл болон хэрэгжилт</li> <li>- Төслийн хог хаягдлын менежментийн талаарх мэдээлэл болон хэрэгжилт</li> <li>- Төслийн усны менежментийн талаарх мэдээлэл болон хэрэгжилт</li> <li>- Төслийн химийн бодисын менежментийн талаарх мэдээлэл болон хэрэгжилт</li> </ul>
4	<p>Ус дахин боловсруулах үйлдвэрийн төслийн нийгэм, жендерийн оролцооны үйл ажиллагааны танилцуулга</p>	<p>Төслийн гүйцэтгэгч М-Си-Эс Проперти ХХК-ийн нийгэм, жендерийн оролцоо хариуцсан багийн ахлах А.Булган нь төсөл хэрэгжих хугацаанд нийгэм, жендерийн оролцоог хангах үйл ажиллагааны зорилгууд болон хэрхэн хангаж ажиллах, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудын талаарх мэдээллийг дараах агуулгын хүрээнд хүргэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын биелэлт, тоон мэдээлэл, барилгын салбарт эмэгтэйчүүд эрхэлж болох ажлын байрны мэдээлэл</li> <li>- Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын биелэлт, тоон мэдээлэл</li> <li>- Боловсролын коллеж болон их дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын биелэлт</li> <li>- Орон нутгийн болон эмэгтэй эзэмшигчтэй ЖДҮ дэмжих ажлын биелэлт тоон мэдээлэл</li> <li>- Нийгэм жендерийн эрсдэлийг тодорхойлох, нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлууд</li> <li>- Нийгэм, жендерийн зөрчил гомдлыг мэдээлэх, хүлээж авах, шийдвэрлэх хариу арга хэмжээний талаарх мэдээлэл</li> <li>- Нээлттэй ажлыг байр болон анкет илгээх холбоос мэдээлэл</li> </ul> <p>Тус уулзалтын үер төслийн талбайд эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх таатай орчинг хэрхэн бүрдүүлж буй мөн хүйсээр ялгаварлан гадуурхах, дарамт хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй нөлөөллийн арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн.</p> <p>Мөн, УДБҮ-ийн төслийн хүрээнд нээлттэй байгаа ажлын байрны зарыг түгээж, хэвлэмэл хэлбэрээр хорооны байрны зарын самбарт байршуулсан ба ажлын байрны анкетыг хэвлэмэл хэлбэрээр иргэдийн нийтийн хуралд оролцсон иргэдэд тараасан.</p>
5	<p>Хүчирхийллийн эсрэг төв ТББ- "МЭДЬЕ, МЭДСЭНЭЭ ТҮГЭЭЕ!" нээлттэй өдөрлөг</p>	<p>"М Си Эс Проперти" ХХК-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах төслийн хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ нь гэрээт ажлын нэг хэсэг болох орон нутгийн иргэд, зорилтот бүлэгт чиглэсэн Жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байран дах бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нээлттэй өдөрлөгийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү сургалтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жендэрт суурилсан хүчирхийллийн төрөл: Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх</li> <li>- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх үүднээс хорооны нийгмийн ажилтантай урьдчилан зөвшилцсний дагуу хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаарх ойлголт, урьдчилан сэргийлэх, мэдээлэх чадавхийг дээшлүүлэх ажлын хүрээнд танилцуулга</li> <li>- мэдээллийн хуудас, хүүхдийн эрхийн карт бусад мэдээллийг тарааж, дархлаа дэмжих эрүүл мэндийн багц, ном, бичиг хэргийн зүйлсээр дэмжлэг үзүүлэн тарааж</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэшсэн хуульч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч гэсэн багаар очиж, зөлөгөө мэдээлэл өгч ажиллав.</li> </ul> <p>Нээлттэй өдөрлөгөөр ганцаарчилсан зөвлөгөө, үйлчилгээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ганцаарчилсан хуулийн зөвлөгөө - 21 иргэн</li> <li>- Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө – 10 иргэн</li> <li>- Эрүүл мэндийн үйлчилгээ – 15 иргэн</li> <li>- Холбон зуучлах үйлчилгээ – 3 иргэн</li> </ul> <p>Зөвлөгөө, үйлчилгээнд хамрагдсан иргэд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ГБХТхууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Хүүхэд хамгааллын хуулийн талаар мэдээлэлтэй болж, эрхээ хамгаалуулах, үйлчилгээ авах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх ойлголт, мэдлэгтэй болсон.</li> <li>- Өөрт тулгамдаж буй гэр бүлийн болон бусад асуудлын талаар ганцаарчилсан зөвлөгөө авч, шийдвэрлэх гарцаа тодорхойлсон.</li> <li>- Хорооны хамтарсан багаас үйлчилгээ авах ойлголт нэмэгдэж, тусламж, үйлчилгээ авах гарцаа олсон.</li> <li>- Шаардлагатай байгаа үйлчилгээндээ холбон зуучлуулсан.</li> </ul>
--	--	--

Бэлтгэсэн: М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

x  \_\_\_\_\_  
  
 Гарын үсэг, он сар өдөр  
**Ц. Тува**

СХД-ийн 20-р хорооны ИНХ-ын Дарга

x  \_\_\_\_\_  
 Гарын үсэг, он сар өдөр

**О.БАТЗОРИГ**

Төслийн Менежер